

Лиакона

Санваар
сэргээгдсэн
алдар суут
өдөр, х.24

Гэр орондоо
Аврагчийн тухай
заах арга замууд,
х.10

Их Эзэнээр
удирдуулсан нь:
Иосефийн Палмирад
хүрэх зам, х.14

Илүү сайн шавь болох
нь: Лукийн номоос авах
сургамжууд, х.28





“Хүүгээ талх гуйхад
чулуу өгдөг хүн
та нарын дунд
байна уу?”

“Эсвэл, загас гуйхад
нь түүнд могой
өгөхгүй биз дээ?”

“Хэрэв тэгээд та
нар, хилэнцэт
байж, хүүхдүүддээ
хэрхэн сайн бэлэг
өгөхийг мэддэг
бол, тэнгэр дэх Эцэг
тань түүнээс гуйсан
тэдэнд сайн зүйлийг
хичнээн ихээр өгөх
билээ?”

Матай 7:9–11



ЗАХИАСУУД

- 4 Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Гэр бүлүүд үүрд мөнх хамт байж чадна**
Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг
- 7 Айлчлагч багшийн захиас бичиг: Есүс Христийн тэнгэрлэг зан чанарууд-Ариун журам**

ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

- 10 Гэр орондоо “Христийн тухай номлох” бидний арга зам**
Дэррен Э.Шмидт
Христэд илүү их төвлөрсөн гэр бүлийг бий болгох санаанууд
- 14 Палмирад хүрэх зам**
Мэттью С.Холланд
Анхны үзэгдэл болсон, алтан ялтсууд булаастай байсан газар—Палмирад хүрэх зам Иосеф Смитийн болон түүний гэр бүлийн хувьд амар байгаагүй юм.

- 20 Авралыг эрэлхийлэх нь**
Конни Голдинг
Хэрэв та зовлон бэрхшээл, сул дорой байдлуудаасаа, эсвэл хүнд хэцүү нөхцөл байдлаас болж мухардсан бол аврагдах найдвар байгаа.

- 24 Санваар сэргээгдсэн алдар суут өдөр**
Ахлагч Л.Том Пэрри
Их Эзэн Өөрийн Сүм болон Өөрийн санваарыг дэлхий дээр сэргээсэнд бид талархах ёстой.

- 28 Шавь байх талаар Аврагчийн заасан зүйлс**
Кэйси В.Олсон
Христийн Иерусалим руу хийсэн сүүлчийн аяллын энэ дөрвөн үйл явдал нь бидэнд хэрхэн илүү сайн дагалдагчид болохыг заадаг.

- 34 Хүмүүсийн загасчид**
Ахлагч Скотт Д.Вайтинг
Зөв зүйтэй ажилласан тойргийн зөвлөл тойргоо огт өөр болгосон юм.

АЛБАД

- 8 Сүмд үйлчлэх нь: Хайрын талаар миний сурсан зүйл**
Жанис Тэйт
- 9 Эргэцүүллүүд: Соно бялзуухайг аварсан нь**
Виллиам Хогган
- 38 Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой**
- 80 Биднийг дахин уулзтал: Үүнийгээ орхи**
Ерөнхийлөгч Боид К.Пакэр

ХАВТСАН ДЭЭР

Нүүрэн талд: Гэрэл зургийг Лэсли Нилссон. Нүүрний дотор талын гэрэл зургийг Ridvan Çelik/iStock/Thinkstock. Арын хавтасны дотор талын гэрэл зургийг Cody Bell.

46



42 Их Эзэний баталгаанд итгэхүй

Минди Энн Лэвитт

Их Эзэн биднийг тэр даруй чөлөөлөхийн оронд зовлон бэрхшээлүүд дотор маань үнэлж баршгүй баталгаагаар адисалж болно.

46 Солилцоогоор явахгүй

Лена Син Яао Чо

Би энэ газарт дахин зургаан долоо хоног ажиллахаар томилогдсоноо сонсоод, чихэндээ ч итгэж чадахгүй байв.



Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой.

Санамж: Чи машинаас өөр юу жолоодож чадах вэ?

48 Хурдан хэмнэлтэй дэлхийд амьдрах нь
Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф
Энэ дөрвөн харилцаан дээр анхаарлаа төвлөрүүлж, амьдралаа энгийн болго.

52 Бидний орон зай

54 Иохан Баптисттай адил сайн мэдээг хуваалцах нь
Рян Карр

56 Хэрвээ . . . тэгвэл яах вэ?
Номлолд үйлчлэх талаар асуудаг асуултууд

60 Асуулт, хариултууд

Нэг найз маань ямар нэг муу зүйлийг ердөө ганцхан удаа хийж үзэхийг хүсээж байна. Хүмүүсийг энэ тухай ярих үед тэр үүнийг хийж үзсэн байх хүсэлтэй байгаа гэнэ. Энэ нь сайхан санаа биш гэдгийг ойлгоход нь би түүнд хэрхэн тусалж чадах вэ?

62 Судар судлах нь зураг эвлүүлдэг тоглоомтой адил юм.
Коди Филлипс

65 Сайн мэдээн дэх эгч дүүс
Паола Сарахи Хернандес Крүз
Найз нь ганцаардаж байсан учраас Паола сайн мэдээний адислалуудыг түүнтэй хуваалцахыг хүссэн юм.



72

66 Онцгой гэрч: Би хэрхэн Ариун Сүнсээр удирдуулж чадах вэ?
Ахлагч Л.Том Пэрри

67 Дуу хөгжим: Ариун Сүнс
Үг, аяыг Жийн П.Лаулер

68 Судрын цаг: Сайн Хоньчин
Эрин Сандэрсон

70 Бидний хуудас

71 Шинэ Гэрээний судрын хүмүүс: Сайн Хоньчин

72 Стивэний тэмдэглэсэн анхны ирээдүйн аавуудын баяр
Кэлли Жорж Пурчил
Аавуудын баярын өдрөөр Стивэнийг гуниглахгүй байхад туслах санаа ээжид нь төржээ.

74 Миагийн гэрчлэл
Амелиа Хоокинс
Миа гэрчлэлтэй болохыг хүссэн ч, хэрхэн гэрчлэлтэй болох билээ?

76 Бага насны хүүхдүүдэд зориулав: Аравны нэгээр баригдсан өргөө
Жэнил Виллиамс

48

2015 ОНЫ ЗУРГААДУГААР САРЫН ДУГААР, 16, №3 ЛИАХОНА 12566 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хэнри Б.Айринг,
Дийтр Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн чуулга: Боид К.Пакэр,
Л.Том Пэрри, Рассэлл М.Нэлсон, Даллин Х.Өүкс,
М.Рассэлл Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хэйлс,
Жэффри Р.Холланд, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Кук,
Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн

Эрхлэгч: Крэйг А.Кардон

Зөвлөхүүд: Мэрвин Б.Арнолд, Кристоффэл Гоулдэн,
Ларри Р.Лоурэнс, Жэймс Б.Мартино, Иосеф В.Ситати

Удирдах захирал: Дэвид Т.Варнэр

Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал:
Винсент А.Ваун

Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр

Хэвлэлийн туслах: Лиза Кэролин Лопэз

Редакцийн баг: Бриттани Бийти, Дэвид Диксон,
Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Лори Фүллэр,
Гаррэт Х.Гарфф, Ларин Портэр Гаунт, Минди Аннэ
Лийвигт, Майкл Р.Моррис, Салли Жонсон Одэкөрк,
Жошуа Ж.Пэркий, Жан Пинбороу, Ричард М.Ромни,
Пол Вандэнбэрг, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер:

Ж.Скотт Кнудсэн

Зураглал чимэглэлийн удирдагч: Тэдд Р.Петрсон

Уран бүтээлийн ажилтнууд: Жанэтт Эндрьюс, Фэй
П.Андрус, Мэндэл М.Бэнгли, С.Кимбалл Ботт, Том Чайлд,
Нэйт Гайнс, Коллийн Хинкли, Эрик П.Жонсэн, Сюзан
Лодфрэн, Скотт М.Моой, Марк В.Робисон, Брад Тизери,
П.Никол Вокэнорст

Оюуны өмчийн зохицуулагч: Коллэт Нэбэкэр Аун

Хэвлэлийн захирал: Жэйни Анн Пэтэрс

Хэвлэх баг: Конни Вауторп Бриж, Жоли Бардэтт, Кэти
Данкан, Брайн В.Гайги, Дэнис Көрби, Жинни Ж.Нилсон,
Гэйл Тэйт Раффэрти

Хэвлэлийн захирал: Крэйг К.Сэдвик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсэн, Нэгдсэн
Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга болон үнийн
талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог,
салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт
liahona.lds.org pyu; шуудангаар Liahona, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA
хаяагаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаяагаар
ирүүлнэ үү.

Лиэхона нь (Мормоны Номон дахь утгаараа бол “луужин”
буюу “залагч”) албани, англи, армен, бислам, болгар,
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани,
итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл,
монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын,
свахили, самоа, себуано, солонгос, тагало, тай, тахити,
тонга, украин, унгар, урду, фижи, фин, франц, хорват,
хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр
нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр
байна.)

© 2015 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиэхона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувиран олшруулж
болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual
Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150, USA хаяагаар; эсвэл электрон шуудангийн:
cor-intellectualproperty@ldschurch.org хаяагаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:

June 2015 Vol. 16 No. 4. LIAHONA (USPS 311-480) Mongolian
(ISSN 1525-7584) is published six times a year (January, April,
June, July, October, and December) by The Church of Jesus
Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150. USA subscription price is \$5.00 per year; Canada,
\$6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake
City, Utah. Sixty days' notice required for change of address.
Include address label from a recent issue; old and new address
must be included. Send USA and Canadian subscriptions to Salt
Lake Distribution Center at address below. Subscription help
line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard,
American Express) may be taken by phone. (Canada Poste
Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 707.4.12.5).
NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes
to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368, USA.

Гэр бүлийн үдшийн санаанууд

Энэ дугаарт гэр бүлийн үдшээр ашиглаж болох өгүүлэл, үйл ажиллагаануудыг
оруулсан. Доор хоёр жишээ өгөгдсөн болно.



“Санваар сэргээгдсэн алдар суут

өдөр,” 24-р хуудас: Адамаас эхлээд
Хуучин Гэрээний бошиглогчид хүртэл,
цаашлаад Есүс Христ ба Түүний төлөө-
лөгчдөөс Иосеф Смит хүртэл санваар
хэрхэн дамжиж ирснийг нэг хүнээс нөгөө
рүү нь зураас татаж, тайлбарлах талаар
бодож үзээрэй. Иохан Баптист Аароны
санваарыг Иосеф Смит, Оливер Каудери
хоёрт хүртээж байхдаа хэлсэн үг Сургаал
ба Гэрээ 13:1-д цэдэглэгдсэн байдаг бөг-
өөд та үүнийг чээжилж, энэ үйл явдлын
ач холбогдлын талаар ярилцаж болно.

“Миагийн гэрчлэл,” 74-р хуудас: Та

энэ өгүүлийг хамт уншсанахаа дараа
“хэрхэн” гэрчлэлтэй болох тухай ярил-
цаж болно. Тухайлбал: залбирах, судар
унших, бошиглогч, төлөөлөгчдийг болон
бусдын гэрчлэлийг сонсох, гэрчлэлээ
хуваалцах гэх мэт. Гэрчлэл гэрэлтэй хэр-
хэн адилхан байж болох талаар ярилц.
Дараа нь эцэг, эхчүүд гэрчлэлээ хуваал-
цаж, мөн хүсвэл гэрчлэл эсвэл төрсөн
мэдрэмжээ хуваалцахад хүүхдүүдээ
урьж болно.

ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиэхона болон Сүмийн бусад материалыг олон хэлээр languages.lds.org хаяагаар
орж үзэж болно.

ЭНЭ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллтийн эхний хуудсыг заана.

Аврах, 9, 20

Ажил эрхлэлт, 39, 52

Амь биеэ зориулах, 28

Аравны нэг, 76

Ариун Сүнс, 62, 66, 67, 74

Ариун журам, 7

**Ариун сүмийн ажил, 4,
6, 70**

Баптисм, 65, 70

Гэр бүл, 4, 10, 48, 72

Гэр бүлийн түүх, 4

Гэрчлэл, 56, 74

Дуу хөгжим, 8, 53, 67

**Есүс Христ, 7, 10, 20, 28,
42, 48, 54, 66**

Заасан зүйл, 10

Залбирал, 10, 74

**Идэвх султай гишүүдийг
идэвхжүүлэх нь, 9**

Иосеф Смит, 14

Мормоны Ном, 10

Найдвар, 42

Наманчлал, 56

Номлогчийн ажил, 54, 65

**Номлолууд, 40, 42, 46,
54, 56**

Өршөөл, 80

Санваар, 4, 24

Сорилтууд, 20, 42, 52

Судрууд, 62, 68, 71

Сэргээлт, 14, 24

Тойргийн зөвлөлүүд, 34

Тохинуулах нь, 9, 28, 34

Тэвчээр, 38

Тэнгэрлэг Эцэг, 48

Удирдлага, 34, 46, 80

Үйлчлэл, 8, 24, 34, 41, 48

Хайр, 8, 40

Хоёр дахь ирэлт, 54

Цагаатгал, 20, 42

Шавь байх нь, 28

Эцгүүд, 72



Ерөнхийлөгч
Хэнри
Б.Айринг

Тэргүүн Зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх

ГЭР БҮЛҮҮД МӨНХӨД ХАМТ БАЙЖ ЧАДНА

Гэр бүлүүдийг үүрд мөнх холбох санваарын хүч нь Бурханы хамгийн агуу бэлгүүдийн нэг юм. Авралын төлөвлөгөөг ойлгодог хүн бүр энэ мөнхийн адислалыг авахыг хүсдэг. Бурхан гэр бүлүүд мөнхөд хамт байх болно гэсэн амлалтыг зөвхөн Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн онцгойлон адислагдсан ариун сүмүүдэд гүйцэтгэгддэг лацдан холбох ёслолоор дамжуулан өгдөг.

Үүнийг боломжтой болгодог санваарын түлхүүр нь Көртландын ариун сүмд бошиглогч Елиагаар дамжуулан Иосеф Смитэд сэргээгдсэн юм. Эдгээр санваарын түлхүүр нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм дэх амьд бошиглогчдын тасралтгүй холбоогоор дамжин энэ цаг үед ирсэн билээ.

Аврагч мөнх бус тохинууллынхаа үед Өөрийн ахлах төлөөлөгч Петрт “Чи газар дээр юуг холбоно, тэр нь тэнгэрт холбогдоно. Газар дээр юуг тайлна, тэр нь тэнгэрт тайлагдах болно” (Матай 16:19) хэмээн хэлэх үедээ гэр бүлүүдийг лацдан холбох хүчний тухай түүнд ярьжээ.

Бид гэр бүлээрээ үүрд мөнх хамт амьдарч чадах газар бол зөвхөн селестииел хаант улс юм. Бид тэнд Тэнгэрлэг Эцэгийнхээ болон Аврагчийн оршихуйд гэр бүлээрээ хамтдаа байж чадна. Бошиглогч Иосеф Смит энэ гайхалтай үйл явдлыг Сургаал ба Гэрээнд дараах байдлаар дүрсэлсэн юм:

“Аврагчийг залран ирэхэд бид түүнийг байгаагаар нь харах болно. Тэрээр бидэнтэй адилхан хүн гэдгийг бид харах болно.

“Энд бидний дунд байгаа тэрхүү харилцаа тэнд бидний дунд байх болно, гагцхүү энэ нь эдүгээ бидний эдэлдэггүй тийм алдар суу болох мөнхийн алдар суугаар хоёр дахин ихсэх болно” (С ба Г 130:1–2).

Бид гэр бүл дэх харилцаагаа тэнгэрлэг жишигт хүргэхээр итгэлтэйгээр хичээж болно гэдгийг энэ судар харуулдаг. Бид амьд болон нас барсан гэр бүлийн гишүүдийнхээ төлөө санаа тавьж, биднийг тэнгэрт холбох санваарын ёслолуудыг тэдэнд хүртээхийн тулд чадах бүхнээ хийж чадна.

Хөгшин, залуу олон хүн үүнийг хийж байна. Та нар лацдан холбогдож амжаагүй байгаа өвөг дээдсийнхээ нэрсийг хайж байгаа.

Санваарын хүчээр гэр бүлтэйгээ лацдан холбогдоогүй, амьд байгаа хамаатан садангууд бараг хүн бүрд байдаг. Санваарын ёслолуудыг хүлээн авсан боловч Бурхантай хийсэн гэрээгээ сахидаггүй хамаатнууд ч олон бий. Бурхан итгэлээрээ эдгээр хамаатан садандаа хүрч туслах чадвараар та нарыг адислах болно. Бусдыг Өөрт нь авчирдаг дагалдагчдадаа өгдөг Их Эзэний амлалт та нарт ч бас хамаатай юм:

“Мөн та нарыг хэн ч хүлээн авлаа гэсэн, тэнд би тэрчлэн байх болно, учир нь би та нарын нүүрний өмнө явах болно. Би та нарын баруун гар талд мөн та нарын зүүнтээ байх болно, мөн миний Сүнс та нарын зүрх сэтгэлд, мөн миний тэнгэр элчүүд та нарыг дэмжихийн тулд та нарын эргэн тойронд байх болно” (С ба Г 84:88).

Би өдөр бүр ажлын өрөөний цонхоороо үзэсгэлэнт цэцэгсийн дунд, дээш цацрах усан оргилуурын дэргэд



зургаа авахуулж буй шинэхэн гэрлэсэн хосуудыг хардаг. Ихэнх тохиолдолд зурагчин хуримын зургийг авахдаа, сүйт залуу нь бүсгүйгээ бүх чадлаараа гар дээрээ өргөх тэр хооронд зургийг нь дарж амждаг. Би үүнийг харах болгондоо, гэрлэлтийн дараа удалгүй амьдрал хэцүү болох үед бие биенээ өөр маягаар өргөж явах болсон таньдаг

хосуудаа боддог. Хүн ажлаа алдаж болно. Хүүхдүүд нь хөгжлийн бэрхшээлтэй төрж болно. Өвчин зовлон ч ирж болно. Бид бусдыг өөрсдөө хэрхэн хандаасай гэж хүсдэг шигээ тэдэнд ч мөн тийн хандах нь амархан болж, дадаж хэвшсэн үед, мөн бидний бодсоноос ч илүү хүч шаардсан хэцүү цаг үед энэ хэвшил нь биднийг баатрууд болгодог.

Бид Бурханы оршихуйд хүлээн зөвшөөрөгдөхүйц харилцааг гэр бүлдээ бий болгох үүрэгтэй. Бид бусдыг гомдоохгүйг, эсвэл тэдэнд гомдохгүй байхыг хичээх ёстой. Бид уучлах шийдвэрийг хурдан бөгөөд бүрэн дүүрэн гаргаж чадна. Бид өөрсдийнхөөсөө илүү бусдын аз жаргалыг эрэлхийлэхээр хичээж чадна. Бид хэл яриагаа эелдэг байлгаж чадна. Бид энэ бүхнийг хийхийг хичээснээр, гэр бүлдээ болон амьдралдаа Ариун Сүнснийг урих болно.

Бид Их Эзэний тусламж, наманчлагч зүрх сэтгэлээр дамжуулан үүрд мөнхөд хамт байхыг хүсэж буй гэр бүлээ зэрвэсхэн ч болов, төсөөлөн харж чадна гэдгийг би та нарт батлан хэлж байна. Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай. Тэрээр биднийг Өөртөө эргэж ирээсэй гэж хүсдэг. Аврагч биднийг ариун сүмд орж, гэрээнүүдээ хийж, сахиыхыг, мөн цаг нь ирэхээр селестиел алдар сууд буюу гэртээ гэр бүлээрээ мөнхөд хамт амьдрахын тулд хийвэл зохих бидний зүрх сэтгэлийн өөрчлөлтийг Өөрийн Цагаатгалын хүчээр боломжтой болгосон юм. ■

ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Та мөнхийн гэр бүлийн сургаалыг хуваалцахдаа Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г.Скоттын хэлсэн дараах үгсийг бодож үзээрэй: “Гэр бүлүүдийг хүчирхэгжүүлэхийг үргэлж эрэлхийл. Гэр бүлүүд ариун сүмд лацдан холбогдохын ач холбогдлыг мөнхийн үзэл бодлоор заа. . . . Та ариун сүмийн лацдан холбох ёслолуудыг хийлгэх хүсэлтэй байснаар Бурханы хаант улсыг газар дэлхий дээр байгуулахад туслах болно”

(“Би та нарт жишээ үзүүлсэн юм,” *Лиахона*, 2014 оны 5-р сар, 34). Та заадаг хүмүүстээ ариун сүмд лацдан холбогдохын ач холбогдлыг ойлгох алсын хараатай болоход нь хэрхэн тусалж чадах вэ? Хараахан лацдан холбогдоогүй байгаа хүмүүсийг энэ ёслолыг хүлээн авахын тулд хийж чадах алхмуудаа ярилцахад урь. Лацдан холбогдсон хүмүүсийг мөнхийн гэр бүлийн зорилгоо санаж, бие биетэйгээ харилцах харилцаагаа сайжруулахын тулд хэрхэх талаар ярилцахад урь.

Гэр бүлтэйгээ мөнхөд холбогдлоо

Лора Бертон

Намайг гурван настайдаа үрчлэгдэх үед, төрсөн ээж маань намайг 12 хүрсний дараа л Сүмийн ёслолуудыг хүртэх боломж олгохыг эцэг эхэд маань зөвшөөрчээ. Ээж минь намайг өөрийнхөө төлөө сонголт хийх хангалттай том болсон байх ёстой гэж бодсон байх. Гэхдээ хүлээх нь маш хэцүү байв.

Олон найз маань найман нас хүрээд баптисм хүртэхийг харах амаргүй байсан ч, өргөж авсан эцэг эх, таван ах, эгчтэйгээ 12 нас хүртлээ лацдан холбогдож чадахгүй гэдгийг мэдэх нь бүр ч хэцүү байв. Надад ямар нэгэн зүйл тохиолдож, тэдэнтэйгээ лацдан холбогдож чадахгүй болох вий гэхээс би айж байлаа.

Миний 12 насны төрсөн өдөр ойртох үед гэр бүл маань миний баптисмыг болон лацдан холболтыг төлөвлөж эхэлсэн юм. Эцэг эх маань лацдан холбогдох ариун сүмийг надаар сонгуулав. Би Калифорнийн Сан Диегогийн ариун сүмийг хамгийн үзэсгэлэнтэй нь гэж байнга боддог байсан учраас гэр бүлийнхэн маань

лацдан холбогдохоор Калифорни руу машинаар явахыг бүгд зөвшөөрсөн юм.

Би аав, ээж, ах, эгч нартайгаа мөнхийн гэр бүл болохыг тэсэн ядан хүлээсэн. Лацдан холбогдох үеэр би Сүнсний маш хүчтэй мэдэрсэн бөгөөд үүнийг үгээр дүрслэхэд ч хэцүү юм. Эцэст нь би гэр бүлтэйгээ лацдан холбогдож, тэдэнтэйгээ үүрд мөнх холбогдсоныг мэдсэнээр санаа зовох зүйлгүй болж, тайтгарал ба амар амгаланг мэдрэх болсон билээ.

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.



ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ



Ариун сүм рүү хараагаа чиглүүл

Санваар байгаа учраас бид ариун сүмд орж, гэр бүлээрээ үүрд мөнх лацдан холбогдох боломжтой болсныг ерөнхийлөгч Айринг тайлбарласан. Дуртай ариун сүмийнхээ зургийг зурж, эсвэл олж аваад, өдөр бүр харж болох газарт байрлуул. Хэзээ нэгэн өдөр ариун сүмд ороход бэлтгэхийн тулд хийх зүйлүүдийнхээ жагсаалтыг гарга.

Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдэхийг эрэлхийл. Аврагчийн тэнгэрлэг зан чанаруудыг ойлгох нь Түүнд итгэх итгэлийг тань хэрхэн нэмэгдүүлж, мөн айлчлагч багшийн хувьд харж ханддаг хүмүүсийн тань амьдралыг хэрхэн адисалж болох вэ? Нэмэлт мэдээлэл авах бол reliefsociety.lds.org хаягаар орж үзнэ үү.

Есүс Христийн тэнгэрлэг зан чанарууд: Ариун журам

Энэ бол Аврагчийн тэнгэрлэг зан чанаруудын талаарх Айлчлагч багшийн цуврал захиасуудын нэг хэсэг юм.

“Бодол санааг чинь ариун журам зогсолтгүй чимэн гоёг, тийнхүү итгэлтэй байдал чинь Бурханы оршихуйд хүчтэй болно. Мөн санваарын сургаал тэнгэрээс буух шүүдэр лугаа адил чиний сүнсэн дээр намуухан буух болно (С ба Г 121:45).

Ариун журам гэж юу вэ?

Ерөнхийлөгч Жэймс Э.Фауст (1920–2007): “Ариун журам гэдэг нь бүрэн утгаараа бидний мөн чанарыг бүрдүүлдэг бүх зөв шударга чанарыг өөртөө багтаадаг”¹ хэмээн хэлсэн. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008): “Бурханыг хайрлах хайр бол бүх ариун журам, сайн сайхан, зан байдлын хүч чадлын үндэс юм”² гэжээ.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Д.Тодд Кристоффэрсон эмэгтэйчүүд ба ариун журам хоорондын харилцааны талаар хэлэхдээ: “Эмэгтэйчүүд энэ дэлхийд төрөхдөө тодорхой нэг ариун журам, тэнгэрлэг бэлгийг өөрсөдтэйгөө хамт авчирдаг бөгөөд тэдгээрийн тусламжтайгаар эмэгтэйчүүд итгэл, эр зориг, өрөвч сэтгэл, өсөлт хөгжил зэрэг гайхалтай чанаруудыг хүмүүс хоорондын харилцаанд болон соёл иргэншил дотор маш чадамгай бий болгодог. . .

Үүнийг эргэцүүлэн бод

Ариун журам биднийг хэрхэн дэмжиж, хүчирхэгжүүлдэг вэ?



“Эгч нар аа, та нарын бүх харилцаан дотроос Бурхантай, та нарын Тэнгэрлэг Эцэгтэй харилцах харилцаа буюу та нарын ёс суртахууны хүч чадлын эх сурвалжийг та нар амьдралдаа үргэлж нэгдүгээрт тавих ёстой. Есүс Христийн хүч Эцэгийн хүсэлд өөрийгөө чин сэтгэлээ зориулсны үр дүнд ирсэн гэдгийг санаарай. . . Эцэг болон Хүүгийн ийм маягийн дагалдагч байхыг эрмэлзэж байвал та нарын нөлөө хэзээ ч буурахгүй.”³

Нэмэлт судрууд

Дуулал 24:3–5; Филиппой 4:8; 2 Петр 1:3–5; Алма 31:5; Сургаал ба Гэрээ 38:23–24

ЭШЛЭЛҮҮД

1. Жэймс Э.Фауст, “The Virtues of Righteous Daughters of God,” *Лиакхона*, 2003 оны 5-р сар, 108.
2. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008), “Excerpts from Recent Addresses of President Gordon B. Hinckley,” *Ensign*, 1996 оны 4-р сар, 73.
3. Д. Тодд Кристоффэрсон, “Эмэгтэйчүүдийн ёс суртахууны хүч,” *Лиакхона*, 2013 оны 11-р сар, 31.
4. Ариун журам хүчтэй (Марк 5:30-ийг үзнэ үү).
5. Судруудын удирдамжинд, “Санваар” бол “Хүмүүний авралын тулд Бурханаас хүнд өгдөг бүх зүйлд үйлдэх эрх мэдэл хийгээд хүч” (С ба Г 50:26–27) гэж тодорхойлдог.

Итгэл, гэр бүл, халамж



Судруудаас

Өнөө үед ариун журамт эмэгтэйчүүд бүрэн дүүрэн итгэлтэйгээр Аврагчид ханддаг. Бид Лук 8-д нэгэн эмэгтэй арван хоёр жилийн турш цус алддаг өвчтэй байсан бөгөөд хэн ч түүнийг эдгээж чадаагүй тухай уншдаг. Тэр эмэгтэй эдгэрэхийн тулд “Есүсийн ард очиж, хувцасных нь хормойд гар хүртэл тэр даруй цус алдах нь зогсов. . . Харин Есүс, Хэн нэг нь Надад хүрсэн. Учир нь Надаас хүч гарахыг Би мэдэрсэн”⁴ гэжээ.” Энэ ариун журамт итгэлт эмэгтэй Түүний өмнө унаж, “Түүнд хүрсэн” хийгээд “тэр даруй эдгэрснээ” “бүх хүний өмнө ярилаа. Есүс түүнд, Охин минь, итгэл чинь чамайг эрүүл болголоо. Амар тайван яв даа гэв” (Лук 8:43–48; мөн 6:17–19-ийг үзнэ үү).

Бид зоригтой мөн итгэлтэйгээр Түүнд хандахыг сонговол Христ Өөрийн ариун журмаар⁵ эдгээж, боломж олгож, хүчирхэгжүүлэн, тайтгаруулж, урам хайрлах болно.

ХАЙРЫН ТАЛААР МИНИЙ СУРСАН ЗҮЙЛ

Жанис Тэйт

Энгийн нэгэн үйлчлэл Тэнгэрлэг Эцэг хүүхдүүдээ хэрхэн хайрладаг талаар надад тийм их зүйл заана гэж би огт төсөөлөөгүй.



Энэ нь ердийн нэг үйлчлэл шиг санагдаж байлаа. Халамжийн Нийгэмлэгийн хэдэн эгч орон нутгийн эмнэлгийн түр асрах төвд найрал дуу дуулахаар болов. Тэр эмнэлэгт манай тойргоос нэг ч гишүүн байгаагүй юм.

Бид нэг жижигхэн өрөөнд чихэлдэн зогсоход тэргэнцэртэй, өндөр настай есөн өвчтөн бидний өөдөөс хараад сууж байлаа. Тэдний царай ямар ч сэтгэл хөдлөлгүй, дүнсгэр байв. Өрөө их халуун, бүгчим байсан болохоор би дотроо “Хурдан дуусаасай” гэж бодож байлаа.

Би дуу удирдах байсан учраас тэдэн рүү нуруугаа харуулаад, хөтөлбөртөө анхаарлаа хандуулсан юм. Биднийг дуулж эхлэхэд нэг өвчтөн “Ээж ээ, ээж ээ” хэмээн

дуудаж, өөр нэг өвчтөн алгаа ташин, дуу чимээ нэлээн гарахыг би сонсов. Надад жаахан эвгүй санагдсан боловч хэдхэн минутын дараа хурдхан дуусгаад, гэртээ харина даа гэж бодлоо.

Бид сүүлийн дуулал болох “How Great Thou Art” (Агуу юм, Та) (*Hymns*, д. 86) дууллыг дуулахаар бэлтгэхдээ өвчтөнүүдийг болон эмнэлгийн ажилтнуудыг хамт дуулахад урьсан юм. Би бүх дуулж байгаа хүнийг удирдахаар эргэж харахдаа нулимсаа арчсан цааснуудаа өвөр дээрээ тавьсан, нүүрэндээ үрчлээтэй, буурал үстэй бяцхан эмээг олж харав.

Тэр намайг нааш ир хэмээн дохилоо. Би түүн дээр очоод, үгийг нь сонсохоор доош бөхийтөл тэргарыг минь барив. Тэгээд тэрээр “Би хожмын үеийн гэгээнтэн. Эгч нар маань ирээд ямар сайхан байна аа” гэж шивнэхэд түүний бүх бие чирч байж билээ.

Сүнс бодгалийг минь дүүргэж, түүний хажууд сөхрөн суухад, нүднээс минь нулимс урсаж эхлэв. Тэр миний сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгосон мэт нөгөө гараараа намайг тэврэн, тайвшруулж байлаа. Бүх хүн дуулж эхэлсэн ч, би эхний бадгийг дуулж чадсангүй.

Өвчтөнүүд эмнэлгийн ажилтнуудтай хамт Бурханы сүр жавхлангийн тухай дуулж байх үед Сүнс өрөөг дүүргэж, хүн бүрийн зүрх сэтгэлд

хүрсэн юм. Би арайхийн сэтгэлээ бариад, бусадтайгаа хамт дуулж эхлэв:

*Христ ирэх үед баяртайгаар
дуу алдаж,*

*Намайг гэрт минь аваачихад
баяр баясал миний зүрхийг
дүүргэх болно!*

*Тэгээд би хүндэтгэлтэйгээр
мэхийн ёсолно*

*Тэнд би, “Бурхан минь, агуу юм
та!” хэмээн тунхаглана.*

Хөтөлбөр дууссаны дараа Халамжийн Нийгэмлэгийн эгч нар өвчтөнүүдтэй болон эмнэлгийн ажилтнуудтай буужигналдан ярилцаж байв. Буурал үстэй эгч биднийг ирэх хүртэл тун их ганцаардаж, танихгүй хүмүүсээр хүрээлүүлсэн мэт санагдаж байсан гэдгээ бидэнд хэлсэн юм. Бид түүнийг энд байгааг мэдээгүй ч, Тэнгэрлэг Эцэг маань харин мэдэж байжээ.

Тэнд байсан бүх хүн бидний ах, эгч бөгөөд тэдэнд хайр, тайтгарал хэрэгтэй байсныг, мөн би хэзээ нэгэн цагт тэдэн шиг байдалд орж ч болох шүү дээ гэдгээ ойлгосон юм. Бид хайраар дүүрэн Эцэгийнхээ зэмсгүүд нь болсондоо зүрх сэтгэл минь баяраар дүүрсэн бөгөөд энэхүү үйлчлэл надад хайрын тухай том хичээл заасанд би ихэд талархаж билээ. ■

*Энэ өгүүллийг бичигч АНУ-ын
Калифорнид амьдардаг.*



ХАЙРЫН ҮЙЛДЭЛ

“Хэн ч тоодоггүй хүмүүст анхаарал тавьдаг, сэтгэл санаагаар унагсдад найдвар төрүүлдэг, мөн өвчин

зовлонд нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэн энэрдэг байх нь үнэхээр чухал билээ. Жинхэнэ энэрэл бол хайрын үйлдэл юм. Энэрэл хаа сайгүй хэрэгтэй байна.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Энэрэл хэзээ ч дуусдаггүй,” *Лиакхона*, 2010 оны 11-р сар, 124.

СОНО БЯЛЗУУХАЙГ АВАРСАН НЬ

Виллиам Хогган

Бид соно бялзуухайг аварснаар сүнслэг байдлаараа сул дорой хүмүүст хэрхэн туслахаа ойлгосон юм.

Калифорнийн уулархаг нутагт болсон залуу эмэгтэйчүүдийн аялаар охид болон удирдагчид жижиг байшин дотор оройн хоолоо хүлээж байлаа. Биднийг хүлээх зуур хэсэг охин ширээн дор нэг зүйл байгааг анзаарчээ. Соно бялзуухай байшинд нисэж орж ирээд, гарч чадалгүй шалан дээр унасан байжээ. Тэд надаас тусламж хүссэн юм.

Шувуу бараг үхэх гэж байгаа юм шиг харагдсан бөгөөд хошуу нь аалзны шүлсэнд орооцолдож, өд нь салбарсан байлаа. Би шувууг аяган дотор эвтэйхэн хийж, гадаа авч гарав. Би түүнийг өөрөө сайжирчихаж магадгүй гэж найдсан ч байгалийн жамаар үхчих вий дээ гэж бас бодлоо. Гэвч би соно бялзуухайг гаргахаар аягыг зөөлөн хөмрөх гэтэл, тэр аяганы амсраас жижигхэн савраараа зуурав. Би аягыг дээш нь харуулан барьж байсан ба шувуу амсраас нь зуурсан чигээрээ, нүд нь аниастай ирмэг дээр гарч ирэв. Одоо яах вэ? гэж би бодлоо.

Шувууг харсан нэг удирдагч ус, элсэн чихрийн уусмал надад авчирч өгөв. Эхлээд би зүү шиг хурц хошуунаас нь аалзны торыг салгахаар зөөлөн арчив. Шувуу айж цочсонгүй. Дараа нь би элсэн чихэртэй усанд хуруугаа дүрээд, хошуун дээр нь дусаав. Шувуу хэдийгээр хөдлөөгүй боловч дусал ус алга болов. Хошуугаараа сорчихов уу

даа? Би хуруугаа дахин усанд дүрж, шувууны хошуун дээр дусаалаа. Энэ үед тэр ширхэг үснээс ч нарийхан хэлээрээ миний хурууны үзүүрийг долоосон юм.

10–15 минутын турш соно бялзуухай усыг дусал дуслаар уув. Энэ хооронд өөр хэдэн удирдагч миний хажууд ирэхэд би тэднээс шувуунд ус өгөх үү гэж асуулаа.

Шувуу гэнэт нүдээ нээж, салбарсан өд сөд нь ч хэвэндээ орсон юм. Тэр дахин хэдэн дусал ус уугаад, далавчаа

дэвж, хэдэн секундийн турш биеэ дасгалжуулснаа дээш нисэв. Шувуу хэсэг зуур бидний дээр эргэлдсэн нээ нисэн одсон юм.

Бид тэнд алмайран зогсож байлаа. Тэгтэл шувуу гэнэт нисэж одсонтой адил, дараах сүнслэг сургамж толгойд орж ирэв:

- Идэвх султай хүмүүст туслах бидний оролдлого ихэнхдээ нэмэргүй мэт санагддаг. Гэхдээ соно бялзуухайн хөдөлгөөнгүй хошуу руу чихэрлэг уусмал уусан орсон шиг бидний хайр тэдэнд сүнслэг тэжээл өгч, хэзээ нэгэн цагт үр дүнгээ өгөх болно.

- Заримдаа бид өөрсдөө ч цаашаа явж чадахааргүй болдог ба бидэнд халамж үзүүлэх гар хэрэгтэй болдог.
- Зарим үед хүмүүс нүглийн юм уу донтолын торонд орооцолддог бөгөөд үүнээс чөлөөлөгдөхийн тулд тэдэнд найзын эсвэл санваарын удирдагчийн тусламж, Аврагчийн дэмжлэг хэрэгтэй болдог.
- Бидэнд тэвчихэд туслах байнгын сүнслэг тэжээл хэрэгтэй бөгөөд эс бөгөөс бидний сүнслэг хүч шавхагдаж, бид хорон муу нөлөөнд автагдах болно.

- Соно бялзуухай тэвчсээр байсан. Шууд утгаараа шүү. Тэсэж байсан учраас л тэр амьд үлдсэн юм. Бид амьдралдаа хүнд, заримдаа аймшигт бэрхшээлүүдтэй тулгарах үедээ итгэлтэйгээр тэвчих хэрэгтэй болдог.

Аврагч бор шувуу унахыг хүртэл мэддэг гэж Шинэ Гэрээнд гардаг билээ (Матай 10:29–31-ийг үзнэ үү). Тэрээр соно бялзуухай унахыг ч бас мэддэг гэдгийг би мэднэ. Тэр та нарыг ч мөн мэддэг. ■

Энэ өгүүллийг бичигч АНУ-ын Калифорнид амьдардаг.





“Гэр орондоо Христийн тухай НОМЛЮХ бидний арга зам”



“Мөн бидний хүүхдүүд нүглээс ангижрахын тулд ямар сурвалжийг хайж болохыг мэдэж болохын тулд бид Христийн тухай ярьж, бид Христэд баясч, бид Христийн талаар номлож, бид Христийн тухай бошиглож, мөн бид бошиглолудынхаа дагуу бичдэг болой” (2 Нифай 25:26).

Дэррэн Э.Шмидт

Нэг удаа Христийн Амилалтын баярын үеэр эхнэр минь Аврагчийн сүүлийн долоо хоногийн тухай судрын түүхээс гэр бүлээрээ уншихыг санал болгосон юм. Бид орой бүр унтахаасаа өмнө хүүхдүүдээ Шинэ Гэрээг уншиж өгч, үйл явдал бүрийн талаар богино видео бичлэг үзүүлээд, тэдний асуусан зүйлийн тухай ярилцдаг байв. Хүүхдүүдийнхээ асуултуудад, мөн хамт уншиж, ярилцах үеэр Сүнс манай гэрт хүчтэй мэдрэгдэж байгаад би гайхширч байсан.

Би долоо хоногийн төгсгөлөөр Түүний золиослол, туулж өнгөрүүлсэн бүхнийх нь үр дагаврыг тунгаан бодсоноор Аврагчид илүү их талархаж, Түүнийг хайрлах болсон юм. Миний сэтгэл хөдлөхийн зэрэгцээ эхнэр маань ч бас сүнслэгээр өдөөгдсөнийг би мэдэж байсан бөгөөд хүүхдүүд маань Аврагчийг илүү сайн ойлгож, илүү их хайрлаж байгааг, мөн тэд нэг нэгэндээ Христийнхтэй адил зан чанарыг үзүүлэх хүсэлтэй байгааг мэдэрч билээ.

Үүнээс хойш бид харилцан яриа, хичээлүүддээ “Христийг ярьж” мөн “Христийн тухай номлох” өөр арга замуудыг нээж олсон бөгөөд Есүс Христийн суурин дээр босгогдвол амьдралын шуургыг тэсэн гарах агуу хүч бидэнд амлагдсан гэдгийг мэдэж байв (Хиламан 5:12-ыг үзнэ үү).



Залбирлын талаар заах жишээ

Жишээ нь, та залбирлын ач холбогдлын талаар зааж байна гэж бодъё. Та “үргэлж залбир” хэмээх удирдамжийг агуулсан Сургаал ба Гэрээ 10:5-ыг, эсвэл “хилэнцэт сүнс хүнд залбирахыг үл сургана” (2 Нифай 32:8) хэмээх Нифайн зөвлөгөөг ашиглаж болно. Эдгээр судар залбирлын сургаалыг хүчтэй заадаг. Та эдгээрийг ярилцахдаа “Аврагч хэрхэн залбирсан бэ?” эсвэл “Аврагчийн залбирал ямар байсан бэ?” гэж асуулаа гэж бодъё. Хэрэв та

Зааж буй зүйлээ Аврагч дээр төвлөрүүл

Аврагчийн жишээ, сургаалуудыг гэр бүлийн ярилцлага ба харилцан үйлчлэлд оруулах үед тэдгээр нь илүү хүчирхэг, бас утга учиртай болдгийг бид ойлгож мэдсэн. Аврагч “Би бол усан үзмийн мод, та нар бол мөчрүүд. Хүн Миний дотор байж, Би мөн түүний дотор байвал, тэр хүн их жимс ургуулна” хэмээн заасан билээ (Иохан 15:5). Хэрэв бид заахдаа энэ зүйрлэлийг ашиглавал бид сайн мэдээний зарчмуудыг хоорондоо авчалдаагүй байдлаар бус, харин бошиглогч Иосеф Смитийн хэлсэнчлэн тэдгээрийг Есүс Христийн Цагаатгалын хавсралт болгож заах болно.¹ Бид энэ мэтчилэн зааж буй зүйлээ Аврагч дээр төвлөрүүлснээр өөрсдийгөө Түүний усан үзмийн модны мөчрүүд гэдгийг илүү сайн ойлгож чадна.

Хэрэв бид Түүнийг зааж буй зүйлийнхээ цөм нь болговол энэ нь бидэнд тэжээл, хүч чадал, өсөлт хөгжил ба арвин жимстэй мөчрүүдийг өгч, өөрөөр хэлбэл бидний ярилцлага ба хичээлүүд илүү агуу хөрвүүлэх хүч ба урт хугацааны үр дүнг өгөх болно гэж амлагдсан билээ. Үүнийг хийх нэгэн арга зам бол сайн мэдээний нэг зарчмыг заагаад, “Есүс энэ зарчмыг, эсвэл энэ сургаалыг хэрхэн үзүүлсэн бэ?” эсвэл “Энэ зүйлийн талаар Их Эзэн юу хэлж эсвэл заасан бэ?” зэрэг асуулуудыг хүүхдүүдээсээ асуух явдал юм.

бага насны хүүхэдтэй бол “Аврагчийн залбирал ямар байсан гэж чи *бодож* байна вэ?” гэж асууж болно.

Та санаандаа орж ирэх судруудыг бодож байгаад, энэ асуултанд өөрөө яаж хариулах байснаа түргэхэн бод. Миний санаанд Аврагчийн Америк тивд хийсэн айлчлал шууд бууж байна, “тэр Эцэгт хандан залбирав, мөн түүний залбирсан зүйлүүд бичигдэх аргагүй байлаа. . . . Эцэгт хандан Есүсийн ярьсныг бид харж мөн сонссон шиг тийм агуу хийгээд гайхамшигт зүйлүүд урьд нь нүдэнд хэзээ ч үзэгдээгүй, бас чихэнд хэзээ ч сонсогдоогүй бөлгөө” (3 Нифай 17:15–16).

Дараа нь хүмүүс Түүний залбирлыг загвар болгож, үүний үр дүнд “олон үг нуршсангүй, учир нь тэд юу гэж залбирах нь *тэдэнд өгөгдсөн байв*, мөн тэд *хүслээр дүүргэгдэв*” гэдгээс бид суралцдаг (3 Нифай 19:24; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн). Энэ үед та залбирах хүсэл төрж байсан үеийнхээ талаар хуваалцахад хүүхдүүдээ урих юм уу, залбирч байх үед хэлэх үгс танд өгөгдөж байсан үеийнхээ тухай хуваалцаж болно. Дараа нь та, Аврагчийн зааснаар залбирахад залбирал хэр хүчтэй байдаг тухай гэрчилж болно.

Таны хүүхдүүд эдгээр шүлэг дэх залбирлын тухай зарчмуудын дагуу, мөн таны болон өөрсдийнхөө хуваалцсан гэрчлэлийн дагуу үйлдвэл тэдэнд ямар өөрчлөлт гарч болохыг бодоод үзээрэй. Энэ нь тэдний Ариун Сүнсийг мэдэрч, таних чадварт, мөн дуудлагаа эрхэмлэн

биелүүлэх, санваарын адислал өгөх, өөрсдийн гэр бүлтэй болох зэрэгт “хүмүүнд залбирахыг сургах” (2 Нифай 32:8) тэрхүү Сүнсээр удирдуулах чадварыг хэрхэн нэмэгдүүлж болохыг бодоод үз.

Хэрэв энэ ярилцлагад Аврагчийн жишээ, эсвэл заасан зүйлс ороогүй байсан ч, бид залбирлын талаар сайтар ярилцаж болно. Гэхдээ Түүний жишээ ба заасан зүйлсийг оруулах нь үүнд илүү их утга учир, хүч чадлыг нэмж өгдөг.

Сайн мэдээнд төвлөрсөн уран зургууд

Христэд илүү төвлөрсөн гэр бүлийг бий болгохын тулд бидний хийдэг өөр нэг зүйл бол Христийн болон ариун сүмийн, мөн сайн мэдээтэй холбоотой бусад зургийг хүүхдүүдэд харагдахуйц газарт байрлуулж, бидэнд юу хамгийн чухал болохыг сануулж байх явдал юм.

Хэдэн жилийн өмнө хүүхдүүдтэйгээ аравны нэгийн тайлан хэлэлцүүлэгт орж байхад бишоп маань манай арван настай хүүд Аврагчийн зургийг өгөөд, Түүнийг дагах амлалтыг гэр бүлд маань байнга сануулж байх газарт байрлуулахыг хүссэн юм. Тэр гэртээ ирээд, зургаа хаалган дээр байрлуулан, “бид бүгдээрээ үүнийг энд хамгийн их харах болно” гэж хэлэв. Энэ нь Есүс Христийг дагах амлалтыг маань бид бүгдэд өдөр бүр сануулдаг гайхалтай адислал, байнгын сануулагч болсон билээ.

Зургууд гэрийн тань хаана байгаа нь хамаагүй, та нар ханан дээр байгаа зургуудыг анзаарахдаа хүүхдүүдээ ямар захиас өгч байгаагаа бодох нь л чухал юм. Танай гэрт байгаа зургууд Аврагчийг дагах амлалтыг тань харуулдаг уу?

Христийн талаар заах өөр арга замууд

Есүс Христийг хүүхэддэйн киноны супер баатруудаас илүү хүчтэй эсэхийг хүүхдүүд асуух үед миний инээд нэг бус удаа хүрч байсан ч хүүхдүүдийн асуулт нь Аврагч юугаараа супер баатруудаас илүү болох тухай ярилцах сайхан сэдэв болдгийг би ойлгосон. Иймэрхүү өдөр тутмын харилцан ярианаас гадна эдгээр нь гэрээгээ Христэд төвлөрсөн байхын тулд анхаарч үзэж болох санаанууд юм.

- Есүс Христийн Цагаатгалын тухай хүүхдүүдэд заахын тулд Мормоны Номыг ашигла. *Цагаатгал*

эсвэл *цагаатгах* гэдэг үг Мормоны Номонд 39 удаа гардаг.

- Гэр бүлийн үдшийн хичээлүүд болон судрын уншлагаа сайжруулахын тулд Mormon Messages, Библийн видео бичлэгүүд, мөн Есүсийн талаар заадаг Сүмийн өөр эх сурвалжуудыг ашигла.
- Аврагчийн тухай дууллаудыг сурч, хамтдаа дуулж, тэдгээрийн зааж буй сургаал ба утгыг ярилц.
- Бошиглогчид бол Есүс Христийн онцгой гэрчүүд гэдгийг онцлох арга замуудыг ол.
- Аврагчтай харилцах хувийн харилцаагаа сайжруулахыг байнга эрэлхийл.

Би анхааралтай судалж, шаргуу залбирснаар Есүс амьд, Түүний Цагаатгалын агуу бэлэг нь бодитой бөгөөд бидний болон хайртай хүмүүсийн маань амьдралд утга учир, зорилго чиглэл өгдгийг, мөн гэр бүл маань үүрд мөнх биднийх байх болно гэсэн агуу, алдар суут амлалттай хамт өгдөг гэдгийг мэдэж авсан юм. Бид бүгд Христэд төвлөрсөн гэр оронг бий болгохын ач холбогдлыг ухаарч, “Христэд мөн түүгээр бус аваас хүмүүн аврагдаж чадах өөр зам эсвээс арга үгүй гэдгийг” (Алма 38:9) ойлгох болтугай. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

Эшлэл

1. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 59-ийг үзнэ үү.



ПАЛМИРАД

хүрэх зам



*Анхны үзэгдэл, мөн алтан ялтсууд
булаастай байсан газар болох Палмирад хүрэх
зам нь Иосеф Смит ба түүний гэр бүлийн
хувьд асар хүнд, бэрхшээлтэй байсан юм.*

ГЭРЭЛ ЗҮРГИЙГ ЖОРЖ АНДЕРСОН, СМИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТГЭВ

Мэттью С.Холланд

Энэ нь бошиглогч Иосеф Смитийн тухай цуврал хоёр өгүүллийн эхнийх нь юм. Хоёр дахь өгүүлэл "Мормоны Номын ирэлт" нь Лиакхона сэтгүүлийн дараа сарын дугаарт гарах болно.

Үүнд эргэлзсэний хэрэггүй. Та бүрэн цагийн номлогч мөн эсэхээс үл шалтгаалан бүх хожмын үеийн гэгээнтэн нь Их Эзэн Есүс Христийн захиасыг "бүх дэлхийд" (Матай 24:14) хүргэхээр дуудагдсан юм. Бид Түүний сайн мэдээний үнэн зарчмуудыг болон үйл ажиллагаануудыг Түүний нэрээр номлохоор дуудагдсан. Бид үүнийг хийх үедээ Иосеф Смит бол тэдгээр үнэн зарчим ба үйл ажиллагаануудыг дэлхийд сэргээхэд Түүний зэмсэг болсон гэдгийг заавал зааж мөн гэрчлэх ёстойгоо мартаж болохгүй.

Маш их зүйл аюулд ороод байгаа үед та нар урагш алхаж; бүрэн итгэл, зоригийг харуулан "нэг мянга найман зуун хорин оны хаврын нэгэн сайхан, цэлмэг өдрийн өглөө"¹ Иосеф Смит нам гүмхэн ой руу алхаж очин, өвдөг сөгдөн залбирсан бөгөөд үүнээс болж дэлхий орвонгоороо эргэсэн гэж тунхаглаж чадах эсэхээ та нар өөрсдөөсөө асуух нь зүйтэй. Хэрэв та нар Бурханы үйлчлэгчид болж, дуудагдахыг хүсэж байгаа бол үйлдэхэд бэлэн байх ёстой.

Яг одоо бошиглогч Иосеф Смитийн амьдралыг судлах суралцагч болох шийдвэр гарга. Аврагчийн амьдралыг эс тооцвол, өөр ямар ч хүний амьдралд байхгүй хүч, мэргэн ухаан түүний амьдралд байдаг. Та нар хичээнгүйлэн залбирч, Иосефын амьдралын нарийн ширийн зүйлтэй танил болохын хэрээр та нарын түүнийг хайрлах хайр, хүндэтгэл өсөж, номлогчийн ажлын хамгийн хүнд өдрүүдэд ч тайтгарал, урам зориг авч, Иосеф Смитийг бошиглогч биш гэж үздэг орчин үеийн шүүмжлэгчдийн эсрэг ойлголт тань бат бөх болно гэдгийг би амлаж байна. Энэхүү зорилгын улмаас хамгийн гайхалтай энэ хүний амьдралыг цухасхан ч болов хараад үзээрэй.

Бэрх зам

Анхны үзэгдэл болсон өглөө "Иосеф Смитийн анхны залбирал"² хэмээх дуулалд гардагчлан гайхамшигтай бөгөөд үзэсгэлэнтэй байсан гэдэг нь тодорхой юм. Гэхдээ энэ дүр зургийн хажуугаар бид энэ өглөө болохоос өмнө юу болсныг мартарх ёсгүй. Энэхүү ариун нандин явдал болсон газар Палмирад хүрэх зам нь бошиглогч хөвгүүн болон түүний гэр бүлийн хувьд асар хүнд, бэрхшээлтэй байсан юм.



Ахмад Иосеф Смит
Вермонтод гурван жил
дараалан ургацаа алдса-
ныхаа дараа баруун урд
зүгт 482 км зайд орших
Нью-Йоркийн Палмира
руу гэр бүлээрээ нүүх
хүндхэн алхам хийжээ.

нутагт ферм нь санхүүгийн тогтвортой байдал болон урт хугацааны аюулгүй байдлын баталгаа болж байв. Ингээд мөнгө ч үгүй, газар ч үгүй болсон Смитийн гэр бүл 14 жилийн дотор 8 удаа нүүхээс өөр аргагүй болж, гэр бүлээ тэжээх арга зам хайсаар байв.

Энэ олон нүүдлийн нэг нь гэхэд л, 1813 онд Смитийн гэр бүлийн хүүхдүүдийг дайрсан гэдэсний хижиг өвчнөөс шалтгаалсан эмчилгээний төлбөрөөс үүдэлтэй юм.

Бошиглогчийн эцэг Ахмад Иосеф Смит, эх Люси Мак Смит нар 1796 онд АНУ-ын Вермонтын Танбрижэд гэрлэжээ. Смитийн гэр бүл фермийн аж ахуйг зургаан жил амжилттай эрхэлсний эцэст дэлгүүр ажиллуулж үзэхээр ойролцоох Рандолф гэдэг газар руу нүүжээ.³

Бостонд суурьшдаг зээл олгогчийн тусламжтайгаар Ахмад Иосефын авч ирсэн барааг хүлээсэн харилцагчид нь тэр даруй авсан боловч бэлэн мөнгөөр биш, харин ургац хураалтын сүүлээр төлнө гэж зээлээр авчээ. Тэр өрөө аваад, зээл олгогчийн өрийг төлөхөөр хүлээж байх зуураа мөнгөө өсгөх өөр нэг боломжийг олж харжээ.

Тухайн үед Хятадын зах зээлд газар авсан хүн орхоодойн үндэс сайн зарагдаж байв. Нэг зуучлагч Ахмад Иосефын тээвэрлэхээр цуглуулж, бэлтгэсэн хүн орхоодойн үндсийг бэлэн мөнгөөр буюу 3000 ам.доллараар авах санал тавьсан ч тэр бараагаа Нью-Йорк руу өөрөө авч яваад, тэндээ нэг усан онгоцны ахмадтай тохиролцож, Хятадад заруулах илүү эрсдэлтэй боловч ашигтай байж болох хувилбарыг сонгожээ. Тэр зуучлагчийн санал болгосноос 4500 ам.доллар илүү олох боломжтой байсан юм. Энэ нь тухайн үедээ асар их хэмжээний мөнгө байв.⁴

Азгүйтэл үү, эсвэл гай таарсан уу, Ахмад Иосефын барааг ачиж явсан усан онгоцонд өнөөх зуучлагчийн хүү явж байжээ. Зуучлагчийн хүү энэ боломжийг ашиглан Смитийн хүн орхоодойг Хятадад “өндөр үнээр” зараад, өөрөө мөнгийг нь авч, энэ аяллаар ямар ч ашиг олоогүй, харин авдар дүүрэн цайтай ирлээ гэсэн үлгэр зохион ярьжээ.⁵

Энэ хооронд Смитийн дэлгүүр их хэмжээний барааны өрийг төлөх хугацаа болсон байна. Хатуу өр нэхэгчдийн шахалтаар Смитийн гэр бүл хамаг мөнгөө шавхаад, юу ч үгүй үлджээ. Люси өрөө төлөхийн тулд олон жил хадгалсан хуримын бэлэг болох 1000 ам.доллараа өгч, Иосеф Танбриж дахь гэр бүлийн фермээ 800 ам.доллараар худалдсан юм.⁶ Энэ үед Америкийн газар



Иосефын халуун буугаад, хэдэн долоо хоносны дараа мөр нь аймшигтай өвдөж эхлэв. Орон нутгийн нэг эмч үүнийг булчингийн суналтаас үүдэлтэй хэмээн буруу оношилсон байна. Хоёр долоо хоногийн дараа өвдөлт тэсэхийн аргагүй ихсэхэд, эмч дахин үзээд, Иосефыг халуурахад хүргэсэн халдвар байгааг олж мэджээ.⁷

Халдвартай хэсгийн эргэн тойронд их хөндүүр байсан бөгөөд эмчилгээ дутуу хийгдсэнээс болж Иосефын зүүн хөлөнд шинээр халдварлажээ. Үүнээс болж мэс заслын эмч дуудуулсан байна. Эмч өвдөгнөөс шагай хүртэл 20 см зүсэлт хийсэн нь өвдөлтийг бага ч атугай намдааж байв. Гэвч харамсалтай нь, халдвар ясанд нь орсон байлаа.⁸

Энэ үед гэр бүлийнхэн нь Дартмутын Анагаах Ухааны Их Сургуулийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдээс хамгийн сүүлийн үеийн зөвлөгөөг авчээ. Люси тухайн үед нийтлэг дэлгэрсэн хамгийн боломжтой

Иосеф Смитийг Нью-Йоркийн Палмирад ирэхэд нь Их Эзэн Өөрийн урьдчилан томилогдсон бошиглогчийг үнэлж баршгүй эрдэнэс байгаа газар болох гүвээ рүү авчирсан байна.



байсан арга болох тайрах аргыг *хэрэглэхгүй* гэж зүтгэж байв. Үүний оронд тэд шинэ, асар их өвдөлттэй мөртлөө амжилттай болох магадлал багатай аргыг хэрэглэхээр шийджээ. Эмч нар Иосефын хөлөнд хагалгаа хийж, ясны хоёр талд хоёр, хоёр нүх өрөмдөх хэрэгтэй болов. Дараа нь тэд халдвартай хэсгийг бүхлээр нь авахын тулд ясны гурван том хэлтэрхийг зорж авах хэрэгтэй болсон юм.⁹

Энэ зовлон зүдгүүрийн дараа Вермонтын Норвич дахь шинэ эхлэл тэдний өдрийн бодол, шөнийн зүүд болж байсан тогтвортой байдал, хангалуун амьдралыг авчирна гэж гэр бүлийнхэн нь найдаж байв. Гэвч тэдний найдвар дахин талаар болов. Түрээсийн газар дээр тариалан эрхлэх гэж оролдсон эхний жилдээ тэд ургацаа алджээ. Тэд хоёр дахь жилдээ дахин ургац алдав. Гурав дахь жил буюу 1816 онд Ахмад Смит бүх



Энэ бүх ажиллабар нь өнөөдөр өргөн хэрэглэгдэж буй өвчин намдаагчгүйгээр хийгдэх ёстой байлаа. Тиймээс энэ нарийн түвэгтэй ажиллабарын үеэр Иосефыг хөдөлгөөнгүй байлгахын тулд түүнд архи уулгахыг эсвэл түүнийг орноос хүлэхийг гэр бүлийнхнээс нь хүсчээ. Долоохон настай Иосеф энэ хоёрын алийг нь ч зөвшөөрөөгүй юм. Харин тэр аавдаа тэврүүлж мөн ээжийгээ өрөөнөөс гаргах хоёр хүсэлт тавьжээ.¹⁰

Иосеф орь дуу тавин хашгирахад, ээж нь гадаа байж тэсэлгүй хоёр ч удаа өрөө рүү нь орж ирсэн гэдэг. Түүний харсан дүр зураг аймшигтай байлаа. Иосеф цус нэвчсэн орон дээр хэвтэж байсан бөгөөд “царай нь үхсэн мэт зэвхийрч, том том хөлсний дуслууд нүүрэн дээр нь бөмбөрч, биеийнх нь бүх хэсэг туйлын их өвдөж байв.”¹¹ Азаар мэс ажиллабар амжилттай болсон ч Иосеф гурван жилийн турш суга таягтай явжээ.

зүйл сайжрах ёстой гэсэн итгэлээр дахин нэг оролдоод үзэхээр шийджээ.¹²

1815 онд дэлхийн нөгөө талд Индонезийн Тамбора уул дэлбэрч, дэлхийн агаар мандалд асар их хэмжээний үнс цацагдаж, цаг уурт өөрчлөлт орсон байна. 1816 оны 6–8-р сарыг “зун үзээгүй жил” хэмээн нэрлэсэн ба Шинэ Англид дөрвөн удаа цочмог хүйтэрч, зуны ургацыг дахин сүйтгэжээ.¹³

Өлсгөлөн газар авч, хүмүүс мянга мянгаараа Вермонтоос явж байх үед Ахмад Смит нэгэн хүнд алхам хийсэн юм. Тэрээр амьдралынхаа ихэнх хугацааг өнгөрүүлсэн 32 км радиус бүхий нутгаас гарч; гэр бүл, найз нөхдөө орхин; баруун урд зүгт 482 км зайд орших Нью-Йоркийн Палмира руу явжээ. Тэндхийн газар үржил шимтэй, удаан хугацааны зээл авах боломжтой гэсэн яриа байв. Аргагүй байдлаас болж Ахмад Иосеф түрүүлж явсан бөгөөд Люси найман

хүүхэдтэйгээ эд хогшлоо баглаж, түүний араас явахаар болжээ.¹⁴

Өвөл болоход Люси зоригт бяцхан хүүхдүүдтэйгээ, эзэмшдэг бүхнээ чарганд, дараа нь тэргэнд ачив. Хэд хэдэн хүний өрийг төлсний дараа Люсид аялалдаа зарцуулах багахан мөнгө үлдсэн байна. Аяллынхаа сүүлээр тэр дэн буудлын эздэд хувцас хунар ба эм тариагаар



төлбөр хийж байв. Тэрээр Палмирад “дөнгөж хоёрхон центтэй” ирснээ дурсан ярьсан байдаг.¹⁵

Аялах замд чарга жолоодохоор хөлсөлсөн хүн нь тэдэнтэй нэг зүгт явж байсан Гэйтс хэмээх гэр бүлийн хоёр царайлаг охиныг суулгахын тулд залуу Иосефийг чарганаас буулгаж, алхуулжээ. Бүрэн эдгэрээгүй байсан Иосеф “хэдэн өдрийн турш өдөр бүр цасан дундуур 64 км алхсан” бөгөөд тэр үүнийгээ “хамгийн аймшигтай ядаргаа болон зовиур” хэмээн хэлсэн байдаг.¹⁶

Иосефийн хайрт ах Хайрум, Алвин хоёр энэ эрэгтэйгээс удаан явахыг гуйхад, тэр тэднийг ташуурын ишээр цохиж, газарт унагажээ. Ютикад Люси мөнгөгүй болсон тул сайхь эр тэднийг орхисон бөгөөд тэргийг нь хулгайлах гэж оролдоод, эд юмсыг нь газарт хаясан байна.¹⁷ Тэд Палмирад аюулгүй очиж, Ахмад Иосеф Смит дээр гунигтайхан ирэх хүртлээ аажуухан урагшилсаар байсан юм.

Магадгүй энэ аяллын хамгийн зүрх шимшрүүлэм хэсэг нь гэр бүлийнхээ аяллын цэдэгт Иосефийн нэмж оруулсан хэсэг байж болох юм: “Ютикагаас явах замд би хамгийн сүүлийн чарганд суухаар үлдсэн бөгөөд чарга ирэх үед жолооч Гэйтсийн хөвгүүдийн нэг нь намайг цохиж унагаад, орхиод явсан юм. Намайг цусандаа хутгалдан хэвтэж байхад үл таних хүн олж, Палмира тосгонд авчирсан.”¹⁸ Энэ үйл явдал мартагдах ёсгүй.

Үнэлж баршгүй эрдэнэс

Палмирагийн төвөөс гуравхан километрийн зайд орших ойн төгөлд хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн агуу үзэгдлүүдийн нэг болсон билээ. Үүнээс таван километрийн зайд тухайн үед мэдэгдээгүй байсан алтан ялтсууд хадгалагдаж байсан Кумора гүвээ орших ажээ.

Иосефийг Палмирад ирэхэд нь Их Эзэн Өөрийн урьдчилан томилогдсон бошиглогчийг үнэлж баршгүй эрдэнэс байгаа газарт авчирсан байна. Энэхүү эрдэнэс нь олон зууны турш үргэлжилсэн сүнслэг харанхуй болон эргэлзээний дараа тэнгэр дахин нээгдсэн гэдгийг харуулах учиртай байв. Есүсийн тохинуулал нь тухайн үеийн Христийн сүмүүдийн төсөөлж байснаас ч илүү сургаалын болон газар зүйн хувьд өргөн цар хүрээг хамарсныг энэхүү эрдэнэс харуулах учиртай байжээ. Энэхүү эрдэнэс нь Бурхан гайхамшигт арга замаар цаг хугацаа, хэл, тив газрыг үл харгалзан хүмүүсийн амьдралд идэвхтэй оролцож байгаа гэдгийг батлах байв. Энэхүү эрдэнэс нь туйлын цэвэр сургаалуудыг агуулах бөгөөд хэрэв хүн тэдгээрийг бодгальдаа гүн таривал тэрээр өөрчлөгдөж, ямар ч зүйлээс илүүтээр хүслийг нь гүйцээх тийм амттай гэдгийг олж мэдэх болно.

Бид эгэл нүдээр хараад, энэ хүний аялсан зам нь амархан, үр дүнтэй, алга ташилтаар угтуулсан байх ёстой байсан гэж бодож болно. Уг хөвгүүн энэ тосгонд ирсний үр дүнд болсон зүйлүүдийг мэдэж байсан, мөн мянга гаруй жилийн өмнө алтан ялтсуудын байх газрыг маш сайн төлөвлөсөн Их Эзэн энэ хөвгүүнийг шулуун дардан, тав тухтай, олонд танигдсан маягаар ирүүлж чадахгүй байсан юм гэж үү?

Их Эзэн үүнийг хийж чадах байсан ч, Тэр тэгээгүй юм.

Бага байхад нь түүнийг сүр дуулиантайгаар тослоогүй (1 Самуел 16:11–13-ыг үзнэ үү). Түүнийг амлагдсан газар руу удирдсан зүүд өгөгдөөгүй (1 Нифай 5:4–5-ыг

**Нью-Йоркийн Палмирагийн
төвөөс холгүйхэн орших ойн
төгөлд хүн төрөлхтний түүхэн
дэх хамгийн агуу үзэгдлүү-
дийн нэг болсон билээ.**



үзнэ үү). Түүний гэр бүлд аюул ослоос зайлсхийхэд туслах Лиахона ч байгаагүй билээ (1 Нифай 16:10; Алма 37:38-ыг үзнэ үү). Жигд урт цуваан дунд дээвэргүй лимузин машин явж, хоёр талаар нь уухайлан дэмжих олон үзэгчтэй, сүр дуулиан бүхий жагсаал байгаагүй нь тодорхой.

Харин Иосеф болон түүний гэр бүл азгүйтэл, өвчин эмгэг, алдаа оноо, байгалийн гамшиг, аймшигт өвдөлт, шударга бус байдал, байнгын тодорхой бус, ядуу тарчиг байдлын замаар аялж ирсэн юм. Энэ нь Смитийн гэр бүл үргэлж зовлон шаналал дунд амьдарсан гэсэн үг ч биш. Тийм ч байгаагүй юм. Гэхдээ Палмирад хүрэх зам нь шулуун дардан, хөгжил цэцэглэлт дагуулсан, олон нийтэд танигдахаар байгаагүй билээ. Туйлдсан, цусандаа хутгалдсан, доголлон бошиглогч маань агуу ихийг бүтээх газартаа үл таних хүнээр өргүүлж ирсэн юм.

Үүнийг Иосефын амьдралаас болон Мормоны Номын ирэлтээс бидний сурах ёстой эхний сургамж гэж бодож болно. Бүтэлгүйтэл, золгүй явдал, хатуу эсэргүүцэлтэй тулгарсан ч гэлээ, олон тохиолдолд тэдгээрээс *болж* Иосеф Смит номлолоо гүйцээхийн тулд байвал зохих газартаа ирсэн юм. Одоо, эсвэл ирээдүйд та эргэн тойрноо харахад, таныг ажлаасаа халагдсан үед хичээл зүтгэлгүй нэгэн танил тань ажилдаа амжилт гаргасан байвал; хэрэв гэнэтийн өвчин зовлон таныг удаан хугацааны турш үйлчлэлээс холдуулбал; чухал албан тушаал өөр хэн нэгэнд өгөгдвөл; хэрэв номлолын хамтрагч тань танаас хурдан хэл сурч байвал; сайн санаж хийсэн үйлдлийнхээ хариуд хамтрагчид, тойргийн гишүүд, номлолын удирдагчидтай таарамжгүй байвал; эсвэл гэрээс

чинь санхүүгийн бэрхшээл юм уу эмгэнэлтэй явдлын мэдээ ирвэл; эсвэл хэрэв та өдөр бүр бусдын аз жаргалын төлөө бүтээгдсэн мэт санагдах номлол хэмээх жүжигт гол дүр бүтээхгүй байгаагаа мэдэрч шантарч байгаа бол *үүнийг сана*: 2000 жилийн өмнө Голгота болон цэцэрлэгийн булшинд болсон үйл явдлуудаас хойш дэлхийн түүхэн дэх хамгийн агуу зүйлийн тайз руу очиж байх яг тэр үед Иосеф Смитэд эдгээрийн олон нь тохиолдсон юм.

Та нар “гэхдээ миний амьдрал, хувь тавилан маань хэзээ ч бошиглогч Иосефийнхтой адил байхгүй” гэж хэлж магадгүй.

Үнэхээр ч тийм байж болох юм. Гэхдээ та нарын амьдрал Бурханд хамаатай бөгөөд та нарын болон та нарын номлолдоо уулзах бодгаль бүрийн мөнхийн хувь тавилан нь бошиглогч Иосеф Смитийнхтэй адил ач холбогдолтой гэдгийг би гэрчилж байна. Тиймээс амьдрал эсвэл нэн ялангуяа номлогчийн ажил хүнд, эргэлзээтэй, бүүдгэр болох үед хайрт Иосефийн адилаар та нар хэзээ ч бууж өгөх ёсгүй. Харин Паулын заасанчлан, та нар “Бурханыг хайрладаг, Түүний зорилгын дагуу дуудагдсан хүмүүст тохиолддог *бүхий* л зүйл эцэстээ тэдний сайн сайхны төлөө байдаг гэдгийг” (Ром 8:28; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) ойлгох ёстой.

Залуу Иосефийн адилаар Бурхан та нарын мэдэж байгаагаас ч илүү зүйлд та нарыг өдөр бүр бэлтгэж мөн чиглүүлж байгаа! ■

2014 оны 2-р сарын 15-нд Ютагийн Прово дахь Номлогчийг Бэлтгэх Төвийн онцгой цугларалтаар хэлсэн “Мормоны Ном, Иосеф Смит ба та нарын уг гарал” сэдэвт үгнээс авав. Мэттью С.Холланд нь Юта Валли Их Сургуулийн захирал юм.

ЭШЛЭЛҮҮД

1. Иосеф Смит—Түүх 1:14.
2. *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу*, х.14
3. Люси Мак Смит, *Biographical Sketches of Joseph Smith, the Prophet, and His Progenitors for Many Generations* (1853), 37, 45-ыг үзнэ үү. Смитийн гэр бүл Палмира руу нүүсэнтэй холбоотой товч мэдээлэл авахыг хүсвэл Richard Lyman Bushman, *Joseph Smith: Rough*

- Stone Rolling* (2005), 17–29-ийг үзнэ үү.
4. Люси Мак Смит, *Biographical Sketches*, 49-ийг үзнэ үү.
5. Люси Мак Смит, *Biographical Sketches*, 49-50-ыг үзнэ үү.
6. Люси Мак Смит, *Biographical Sketches*, 51-ийг үзнэ үү.
7. Люси Мак Смит, *Biographical Sketches*, 60, 62-ыг үзнэ үү.
8. Люси Мак Смит, *Biographical Sketches*, 62-63-ыг үзнэ үү.
9. LeRoy S. Wirthlin, “Joseph

- Smith’s Boyhood Operation: An 1813 Surgical Success,” *BYU Studies* 21, no. 2 (1981): 146–154-ийг үзнэ үү.
10. Люси Мак Смит, *Biographical Sketches*, 64-ийг үзнэ үү.
11. Люси Мак Смит, *Biographical Sketches*, 65-ыг үзнэ үү.
12. Люси Мак Смит, *Biographical Sketches*, 66-г үзнэ үү.
13. *Church History in the Fulness of Times*, 2nd ed. (2003), 24-ийг үзнэ үү.

14. Люси Мак Смит, *Biographical Sketches*, 67-г үзнэ үү.
15. Люси Мак Смит, *Biographical Sketches*, 68, 70-ыг үзнэ үү.
16. Иосеф Смит, *The Papers of Joseph Smith*, ed. Dean C. Jessee, 2 vols. (1989), 1:268.
17. *The Papers of Joseph Smith*, 1:268-ыг үзнэ үү.
18. Иосеф Смит, *The Papers of Joseph Smith*, 1:268–269-ийг үзнэ үү.



Авралыг

ЭРЭЛХИЙЛЭХ НЬ

Конни Голдинг

2010 оны 8-р сарын 5-нд уурхайн нуранги болж, 33 чили уурхайчин уурхайн гүнд гацсан юм. Тэд газар доор 700 метрийн гүнд жижигхэн аюулгүй газарт байлаа.

Нөхцөл байдал тун хүнд байв. Тэднийг асар их чулуун нуранги гэр орон, гэр бүлээс нь тусгаарлаж байсан юм. Тэдэнд хоол, ундны багахан л нөөц байв. Тэдэнд багаж хэрэгсэл нь ч, мөн мэдлэг нь ч байсан, гэхдээ тэд энэ ослоос өөрсдийгөө аварч чадахгүй байсан юм. Тэдэнд байсан ганц боломж бол аврах багийнхантай холбоо тогтоосноор аврагдах явдал л байлаа.

Нөхцөл байдал ийм байсан ч гэсэн тэд найдаж байсан юм. Тэд өөрсдийгөө зөв зохион байгуулж, хоол ундны нөөцөө гамтай хэрэглэж байв. Газар дээр байгаа хүмүүс тэднийг аврахын тулд чадах бүхнээ хийж байгаа гэдэгт тэд итгэж байлаа. Гэсэн хэдий ч газар доор, харанхуйд энэ найдвараа хадгалах тун амаргүй байсан болов уу. Өдөр хоног өнгөрсөөр хэдэн долоо хоног болов. Тэдний гамнаж хэрэглэж байсан хүнс ч дуусчээ.

Миний амьдралд ч бас асар их гамшиг болсон юм. Хамгаас хөөрхөн, гэрэл гэгээгээр дүүрэн найман настай хүү минь миний нүдэн дээр зам тээврийн ослоор нас барсан. Тэр зам дээр цус алдаж, сүнс нь тэнгэрлэг гэр рүүгээ буцах тэр мөчид би хүүгийнхээ биенийг тэвэрч байсан. Хүүг минь амьдруулаач гэж би Тэнгэрлэг Эцэгээс гуйсан хэдий ч энэ нь хүүгийн минь амьдралын төлөвлөгөөнд байгаагүй юм.

Би харанхуйд төөрч, уй гашуундаа дарагдсан байв. Би туйлдаж, амарч ч чадахгүй болж, мөнх бус амьдралын бэрхшээл нүдийг минь бүрхсэн байсан юм. Харуусан зүрхтэй байх гэдэг нь бодит мэдрэмж гэдгийг би ойлгосон. Зүрх байсан газарт маань зовиуртай харанхуй нүх бий болжээ.

Би үүнийг тэвчих тэнхээтэй байх ёстой гэдэгт итгэж байлаа. Олон хүн үүнээс ч илүү зовсон. Би хөдөлшгүй

**Чили улсад болсон уурхайн нурангиг
гацаад байсан 33 хүнтэй агил бэрхшээл,
сул дорой байдлаасаа болж мухардах үе
бигдэнд байдаг ч, авралын төлөвлөгөөгөөр
дамжуулан биг аврагдах найдварыг олж
авч чадна.**

чулуун нурангид дарагдсан уурхайчид шиг уй гашуугаас бий болсон ачаа дарамтаа өргөж дийлэхгүй байв.

Бид маш олон байдлаар гацаанд орж болдог. Зарим хүн хувийн бэрхшээл, сул талууддаа, эсвэл хүнд нөхцөл байдлуудад дарагддаг. Гэвч бид харуусал, гунигт автах үедээ мөнх бус амьдрал бол илүү хүчирхэгжих цаг хугацаа гэдгийг мэдсэнээр тайтгардаг. Бид Есүс Христээс найдварыг олдог.

Найдварын гэрэл

Осол болсноос хойших 17 дахь өдөр нурсан чулуун дундуур өрөмдөж, жижиг нүх гаргаснаар уурхайчдын найдвар сэргэсэн юм.

Гацаанд орсон эрчүүд өөрсдийнхөө амьд байгааг мэдэгдэхийг хүсэн, өрөмний гол төмрийг цохиж, дээр нь улаан балаар бичсэн зурвас бэхэлсэн байлаа. Үүн дээр “*Estamos bien en el refugio, los 33*” (“Бид гучин гурвуулаа хоргодох газарт аюулгүй байна”) гэж бичжээ. Найдвар сэргэв. Тэд оллоо.

Алим л багтахуйц жижиг нүхээр гадаад ертөнцтэй холбоо тогтоож чаджээ. Хайртай хүмүүсээс нь хоол, ус, эм, зурвас зэрэг зүйлийг уурхайчдад энэ нүхээр дамжуулж өгсөн байна.

Энэ нөхцөлд уурхайчдын сэтгэл санаа тогтворгүй байсан нь мэдээж. Хэдийгээр тэд олдсондоо ихэд

баярлаж байсан ч тэдний нөхцөл байдал хүнд хэвээр байлаа. Газар дээрх хүмүүс тэдний хаана байгааг мэдэж байсан ч аврах төлөвлөгөө боловсруулж, үүнийг ашиглахад хугацаа хэрэгтэй байв. Энэ төлөвлөгөө бүтэх эсэх нь ч тодорхойгүй байсан юм.

Аврагчид уурхайчдыг газрын гадаргуу дээр гаргахад хэдэн сар шаардлагатай гэдгийг итгэлгүйхэн хэлж байв. Тэд уурхайчдыг Христийн мэндэлсний баярын үеэр гэр бүлтэй нь уулзуулна гэж найдаж байсан бөгөөд энэ нь уурхайчид тэндээ дахин 4 сар байна гэсэн үг юм. Хэдий тийм ч тэд найдвар тээн хүлээж байв.

Бидэнд ч бас найдварын гэрэл байгаа. Энэ дэлхий бүтээгдэхээс өмнө биднийг аврах нэгэн төлөвлөгөө хийгдсэн юм. Тэнгэрлэг Эцэг биднийг мөнх бус байдал, нүгэл хилэнц, сул дорой байдлаас, мөн энэ амьдралд амсах бүх зүйлээс аврах Аврагчийг бидэнд өгсөн юм. Тэр бол найдвар, мөн амьдрал бэлэглэгч билээ. Тэрээр Тэнгэрлэг Эцэгтээ эргэн очиж, нас барсан хайртай хүмүүстэйгээ уулзах замыг бидэнд үзүүлсэн. Тэр бидний үүрч буй ачааг авахаар, мөн бидний нулимсыг арчиж, бидэнд амар амгаланг өгөхөөр бидний дэргэд зогсож байдаг. Түүний төлөвлөгөөг дагавал Тэр биднийг гэрт маань аваачих болно.

Аврах ажиллагаа

Уурхайчдыг аврахаар олон удаа оролдсон боловч өмнө нь тэдний байршлыг тогтоох гэж өрөмдсөн жижиг нүхнүүдийн нэгээр нь л нэг өрөм тэгшхэн орсон байна.

Уурхайчид аврах ажиллагаанд идэвхтэй оролцсон юм. Өрөм тэднийг чиглэн ирэх үед чулуу нурж, уурхайчдын гацсан газрыг дүүргэжээ. Чулуу унаж ирэхэд, тэд үүнийг зайлуулж, том өрмөнд зам гаргаж өгч байв.

Аврагчид нүхээр дээш доош явах бүхээг зохион бүтээжээ. Энэ бүхээгт нэг л хүн багтах зайтай байв. Бүхээгний голч нь 700 метр үргэлжлэх чулуун



Бид хүсэл бодлоо Аврагч Есүс Христэд хандуулах ёстой. Бидэнд зориулсан нэг л аврах төлөвлөгөө байгаа ба энэ нь Түүний цагаатгагч золиослолоор хийгддэг. Тэр биднийг аврахын тулд бүх зүйлээс доогуурт бууж ирсэн билээ.

нурангин дундуур ухсан нүхнээс 10 сантиметрээр нарийн байсан юм.

Уурхайчдыг аврах цаг болоход, уурхайчин бүр сонголт хийх хэрэгтэй болжээ. Бүхээгт нэг л хүн орж, ганцаараа дээш явах ёстой байлаа. Хүн бүр төлөвлөгөөнд итгэж, бүхээг нарийн цооногоор тэнцвэрээ алдаж, замдаа гацахгүйгээр дээшээ саадгүй явна гэж найдаж байв.

Энэ төлөвлөгөө бүтэхгүй бол бүх найдвар тасрах байлаа. Уурхайчин бүр бүхээгт орж, өөрийнхөө амь насыг энэ төлөвлөгөөнд болон аврагчдад даатгасан юм.

Уурхайчид нэг нэгээрээ харанхуйгаас гэрэл рүү дээш явсан ажээ. Тэднийг хайртай хүмүүс нь угтан авахыг дэлхий дахин харж, баясаж байлаа.

Аврах төлөвлөгөө амжилттай хэрэгжиж, нэг ч хүн эрсдээгүй юм. Тэд 2010 оны 10-р сарын 13-нд буюу уурхайн нуралтаас 69 өдрийн дараа, тэднийг олсноос хойш 52 хоногийн дараа аврагдсан билээ.

Есүс Христийн Цагаатгалд итгэ

Бид ч бас уурхайчидтай адил нэг нэгээрээ аврагддаг. Хэдийгээр хүн бүр аврагдах боломжтой ч, Аврагчтай харьцах бидний харилцаа нэн хувийн шинжтэй юм. Бид хүсэл бодлоо Аврагч Есүс Христэд зориулах ёстой.

Хүмүүний сонгох эрх нь ариун бөгөөд энэ мөнх бус амьдрал үүнд тулгуурлан үүссэн учраас Аврагч бидний хүслийг хүчээр авч чадахгүй. Бид сонгох эрх чөлөөтэй. Аврагч бидний шархыг эдгээж, биднийг мөнхийн аврал өөд өргөхөөр дэргэд маань хүлээж байдаг боловч Тэр үүнийг зөвхөн бидний урилгаар л хийж чадна. Бид Түүнийг сонгох ёстой. Бидэнд зориулсан нэг л аврах төлөвлөгөө байгаа ба энэ нь Түүний цагаатгагч золиослолоор хийгддэг. Тэр биднийг аврахын тулд бүх зүйлээс доогуурт бууж ирсэн билээ.

Хүүгээ алдсанаасаа болж гашуудан, өвдөг сөхөрч байхад миний аврал ирсэн юм. Уурхайчид бүхээгт орох тэрхэн агшин шиг би ч бас шийдвэрлэх үе дээрээ байлаа. Би бэрхшээлийг өөрийн хүч чадал, мэдлэгээр даван туулахыг хичээх үү, эсвэл Тэнгэрлэг Эцэгт хандан, тусламж хүсэх ёстой юу?

Уй гашуудаа дарагдсан би Бурханд хандах шийдвэр гаргасан билээ. Би Тэнгэрлэг Эцэгтээ хандахдаа хэчнээн их туйлдсанаа хэлж, миний харууслын ачааг өргөж өгөөч гэж гуйсан юм. Намайг залбирч дуусахаас

өмнө миний ачаа мөрөн дээрээс маань авагдсан. Хэдийгээр би шаналал, зовиурыг мэдэрч байсан ч, дийлдэшгүй ачаа минь алга болсон байж билээ.

Тэр үед би Аврагч бидний дэргэд зогсож, биднийг өргөж, Түүнээс гуйхыг маань хүлээн, ачаагаа Түүний мөрөн дээр тавихыг, мөн Түүнд гараа өгөхийг хүлээж байдаг юм байна гэдгийг ойлгосон юм.

Бүхээгний хаалгыг дотроос нь хаагаад, аврагчдад итгэсэн уурхайчидтай адил бид ч бас Аврагчид хүсэл бодлоо өгч, Түүний авралын төлөвлөгөөнд итгэх ёстой.

Би энэ амьдралаас дараачийн амьдрал өөд ганцаар явж, надаас түрүүлж одсон хүмүүстэйгээ уулзах үед тун их баярлаж, сэтгэл догдолно гэдэгтээ найдаж байна! Аврагч амьд бөгөөд энд байх хугацаанд намайг хайрлаж, миний дэргэд зогсож байдгийг би мэднэ. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.



АВРАГЧИЙН ЦАГААТГАЛ ТАНЫГ ӨРГӨЖ ЧАДНА

“Та нарын зам заримдаа хэцүү байх болно гэдгийг бид мэднэ. Гэвч та нар босож, бидний Гэтэлгэгч бөгөөд Аврагчийн зам мөрийг дагавал нэгэн өдөр эргэж хараад Цагаатгалд болон өөрсдийг тань өргөн дэмжиж, хүч чадлыг та нарт өгдөг үүний хүчинд итгэхээр сонгосондоо мөнхийн баяр талархлаар дүүрэн байх болно гэсэн амлалтыг би та нарт Их Эзэний нэрээр өгч байна.”

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф, “Та үүнийг хийж чадна!” *Лиахона, 2013 оны 11-р сар, 57.*





Санваар сэргээгдсэн АЛДАР СУУТ ӨДӨР

*Их Эзэн Өөрийн Сүмийг болон санваарыг дэлхий дээр
сэргээсэнд бид хэчнээн их талархвал зохилтой вэ.*

Аврагч Есүс Христ дэлхий дээр ирээд, хамгийн түрүүнд Өөрийн Сүмийг зохион байгуулсан. Тэр “залбирахаар ууланд гарч, бүхэл шөнийг Бурханд залбирсаар өнгөрөөв” хэмээн Шинэ Гэрээнд бичигдсэн байдаг. Маргааш өглөө нь Тэр бууж ирээд, Өөрийн төлөөлөгчдийг цуглуулан, “тэднээс арван хоёрыг сонгон, элч нар гэж нэрлэжээ” (Лук 6:12–13).

Дараа нь Тэрээр Петр, Иаков, Иохан нартай хамт ууланд гарч, Петр тэнд санваарын түлхүүрүүдийг хүлээн авсан (Матай 17:1–9; мөн 16:18–19-ийг үзнэ үү). Петр Аврагчийг явсны дараа дэлхий дээрх бүх түлхүүрийг атгаж, Сүмийг удирдах үүрэг хариуцлагыг хүлээн авсан байна.

Аврагчийн зааврын дагуу (Марк 16:15-ыг үзнэ үү) төлөөлөгчид сайн мэдээг номлож, Сүмийн салбаруудыг зохион байгуулав. Олон тохиолдолд тэд салбаруудаар нэг л удаа айлчлах боломжтой байсан учраас тэдэнд бусдад зааж, мөн сургах боломж хомс байсан юм. Удалгүй буруу номтны үзэл санаа шургалж, Аврагчийн сургаалын хэсгүүд өөрчлөгдөх буюу гуйвуулагдсан байна (Исаиа 24:5-ыг үзнэ үү). Урвалт тархахын хэрээр Их Эзэн санваарыг дэлхийгээс татан авах шаардлагатай болсон юм. Үүний үр дүнд дэлхий дээр хэсэг хугацааны турш санваарын адислалууд байхгүй болсон билээ.

Их Эзэн Өөрийн хаант улсыг санваарын хүчтэй хамт дэлхий дээр дахин байгуулахын тулд сайн мэдээг сэргээсэн юм.

Сэргээлтийг сана

Иосеф Смит Мормоны Номыг орчуулж, Оливер Каудери түүний бичээчээр үйлчилж байх үед тэд амилсан Аврагч Америк тивд айлчилсан түүхийг 3 Нифайгаас уншжээ. Тэд баптисмын талаарх Түүний заасан зүйлийг олж мэдээд (3 Нифай 11:23–28-ыг үзнэ үү), тухайн үед янз бүрийн байдлаар хийгдэж байсан баптисм болон хэн баптисм хүртээх эрх мэдэлтэй байх талаар бодож байв.

Иосеф, Оливер хоёр Их Эзэнээс асуухаар шийдэж, Иосеф, Эмма хоёрын гэрийн ойролцоох ой руу орж, залбирчээ. Иохан Баптист үзэгдэж, тэдний толгой дээр гараа тавин, “Миний нөхөд үйлчлэгч та нарт би Мессиагийн нэрээр, тэнгэр элчүүдийн тохинууллын хийгээд наманчлалын сайн мэдээний, мөн нүглүүдийн ангижралын тулд усанд умбуулалтаар хийх баптисмын түлхүүрүүдийг атгагч Аароны санваар хүртээж байна; мөн энэ нь Левийн хөвгүүд Их Эзэнд зөв шударга байдалд дахин өргөл өргөх хүртэл дэлхийгээс хэзээ ч дахин авагдахгүй байх болно” гэж хэлжээ (С ба Г 13:1).

Энэ бол алдар суут үйл явдал байлаа. 1829 оны 5-р сарын 15-нд Сүмийн түүхэнд тохиосон нэгэн ариун үйл явдлыг бүх санваартан санаж байгаа гэж найдаж байна.

Итгэлийн тунхагт “Сайн мэдээг номлох хийгээд үүний ёслолуудыг гүйцэтгэхийн тулд хүн бошиглолоор мөн эрх мэдэл бүхий тэдний гар тавилтаар Бурханаас дуудагдах ёстой гэдэгт бид итгэдэг” (Итгэлийн тунхаг 1:5) хэмээн бичигдсэн байдаг.

Хүн тохиолдлоор бус, харин илчлэлт ба бошиглолоор дуудагддаг. Санваарыг ашиглахаар дуудагдсан хүмүүст Их Эзэний илчлэлт шууд ирдэг. Их Эзэн Өөрийн Сүмийг ийм арга замаар удирддаг бөгөөд Тэр бошиглогч Иосеф Смитийг мөн ийм маягаар дуудсан юм.

Санваар хүртэхүйц зохистой бай

Санваар хүртэх нь зохих насанд хүрмэгц шууд өгөгддөг зан үйл биш юм. Бид “энэхүү хоёр санваарыг хүртэхэд . . . итгэлтэй” (С ба Г 84:33), мөн зөв зохистой байх ёстой. Бид санваарыг хүлээн авахад шаардлагатай нөхцөлүүдийг заадаг Мелкизедек санваарын тангараг ба гэрээг анхааралтай уншиж судлах ёстой:



“Тиймийн тул, санваарыг хүлээн авдаг тэд бүгд зөрчиж ч үл болох, мөн хөдөлгөж ч үл болох, Эцэгийн минь энэхүү тангараг хийгээд гэрээг хүлээн авдаг бөлгөө.

“Гэвч үүнийг хүлээн авсныхаа дараа уг гэрээг зөрчдөг, мөн үүнээс бүрмөсөн нүүр буруулах хэнд ч болов, энэ дэлхийд ч, мөн ирэх дэлхийд ч нүглүүдийн өршөөл байх нь үгүй” (С ба Г 84:40–41).

Энэ бол хөнгөмсөг хандаж болохгүй зүйл билээ. Эрэгтэй хүн Аароны болон Мелкизедек санваарыг хүлээн авахаас зайлсхийж болно гэж та нар бодож магадгүй, гэхдээ дараагийн шүлэг нь “энэхүү санваарт үл ирэх тэдэнд халаг” (С ба Г 84:42; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) хэмээн хэлдэг.

Хэрэв бид санваар хүлээн авч, зохистой амьдрах аваас Их Эзэний адислалуудыг хүлээн авдаг. Хэрэв бид гэрээгээ зөрчиж, санваараас нүүр буруулбал Их Эзэний адислалуудыг хүлээж авахгүй бөгөөд “Бурханы сонгосон хүмүүс” (С ба Г 84:34) болж чадахгүй.

Гэрээгээр хүлээн авагддаг Аароны санваар нь залуу эрэгтэйчүүдийг тангараг *ба* гэрээгээр хүлээн авагддаг илүү дээд Мелкизедек санваар хүлээн авахад бэлтгэдэг.

Бусдад үйлчил

Санваар бол ах дүүсэг агуу харилцаа бөгөөд дэлхий дээрх хамгийн агуу ахан дүүсэг харилцаа ч байж магадгүй. Санваартан ах нарын харилцаа нь гэр бүл доторхоос бусад харилцаанаас илүү хүчтэй байх ёстой. Ах дүүсэг харилцаанаас гадна санваар нь үйлчилдэг байгууллага бөгөөд бид бусдад үйлчилж, аливаа зүйлийг сайжруулахад өөрсдийгөө зориулдаг.

Залуу эрэгтэй Аароны санваар хүлээн авч; диконы, эсвэл багшийн юм уу, пристийн албанд томилогдох үеэс эхлээд санваарын чуулгад харьяалагддаг. Чуулга доторх ах дүүсэг харилцаа нь залуу эрэгтэй Мелкизедек санваар хүлээн авч, ахлагчийн албанд томилогдох хүртэл үргэлжилдэг. Санваарын чуулгууд бол маш чухал зүйл.

Номлолд явж буй нэг залуу эрэгтэй саяхан ариун ёслолын цутлаан дээр үг хэлсэн юм. Тэр дөрвөн найзтайгаа хамт диконы чуулгад явж эхэлсэн гэж тайлбарласан. Тэд бэрхшээл тохиолдох үед, мөн Аароны санваарын албадад томилогдох үед бие биедээ дэмжлэг үзүүлж байсан нь тэдэнд бүрэн цагийн номлолд үйлчлэх зорилгодоо хүрэхэд нь тусалсан гэж тэр хэлж билээ.

Би нэг чуулгад харьяалагддаг. Энэ нь маш онцгой чуулга. Энэ нь өөр өөр ажил мэргэжилтэй эрэгтэйчүүдээс бүрдсэн чуулга. Гэхдээ бид чуулгаараа ажиллах үедээ зорилгоороо нэгддэг.

Чуулгын гишүүд аливаа зүйлийг дагахаар санал нэгдэж, Ариун Сүнсний нөлөөн дор хамт үйлдэх үедээ Их Эзэний хүслийн дагуу үйлддэг. Чуулгын гишүүд бүрэн санал нийлэх хүртэл ах нар аливааг хийдэггүй. Энэ нь та нарыг амьдралын тань турш хэрхэн хамгаалж болохыг бодоод үз.

Санваар бол ах дүүсэг агуу харилцаа бөгөөд дэлхий дээрх хамгийн агуу ахан дүүсэг харилцаа ч байж магадгүй.

Чуулга бүрийн удирдагч чуулгынхаа гишүүдийн нэрсийн жагсаалттай байх ёстой бөгөөд яаж амьдрахаа сайн мэдэхгүй байгаа хүмүүсийг мэдэж байх ёстой. Хэрэв чуулга дотор ийм залуу эрэг-

тэйчүүд байвал удирдагч нь тусламж хэрэгтэй байгаа хүмүүст эн тэргүүнд анхаарлаа хандуулбал зохино. Дараа нь удирдагч ба чуулгын бусад гишүүн тэдэн дээр айлчилж, тэдэнтэй найз болж, тэднийг буцааж ирүүлэх арга замаар чуулгын нэг хэсэг болгох хэрэгтэй.

Аароны санваарын чуулга нь “сануулж, тайлбарлаж, ухуулж, мөн зааж, Христэд ирэхэд бүхнийг урих” (С ба Г 20:59) үүрэгтэй. Санваарын чуулга дахь үйлчлэл нь дэлхий дээр биднийг өсөж хөгжихөд амин чухал юм. Тиймээс бүх чуулгын гишүүд эдгээр үүргийг Тэнгэрлэг Эцэгийн хаант улс дахь үйлчлэх үүрэг гэж авч үзэх ёстой.

Мөнх бус амьдралд бид бэрхшээлүүдтэй тулгардгийг бид бүгд мэддэг. Амьдралын маань туршид бидэнд туслах дэмжлэг байхгүй бол биднийг удирдан чиглүүлэх бат бөх төлөвлөгөө, зүт чиг, эсвэл газрын зураг байхгүй байх болно. Сайн ажиллаж байгаа чуулга нь Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд буцаж очиход биднийг удирдах төлөвлөгөө, газрын зургийг бий болгоход бидэнд тусалдаг.

Талархалтай бай

Бишопууд тойргоо тэргүүлэх түлхүүрүүдийг атгадаг бөгөөд үүнд Аароны санваартай залуу эрэгтэйчүүд багтдаг. Бишоп нь чухамдаа тойргийнхоо пристүүдийн чуулгын ерөнхийлөгч юм. Тэр залуу эрэгтэйчүүдэд Аароны санваар хүлээн авч, албадад томилогдон, Мелкизедек санваар хүлээн авахад бэлтгэхэд нь тусалдаг. Тэрээр санваартнуудын үүрэг хариуцлага, үүнээс ирдэг адислалуудыг ойлгоход тэдэнд тусалдаг. Тэр тэдэнд бусдад үйлчилж, тохинуулахад нь туслах үүрэг даалгавар өгөх замаар санваараа эрхэмлэн биелүүлэх талаар суралцахад нь тусалдаг.

Аароны санваарт хамааралтай түлхүүрүүд нь бидэнд сэргээгдсэн санваарт болон үүний хүч, эрх мэдэл, үүргүүдэд талархаж байх ёстойг сануулдаг: “Доод буюу Аароны санваарын хүч хийгээд эрх мэдэл бол тэнгэр элчүүдийн тохинууллын түлхүүрүүдийг атгах, мөн гаднах ёслолууд, сайн мэдээний заавар, нүглүүдийн ангижралын тулд наманчлалын баптисм, гэрээнүүд хийгээд зарлигуудад нийцүүлэн гүйцэтгэх нь болой” (С ба Г 107:20).

Би залуу эрэгтэйчүүдийг өөрсдөдөө байгаа санваарыг хүндэтгэж, Мелкизедек санваар хүлээн авах нэмэлт адислалд бэлтгэхийн тулд Аароны санваарын бүх албанд томилогдож, бүрэн цагийн номлогчоор Их Эзэнд үйлчлэхэд, мөн ирээдүйд Түүний ариун сүмд гэрлэхэд уриалж байна.

Энэ Сүмийг ямар ч мөнх бус хүн удирддаггүй гэдгийг би гэрчилж байна. Энэ бол Аврагчийн Сүм бөгөөд Тэр үүнийг санваараар удирддаг. Тэр энэхүү эрх мэдлийг дэлхий дээр эрэгтэйчүүдэд итгэмжлэн олгодог бөгөөд тэд Түүний Сүмийг удирдаж, ариун нандин ёслолуудыг гүйцэтгэх ажилд Түүнийг төлөөлдөг. Их Эзэн Өөрийн Сүмийг болон санваарыг дэлхий дээр сэргээсэнд бид талархдаг байх ёстой. ■





ЖАСТИН КУНЗИЙН УРАН ЗУРАГ

Шавь байх

ТАЛААР АВРАГЧИЙН ЗААСАН ЗҮЙЛС

*Иерусалимд сүүлчийн удаа ирсэн Есүс Христийн аяллын
тухай өгүүлдэг Лукийн номонд Аврагч бидэнд Өөрийг
нь дагах тодорхой загварыг өгсөн байдаг.*

Кэйси В.Олсон

Институт ба семинар

Аврагч нас барахаасаа дөрвөн сарын өмнө, “Түүний дээш аваачигдах өдрүүд ойртож байсан үед Есүс шийдвэртэйгээр Иерусалимыг зорьлоо” (Лук 9:51).¹ Дараагийн долоо хоногуудад Есүс Өөрийн шавь нарыг удахгүй тохиолдох бэрхшээлүүдэд болон агуу сүнслэг үйл явдлуудад сайтар бэлтгэж байв.

Жишээ нь, Есүс Христийн тэнгэрлэг байдлыг Петр Цезарь Филиппийн нутагт гэрчилсний дараа Аврагч ойртож буй Өөрийн үхэл болон амилалтын талаар шавь нартаа анх удаа тодорхой, шууд ярьсан (Матай 16:13–21; Марк 8:27–31; Лук 9:18–22-ыг үзнэ үү).² Есүс түүнчлэн Петр, Иаков, Иохан нарыг Өөртэйгээ хамт дагуулж “өндөр ууланд гарчээ,” Тэр “тэдний өмнө хувирч өөрчлөгдөв” (Матай 17:1–2). Тэнд Аврагч, Мосе, Елиа нар санваарын түлхүүрүүдийг Петр, Иаков, Иохан нарт олгов. Мосе, Елиа хоёр “Иерусалимд гүйцээгдэх Түүний үхлийн тухай ярьж” (Лук 9:31) байхдаа Есүст тайтгарал, дэмжлэг үзүүлжээ.³ Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэймс И.Талмэж (1862–1933) уулан дээрх энэхүү явдлыг Есүс Христийн мөнх бус тохинууллын “төгсгөлийн эхлэл” хэмээн хэлжээ.⁴

Есүс Христ “шийдвэртэйгээр Иерусалимыг [зорих]” үедээ Өөрийнх нь үхлээр төгсөх аяллыг хийх гэж байгаагаар сайн мэдэж байсныг эдгээр үйл явдал харуулдаг. Энэ аяллын талаарх хамгийн дэлгэрэнгүй мэдээллийг өгдөг Лукийн номонд Аврагч “Тэр Иерусалим орох замдаа нэг хот, суурингаас нөгөө уруу нь дамжин сургаалаа заасаар явлаа” (Лук 13:22), эрэгтэй, эмэгтэй шавь нар нь Түүнтэй хамт аялав (Лук 11:27-г үзнэ үү).⁵ Есүс тэдэнтэй хамт алхаж байхдаа дагалдагчдаа шавь байх шаардлагын талаар заажээ. Бид Аврагчийн заасан зүйлсийг энэ аяллын хүрээнд авч үзвэл, Тэр шавь байх талаар өгсөн удирдамжуудаа хэрхэн Өөрийнхөө жишээгээр батлан харуулсанд илүү их талархах болно.

Есүс Христийн “Намайг дага” хэмээх удирдамж дахь гурван хариулт

Аврагч Иерусалим руу аялах сүүлийн аяллынхаа өмнөхөн: “Хэрэв хэн нэгэн нь миний араас явахыг хүсвэл, тэр нь өөрийгөө үгүйсгэг. Загалмайгаа үүрч намайг дагаг” (Лук 9:23) хэмээн тунхаглажээ. Дараа нь Есүс шавь нартайгаа Иерусалим руу аялж байхад, “хэн нэг нь Түүнд би Таныг хаа ч явсан дагая гэв” (Лук 9:57). Аврагч “Хүний Хүүд толгой хоргодох ч газар байхгүй” (Лук 9:58) хэмээн хариулсан бөгөөд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холландын хэлснээр үүгээрээ “түүний амьдрал амар хялбар биш” бөгөөд Түүнийг дагахаар сонгосон хүмүүсийн хувьд ч гэсэн “энэ нь ихэнхдээ ийм байх болно” гэдгийг хэлж байсан байж болох юм.⁶

Дараа нь Их Эзэн “өөр нэгэнд Намайг дага гэхэд,” (Лук 9:59), тэр хүн эхлээд явж, эцгээ оршуулахыг надад зөвшөөрөөч гэжээ. Есүс “Үхэгсдийг үхэгсдээр нь оршуулуул. Харин чи явж, Бурханы хаанчлалыг газар бүр тунхагла гэв” (Лук 9:60).⁷ Аврагчийн хэлсэн үг нь нас барсан хайртай хүнийхээ араас гашуудаж болохгүй гэсэн үг биш (С ба Г 42:45-ыг үзнэ үү). Харин энэ нь Их Эзэнд бүхнээ зориулах нь шавь хүний хамгийн эн тэргүүнд тавих зүйл гэдгийг хэлж байгаа юм.

Гурав дахь хүн “Эзэн, би Таныг дагана. Эхлээд гэрийнхэнтэйгээ салах ёс гүйцэтгэхийг Та зөвшөөрөөч [гэжээ]” (Лук 9:61). Есүс ардаа байгаа зүйлээс илүү урдаа байгаа ажилдаа анхаарал хандуулдаг тариачин хүний

зүйрлэлээр хариулсан юм (Лук 9:62-ыг үзнэ үү). Энэ хүнд өгсөн сургамж нь “шийдвэртэйгээр Иерусалимыг [зорьж]” (Лук 9:51), мөн эргэж хараагүй Аврагчийн үлгэр жишээг дагах явдал байсан юм.

Самаригаар дайрч өнгөрөх зам

Есүс дагалдагчидтайгаа Иерусалим орох замдаа Самаригаар дайрч өнгөрөхөд зарим самари хүн “Түүнийг хүлээн [аваагүй]” (Лук 9:53) бөгөөд тэд Есүсийг шавь нартай нь иудейчууд гэж таньсан учраас ингэсэн байж болох юм.⁸ Хариуд нь Иаков, Иохан хоёр тэдний эсрэг

Сайн санаат самари хүнтэй

адилаар Есүс тааралдсан

өвчтэй, зовлонтой хүн

бүрд тохинуулсан юм.

тэнгэрээс гал буулгах зөвшөөрөл хүсчээ (Лук 9:52–54-ийг үзнэ үү). Энэ эгзэгтэй нөхцөл байдалд Аврагч тэвчээр ба хүлцэнгүй байдлыг харуулж, шавь нартаа мөн адил үйлдэхийг анхааруулсан (Лук 9:55–56-г үзнэ үү).

Энэ явдлаас хойш удалгүй Аврагч сайн санаат самари хүний тухай сургаалт зүйрлэл ярьжээ (Лук 10:25–37-г үзнэ үү). Энэ сургаалт зүйрлэл нь шударга бус хуульчийн асуултанд хариулахын зэрэгцээ “хөршөө өөрийн адил хайрла” (Лук 10:27; мөн 25–29-р шүлгүүдийг үзнэ үү) хэмээх зарлигт ямар ч ялгаварлах үзэл байдаггүй гэдгийг Аврагчийн шавь нарт сануулсан байж болох юм.

Үүний зэрэгцээ, сайн санаат самари хүн, Есүс хоёрын үйлдлүүд адил төстэй байгааг Аврагчийн шавь нар анзаарсан байж магадгүй. Иудей хүнийг хайрласан сайн санаат самари хүний хайр нь өсөрхөг самаричуудад үзүүлсэн Есүсийн энэрлийг харуулсан юм. Түүнчлэн дараагийн долоо хоногуудад Иерусалим орох замд Есүс өвчтэй олон хүнтэй тааралдахыг Аврагчийн шавь нар харсан билээ (Лук 13:10–17; 14:1–6; 17:11–19; 19:1–10-ыг үзнэ үү). Аюултай бөгөөд хулгайч нар үүрлэсэн зам дээр зогсож, өөрөөсөө илүү өөр хүний сайн



сайханд санаа тавьсан сайн санаат самари хүнтэй адил Өөрийнх нь үхэл ойртож байсан үед Есүс замдаа тааралдсан өвдөж, зовсон хүн бүрд тохинуулж байсан юм.

Аврагч Мариа, Марта хоёрт заав

Иерусалим орох замдаа Есүс Мартагийн гэрээр ороод гардаг (Лук 10:38-ыг үзнэ үү). Марта “үйлчлэх ажилдаа түүртэж” байхад (Лук 10:40), түүний охин дүү Мариа “Эзэний хөлд суугаад үгийг нь сонсож байлаа” (39-р шүлэг). Бусдыг зочилж, дайлах нь иудейчуудын нийгэмд маш чухал зүйл байсан ба Марта ёс заншлаа дагаж, гэрийн эзэгтэйн хувьд үүргээ биелүүлж байсан юм.⁹

Марта хэдийгээр өөр тохиолдолд Аврагчид бүхнээ зориулж байгаагаа болон итгэлээ харуулж байсан ч (Иохан 11:19–29-ийг үзнэ үү), тэр энд “Эзэн, дүү минь үйлчлэх ажилд намайг ганцаар орхисныг Та анзаарахгүй байна уу? Надад тусал гэж түүнд хэлээч гэв” (Лук 10:40). Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Даллин Х.Өүкс энэ түүхээс чухал сургамж авахад нь Сүмийн гишүүдэд туслахын тулд Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалт дээр профессор Катэрин Корман Парригийн хэлсэн үгийг эш татсан юм:

“Их Эзэн гал тогоонд орж, Мартад хоол хийхээ болиод, сонс гэж хэлээгүй. Харин тэр дүүгээ үйлчилсэнгүй гэж шүүмжлэх хүртэл Их Эзэн түүний үйлчлэлд сэтгэл хангалуун байсан. . . . Марта завгүй байснаас болоогүй, харин *бардамналаасаа* болж Их Эзэний ээмлэлийг хүртсэн юм.”¹⁰

Мартагийн энэ үед гаргасан том алдаа нь тэр бусдад үйлчилж байхдаа ч гэсэн өөрийгөө бодож байсан явдал юм. Их Эзэнд болон бусдад үйлчлэх нь зөвхөн хангалттай биш гэдгийг ойлгоход Аврагч Мартад тусалсан. Бид үйлчилж, Их Эзэний хүслийг эрэлхийлснээр хүсэл,

сэтгэл, үйлдлүүдээ Түүгээр удирдуулж сурах юм (Лук 9:24; С ба Г 137:9-ийг үзнэ үү). Шавь нар эхлээд өөрсдийгөө бодох хандлагыг даван туулж, Тэнгэрлэг Эцэг болон Түүний хүүхдүүдийн төлөө, “[Түүний] алдар суугийн төлөө бүхнээ зориулан” (С ба Г 88:67) үйлчлэхийг сурах ёстой. Хожим ах нь нас барсны дараа Марта Аврагчийн ирж байгааг дуулаад, бүх зүйлээ орхиж, Түүнтэй уулзах гэж очсоноороо итгэлээ үзүүлсэн юм (Иохан 11:19–20-ийг үзнэ үү).

Аврагч шавь байхад шаардлагатай зүйлүүдийн талаар заав

Аврагчийг Иерусалим орох замд нэг хүн “Багш аа, гэр бүлийн өвийг надтай хуваалц гэж ахад минь хэлээч” (Лук 12:13) гэж хэлжээ. Аврагч энэ хүний асуудлын голыг нь олж хариулан, “Шуналын алив хэлбэрээс өөрсдийгөө хамгаал, болгоомжил. Учир нь элбэг хангалуун нэгний амь өөрийнх нь өмч хөрөнгөнөөс хамаардаггүй юм гэв” (Лук 12:15). Дараа нь тэр мунхаг баян хүний тухай сургаалт зүйрлэлийг ярьжээ (Лук 12:16–21-ийг үзнэ үү).

Сургаалт зүйрлэлд Бурхан баян хүнийг мунхаг гэж дүрсэлсний нэг шалтгаан нь түүний харамч занг харуулсан байж болох юм. Лук 12:17–19 дээр баян хүн *би* болон *миний* гэсэн үгсийг 11 удаа хэрэглэж, өөрийгөө л бодож байснаа харуулдаг.¹¹ Тэр хүн харамч сэтгэлдээ эзэмдүүлээд зогсохгүй, эд баялаг нь ямар эх сурвалжаас ирснийг ойлгоогүй юм. Тэр хүн Аврагчийн хэлснээр “газар нь маш үржил шимтэй байжээ” (Лук 12:16) гэдгийг огт ойлгоогүй бөгөөд ургац өгдөг газар дэлхийг бүтээсэн Их Эзэнд ер талархаагүй билээ. Эцэст нь тэр хүн цаг зуурын зүйлийг нөөцөлснөөс болж биш, харин ирээдүйдээ сүнслэг байдлаараа бэлтгээгүйгээс болж шийтгүүлсэн юм. “Бурханы өмнө баян биш” (Лук 12:21)



байсан тэр хүн дэлхий дээр хуримтлуулсан эрдэнэсээ алдаад зогсохгүй “тэнгэрт шавхагдашгүй баялгийг” (Лук 12:33) алдсан юм. Энэ амьдралд хийсэн сонголт нь түүнийг мөнх амьдралд ядууруулсан юм.

Гэнэт нас барахаасаа өмнө цаг зуурын эд зүйл нөөцөлсөн энэ мунхаг хүнтэй адилгүй нь, Есүс Өөрийнхөө үхэл рүү зорилготой алхаж, Өөрт байгаа бүхнийг болон Өөрийгөө—Өөрийн амьдрал, бүх хүслийг Бурханд өгөхөөр явсан юм (Лук 22:42; Мозая 15:7-г үзнэ үү). Тэрээр “Харин хүртэх ёстой нэгэн баптисм Надад байна. Үүнийг гүйцэлдтэл Би ямар их зовно

*Бид Мариа, Марта хоёртой адил
үйлчилж, Их Эзэний хүслийг
эрэлхийлж сурах ёстой.*

вэ!” хэмээн тунхаглажээ (Лук 12:50). Тэр аль хэдийн усаар баптисм хүртсэн байсан болохоор Есүс Өөрийн Цагаатгалын талаар ярьж байжээ. Удалгүй Тэр бүхнээс доогуурт бууж ирэн, бидний нүглүүдийн төлөө зовж, бидний өвчин, шаналлыг мэдрэх үед Түүний бие махбод цус, хөлсөндөө нэвчсэн юм.¹²

Дараа нь хэсэг фарисайчууд Херод Антипас Түүнийг алахыг оролдох болно гэж Есүст анхааруулахад Аврагч зааж, адисалж, мөн бусдыг эдгээх боломж бүрийг ашиглана гэдгээ батлан хэлсэн (Лук 13:31–33-ыг үзнэ үү). Тэр мөнх бус амьдралынхаа сүүлчийн өдрүүдийг бүхий л өдрийн адил бусдад үйлчлэхэд зориулсан билээ.

Есүс Иерусалимд ойртох үед шавь байхын үнэ цэнийг тооцож, Түүнийг дагах шийдвэрээ дахин бодож үзэхийг шавь нартаа хэлсэн билээ (Лук 14:25–28-ыг үзнэ үү). Хэрэв тэд шавь нар байж, үргэлжлүүлэн Түүнийг дагасан байлаа ч, амсах зүйлүүдийг нь Тэр хөнгөвчлөхийг оролдоогүй юм. Харин Тэр: “Иймээс та нарын хэн нь ч байгаа бүхнээсээ эс татгалзвас Миний шавь байж чадахгүй” (Лук 14:33) хэмээн шулуухан хэлсэн. Гэвч


бид жинхэнэ шавийн замаар явбал хариуд нь илүү их зүйлийг болон “энэ дэлхий дэх амар амгалан хийгээд ирэх дэлхий дэх мөнх амьдралыг” (С ба Г 59:23) авах болно гэж Аврагч амлажээ.

Хэдийгээр бидэнд Есүс Христтэй хамт Иерусалим руу алхах боломж байхгүй ч, бид энэ аялалд хамт явах хүслээ амьдралдаа харуулж чадна. Тэнгэрлэг Эцэгийн хүслийн дагуу золиослол хийж, мөн үйлчлэх Аврагчийн хүслийг санах нь бидэнд “явж, үүний адил [үйлдэх]” (Лук 10:37) хүч чадлыг өгч чадна. ■

ЭШЛЭЛҮҮД

1. А.Б.Брюс, *The Training of the Twelve* (1971), 240-ийг үзнэ үү.
2. Аврагчийн тохинуулал болон Түүний зовлон ба үхлийн талаарх судруудад дараах эшлэлүүд багтдаг: Матай 9:15; 16:4; Иохан 2:19; 3:14.
3. Жэймс Э.Талмэж, *Jesus the Christ*, 3 дахь хэвлэл (1936), 373-ыг үзнэ үү.
4. Жэймс Э.Талмэж, *Jesus the Christ*, 373.
5. Марк, Матайн ном нь Аврагч Галилаас сүүлийн удаа явж, Иерусалим руу хийсэн аяллыг товчхон дурдаг бол (Матай 19:1–2; Марк 10:1-ийг үзнэ үү), Лук энэ аялалд маш их анхаарал хандуулсан байдаг (Лук 9:51–53; 13:22, 34; 17:11; 18:31; 19:11-ийг үзнэ үү). Иоханы сайн мэдээ Матай, Марк, Лукийн сайн мэдээнээс нэлээд ялгаатай ба Аврагчийн Галилаас Иерусалим руу хийсэн сүүлчийн аяллыг дурдаггүй.
6. Жэффри Р.Холланд, “The Inconvenient Messiah,” *Ensign*, 1984 оны 2-р сар, 68.
7. Эцэг эхээ хүндлэх ба тэднийг зохих ёсоор оршуулах үүрэг хариуцлага нь Иудей соёлд маш чухал зүйл юм. Хүний биеийг оршуулганд бэлтгэж, булшинд хийсний дараа гэр бүлийн гишүүд нь яснуудыг оссуари гэдэг чулуун хайрцганд хийхээр нэг жилийн дараа эргэн ирдэг бөгөөд энэ хайрцаг нь хоёр дахь оршуулга болж, гэр бүлийн бусад нас барсан гишүүнийхтэй хамт үлддэг. (Richard Neitzel Holzapfel, Eric D. Huntsman, and Thomas A. Wayment, *Jesus Christ and the World of the New Testament* [2006], 78–79-ийг үзнэ үү.) Энэ тохиолдолд тэр шавь саяхан нас барсан аавынхаа эхний биш, харин хоёр дахь оршуулгыг ярьж байсан бол түүний хүсэлт нь тэр соёл уламжлалаа Бурханы Хүүтэй хамт Иерусалим руу явж, Түүнээс сурах боломжоос дээгүүр тавьсныг харуулж байна.
8. Христийн үед иудейчууд болон самаричууд бие биенээ маш ихээр үзэн яддаг байжээ. Энэ хоёр үндэстний хүмүүс бие биетэйгээ ойртохоос зайлсхийдэг байв. Энэ тохиолдолд самаричууд Есүсийг болон Түүний шавь нарыг зочилж, гэртээ оруулаагүй нь тодорхой юм. (Richard Neitzel Holzapfel and Thomas A. Wayment, *Making Sense of the New Testament* [2010], 140; Ralph Gower, *The New Manners and Customs of Bible Times* [1987], 241–242-ыг үзнэ үү.)
9. Говэр, *New Manners and Customs of Bible Times*, 244–245; Фрэд Х.Вэйт, *Manners and Customs of Bible Lands* (1953), 69–77-г үзнэ үү.
10. Далин Х.Өүкс, “Judge Not and Judging,” *Ensign*, 1999 оны 8-р сар, 12–13; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
11. Жэй А.Пэрри, Доналд В.Пэрри, *Understanding the Parables of Jesus Christ* (2006), 122-ыг үзнэ үү.
12. Лук 22:44; Алма 7:11–13; Сургаал ба Гэрээ 19:18; 88:6-г үзнэ үү.





ХҮМҮҮСИЙН Загасчид

*Сүмийг удирдах дуудлага хүлээн авсан хүмүүс
Аврагчийн өгсөн, хүмүүсийн загасчид болох
урилгыг хүлээн авсан байдаг.*

Эхнэр бид хоёр Хавайд жижигхэн гэр бүлээ өсгөж байхдаа биднийг дэмждэг байсан гайхалтай хожмын үеийн гэгээнтнүүдэд талархдаг байв. Энэ эрхэм гишүүд биднийг халуун дотно хүлээн авч, бидэнд өөрсдийн гэр бүл шигээ хандсан юм. Зарим үед тойргийн ах нар далайд загасчлахаар явахдаа манай бяцхан хүүг авч явдаг байлаа. Эдгээр загасчлах аялалд завь хэрэглэгддэггүй байсан бөгөөд эртний хавайчуудын боловсруулсан аргаар загасчилдаг байв.

Энэ аргыг ашиглан загасчлахын тулд чадварлаг загасчин тороо нямбай гэгч эвхэж, давхарлана. Торны доод талд хүндрүүлэгч байдаг. Тэр тэгээд тороо хадархаг эрэг дээгүүр барьж яваад, цэнгэг устай хэсэгт очно. Тэр цөөрөмд загас орж ирэхийг хараад, яг зөв цагтаа тороо чадварлагаар шиддэг бөгөөд тор нь бүх талаараа сунаж, том тойрог болон доош унахдаа бөөгнөрсөн загаснуудыг барьдаг юм.

Загасчны чадвар сайн ч гэсэн цэвэрхэн оёсон, цоорхойгүй, бүтэн тор байхгүй л бол түүний чармайлт талаар болно.

Туршлагатай загасчны амжилт хэр сайн тортой вэ гэдгээс шалтгаалдаг бөгөөд тороо бүрэн бүтэн байгаа

эсэхийг нэгд нэггүй шалгаж үзэх хүртэл үр бүтээлтэй загасчлал эхэлдэггүй.

Бид загасчилж амьдардаг байсан анхны төлөөлөгчдийн амьдралаас энэ зарчмын ойлголтыг харж болно. Бид ирээдүйн Багштайгаа анх уулзах үедээ тороо хаяж, засаж, угааж байгаа эдгээр загасчинтай Матай, Марк, Лук номын эхний бүлгүүдэд танилцдаг (Матай 4:18, 21; Марк 1:16, 19; Лук 5:2-ыг үзнэ үү). Эдгээр эрэгтэй өөрсдийн болон бусдын гэр бүлийг тэжээхийн тулд өдөр бүр загас барьж, хөдөлмөрлөдөг байсан. Амьдрал ба гэр бүл нь тэдний чадвараас, мөн торны бүрэн бүтэн байдлаас хамааралтай байв.

Есүс тэднийг “Намайг дага, Би та нарыг хүмүүсийн загасчин болгоно гэв,” “Тэд тэр даруй тороо орхиж,” “бүхнийг орхин, Түүнийг дагалаа” (Матай 4:19, 20; Лук 5:11; мөн Марк 1:17–18-ыг үзнэ үү).

Би энэ жишээний талаар олон удаа бодож байсан. Сүмийг удирдаж буй хүмүүс “намайг дага” хэмээх урилгад үүнтэй адил итгэлээр хариулсан байдаг. Эртний Сүмтэй адил Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь бошиглогч, төлөөлөгчдөөр удирдуулдаг бөгөөд тэд тороо буюу маш ихийг хийж байж олж авсан мэргэжлээ орхиж, Их Эзэнийг дагахын тулд шинэ чадвар олж авсан хүмүүс юм.

Хүмүүсийн удирдагчид

“Хүмүүсийн загасчид” болно гэдэг нь ямар утгатай вэ? Аврагч эртний төлөөлөгчдөд өгсөн урилгынхаа энгийн үгсээр дамжуулан Өөрийн сургаалыг заах гол хэлбэр болох сургаалт зүйрлэлийг танилцуулсан юм. Түүнийг дагахаар дуудагдсан хүмүүс тодорхой хэмжээгээр “хүмүүсийн загасчид” гэдэг үгийг ойлгоно гэдгийг Тэр мэдэж байсан.

Ерөнхийлөгч Харолд Б.Лий (1899–1973) “хүмүүсийн загасчин” болно гэдэг нь ‘хүмүүсийн удирдагч болно’ гэсэн утгатай юм. Өнөөгийн хэллэгээр бол . . . : ‘Хэрэв та нар миний зарлигуудыг сахивал, би та нарыг хүмүүсийн удирдагч болгоно.’”¹ хэмээн заажээ

Хүмүүсийн удирдагч нь бусдыг “Есүс Христийн үнэн дагалдагчид” (Моронай 7:48) болоход нь туслахын тулд дуудагдсан юм. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* товхимолд “Үүнийг хийхийн тулд удирдагчид юуны өмнө Аврагчийн итгэлтэй шавь нар байхыг цаг үргэлж хичээх ёстой бөгөөд ингэснээр Бурханы оршихуйд эргэж очих болно. Тэгвэл тэд бат бөх гэрчлэлийг хөгжүүлж, Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт улам ойртоход нь бусдад тусалж чадна”² хэмээн заасан байдаг.

Сүмийг удирдах дуудлага хүлээн авсан хүмүүс Аврагчийн өгсөн хүмүүсийн загасчид болох урилгыг хүлээн авсан байдаг.

Загасны тор болон зөвлөлүүд

Сүмийн хамгийн дээд түвшний удирдлагаас Аароны санваарын чуулга, Залуу эмэгтэйчүүдийн бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл хүртэл удирдагчид зөвлөл болж зохион байгуулагддаг. Удирдагчид

сүнслэгээр бэлтгэгдэж, зөвлөлүүдэд бүрэн оролцон, бусдад тохинуулж, Есүс Христийн сайн мэдээг заахаар, мөн санваарыг болон Сүмийн туслах бүлгүүдийг удирдахаар зааварлагдсан байдаг. Мөн тэд Сүмд нэгдмэл байдлыг бий болгож, бусдыг удирдагч ба багш болоход бэлтгэж, бусдад ажил үүрэг даалган, хариуцлагыг төлөвшүүлдэг.³

Эртний төлөөлөгчид загасчлах мэдлэгээ ашиглан хүмүүсийн загасчид болсонтой адил бид тэдний тор хэрэглэдэг арга барил дахь зарчмуудыг Сүмийн зөвлөлдөө ашиглаж болно. Эдгээр зөвлөл нь тортой адил Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийг цуглуулахын тулд зохион байгуулагдаж, бэлтгэгдсэн байдаг. Зөвлөлийн гишүүн бүр торны салшгүй чухал хэсэг юм. Тор бүрэн бүтэн байхдаа хэрэгтэй байдгийн адил, зөвлөлийн гишүүд зохион байгуулагдаагүй, төвлөрөөгүй, мөн зохих байдлаар ажиллахгүй байгаа үед зөвлөл үр дүнтэй ажилаж чадахгүй.

Зөвлөлүүдийн удирдагчид эдгээр “тороо” тогтмол шалгаж, мөн засах замаар эртний загасчин төлөөлөгчдийн жишээг дагадаг. Зөвлөлийн удирдагчид тогтмол сургалт өгч, зөвлөлийн хурлуудыг удирдаж, зөвлөлийн гишүүдэд цагаа олсон, тохиромжтой зөвлөгөөг өгч, мөн хайр, урам зориг, магтаалаар дамжуулан үүнийг хийдэг.



Бүрэн ажиллаж байгаа зөвлөлийн хүч чадал ба бусдыг аврах чадварыг орлох ямар ч зүйл байхгүй.

Тойргийн зөвлөл

Сүмийн гишүүн бүрд нөлөөлөх хамгийн их боломжтой зөвлөл бол тойргийн зөвлөл юм. Энэ зөвлөлд байдаг эрэгтэй, эмэгтэй хүмүүс бишопын удирдлага дор тойрог дахь авралын ажлыг удирдах үүрэг хариуцлагатай учраас үнэхээр хүмүүсийн загасчид байхаар дуудагдсан хүмүүс юм. Тэд тус тусынхаа тойрогт амьдарч, үйлчилдэг бөгөөд тэнд тэд удирдахаар дуудагдсан хүмүүстэйгээ холбоотой байдаг.

“Тойргийн зөвлөлийн гишүүд гэрчлэлтэй болж, авралын ёслолуудыг хүлээн авч, гэрээнүүдийг сахин, Есүс Христийн ариуссан дагалдагчид болоход нь хүмүүст туслахыг хичээдэг (Моронай 6:4–5-ыг үзнэ үү). Тойргийн зөвлөлийн нийт гишүүд тойргийн гишүүдийн сайн сайхан байдлын төлөө хариуцлага хүлээдэг.”⁴

Тойргийн зөвлөлийн гишүүд авралын ажлыг яаравчлуулах ажилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тойргийн зөвлөл бүрэн ажиллахгүй байвал ажил удааширдаг. “Торны” цуглуулах чадвар суларвал, зөвлөлийн хүчин чармайлт ч бага үр дүнтэй байх болно. Гэхдээ тойргийн зөвлөл зохион байгуулагдаж; хувь хүн, гэр бүлүүдийг хүчирхэгжүүлэхэд чармайлтаа төвлөрүүлбэл гайхалтай үр дүнд хүрнэ.

Би үр дүн муутай тойргийн зөвлөл бүхий тойрогт амьдарч байсан. Бишопын хувьд *Гарын авлага 2* дээрх удирдамжийг дагахад хэцүү байсан юм. Учир нь тэр өөрийн арга барилаар болон хуучин загваруудаар ажиллах дуртай байлаа. Хайраар дүүрэн гадасны ерөнхийлөгч зөвлөгөө, сургалт өгсний дараа бишоп зүрх сэтгэлээ зөөлрүүлж, наманчилж, удирдамжийн дагуу тойргийн зөвлөлөө зохион байгуулах гэж маш их хичээсэн юм. Тэр LDS.org дээрх видео бичлэгүүдийг үзэж, *Гарын авлага 2*-ын 4, 5-р хэсгүүдийг уншаад, сурсан зүйлийнхээ дагуу үйлдсэн байна.

Тойргийн зөвлөлийн гишүүд гарсан өөрчлөлтийг хурдан хүлээн авч, хувь хүн, гэр бүлүүдийг хүчирхэгжүүлэх ажилд төвлөрөх үедээ тэдгээр өөрчлөлтөд хайраар болон нэгдмэл байдлын сүнсээр ханджээ. Хурал бүр дээр тэд сонирхогч, шинэ хөрвөгч, идэвх султай болон тусламж хэрэгтэй байгаа гишүүдийн талаар удаан гэгч ярьдаг болсон байна. Тэдний зүрх сэтгэл эдгээр ах,



АЖИЛД НЭГДЭГТҮН

“Их Эзэн үйлчлэлийнхээ үед Галилийн загасчдыг тороо орхин, Өөрийгөө дага гэж дуудахдаа, “Би та нарыг хүмүүсийн загасчин болгоно” гэсэн билээ. Бид чадлынхаа хэрээр тэдэнд тусалснаар эрэгтэй, эмэгтэй загасчдын үүргээ биелүүлэх болтугай.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Авралын ажил дахь бидний үүрэг,” *Лиахона*, 2013 оны 10-р сар, 4.

эгч рүүгээ эргэж, гайхамшгууд тохиож эхэлсэн юм.

Тойргийн зөвлөлд эдгээр өөрчлөлт хийгдсэний дараа тэр даруй таньдаггүй байсан идэвх султай гишүүд нь Сүмд ирж эхэлсэн гэж бишоп хэлжээ. Эдгээр гишүүнд гэнэт Сүмд буцаж очих мэдрэмж төрсөн гэж тэд хэлсэн байна. Тэд гэгээнтнүүдтэй дахин ойр дотно байх ёстой гэсэн тодорхой, хүчтэй өдөөлт хүлээн авсан гэжээ. Тэд гишүүд өөрсдийг нь хайрлах болно гэдгийг, мөн гишүүдийн тусламж тэдэнд хэрэгтэй гэдгийг мэдэж авсан.

Тэнгэрлэг Эцэг эдгээр идэвх султай гишүүний зүрх сэтгэл, оюун ухаанд Сүмд эргэж идэвхтэй болох хүслийг төрүүлэхээсээ өмнө бишопыг хүлээн авсан зөвлөгөөгөө дагаж, үүний дагуу тойргийн зөвлөлийг зохион байгуулахыг хүлээж байсан гэдгийг бишоп надтай хуваалцсан юм. Сүнс эдгээр гишүүнийг буцааж авчрахаас өмнө хайраар дүүрэн, сайхан орчинг бүрдүүлэх хэрэгтэйг бишоп ойлгожээ. Түүний үгс надад загасчин Петрийн туршлагыг санагдуулсан юм:

“Есүс завинуудын нэгэн дээр буюу Симоны завин дээр гараад, газраас жаахан холдуулахыг түүнээс гуйв. Тэгээд Есүс суугаад, завин дээрээс олон түмэнд сургаалаа зааж эхлэв.

“Тэр айдаж дуусаад, Симонд усны гүн уруу нь очоод тороо хаяад барь гэхэд

“Симон, Эзэн, бид шөнөжингөө зүдрэн загасчлаад юу ч барьсангүй. Гэвч Та хэлж байгаа тул тороо хаяад үзье гэв.

“Тэд тороо хаятал маш их хэмжээний загас баригдаж, тор нь урагдаж эхлэв” (Лук 5:3–6).

Бид өнөө үеийн бошиглогч, үзмэрч, илчлэгчдийн буюу жинхэнэ “хүмүүсийн загасчдын” өгсөн зөвлөгөөг сонсож, дагаж, үйлчлэх үедээ тороо шалгаж, мөн засаж янзалбал авралын ажлыг яаравчлуулах чадвар маань агуу ихээр нэмэгдэж, бид Тэнгэрлэг Эцэгийн мутарт Түүний хүүхдүүдийг цуглуулах зэмсэг байх болно. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Харолд Б.Лий, Conference Report, 1960 оны 10-р сар, 15.
2. *Гарын авлага 2: Сүмийг*

- удирдах нь (2010), 3.1.
3. *Гарын авлага 2*, 3.2.1–5; 3.3.2–4-ийг үзнэ үү.
4. *Гарын авлага 2*, 4.4.

МИНИЙ ХАГАРСАН ШИЛТЭЙ ТООР

Би хүүхэдтэй болох хүртлээ өөрийгөө маш сайн ээж байна гэж боддог байв.

Миний хувьд ээж байх нь намайг тун их сорьж байна. Намайг бухимдалтай, дутуу нойртой, санаа зовсон, эсвэл уур уцаартай байх үед сул дорой чанарууд маань гарч ирдэг юм шиг санагддаг. Мэдээж, эцэг эх байснаар ирдэг адислалууд нь ийм мөчүүдээс илүү их боловч би өөрийгөө түргэн ууртай гэдгээ олж мэдсэн юм. Үнэнийг хэлэхэд ичмээр байгаа ч, би хүүхдүүдийнхээ анхаарлыг татахын тулд хашгирч, юм шиддэг байсан.

Би уур уцаараа засах зорилго тавьдаг байсан ч, буймдсан үедээ уурлачихаад байдаг байв. Ямар нэг сүртэй том зүйл болохоос нааш намайг өөрчлөгдөхгүй гэдгийг Тэнгэрлэг Эцэг мэдэж байсан юм.

Би нэг орой өдөржингөө тооржимс дарж нөөцөлсний дараа сүүлийн жигнүүрээ тавьчихаад хэсэг зуур дуг хийхээр шийдлээ. Би шилнүүдээ жигнүүрээс авах цаг болоход сэрнэ гэдэгтэй итгэлтэй байв.

Гэвч би сэрж чадаагүй юм.

Миний нөхөр Күинн бид хоёр тасхийтэл шил хагарах чимээгээр цочин сэрлээ. Би гал тогоо руу гүйн орж, хагарсан шил болон наалдамхай тооржимснүүд өрөөгөөр дүүрэн тарсан байхыг харав. Жигнүүрийн ус ууршиж, халуун хий болон даралт ихэссэнээс болоод, жигнүүрийн таг задарч; зургаа, долоон шилтэй тоор хагарсан байлаа.

“Үүнийг өглөө цэвэрлэсэн нь дээр байх” гэж би хэлэв.

Энэ нь буруу шийдвэр байсан юм.

Өглөө болоход, гал тогооны болон хоолны өрөөгөөр дүүрэн тоорын халуун шүүс хатуурч, шилтэйгээ барьцалдан овойж хатсан байв.

Хагарсан шилний үртсүүд шүүгээний араар, бүх булан тохойд болон хөргөгчний араар орсон байлаа.

Үүнийг цэвэрлэх гэж хэдэн цаг зарцуулав. Би шилтэй барьцалдсан хатуу царцмагийг нойтон цаасан алчуураар дэвтээж, дараа нь гараа зүсчихэлгүйгээр арчиж авахыг хичээж байв.

Намайг цэвэрлэж байхад нэгэн танил дуу надад: “Мэри, уур хилэн чинь эдгээр шилтэй адил тэсрэх үед чи үр дагаврыг нь амархан засаж

чадахгүй. Чиний уур хилэн хүүхдүүдийг чинь болон бусдыг хэрхэн шархлуулж байгааг чи харж чадахгүй. Энэ замбараагүй байдалтай адилаар ийм шарх хурдан хатуурч, зовиуртай болдог” хэмээн шивнэв.

Ийнхүү гэнэт цэвэрлэгээ маань утга учиртай болсон юм. Би маш том сургамж авсан билээ. Миний уур хилэн шиг энэ зүйлийг хурдан цэвэрлэх арга зам байгаагүй юм. Хэдэн долоо хоногийн дараа ч гэсэн

Би гал тогоо руу гүйн орж, хагархай шил болон нялцгай тооржимснүүд өрөөгөөр нэг тарсан байхыг харав.





БИД ЗӨВ ЗҮЙЛ ХИЙСЭН ҮҮ?

шилтэйгээ барьцалдсан хатуу тоор байсаар л байв.

Миний гэвчээр сул дорой чанар минь байсан шиг, энэ нь хэзээ нэгэн өдөр миний агуу хүчтэй тал болохын төлөө би залбирдаг. Их Эзэний Цагаатгал уур уцаараа хянахад надад тусалж байгаа бөгөөд ингэснээрээ би түргэн уураас болж гарах өвдөлтөөс хайртай хүмүүсээ хамгаалах боломжтой болсондоо талархаж байна. ■

Мэри Биесингэр, АНУ, Юта

Би Перугийн Лима дахь зарим сайн сонин, сэтгүүлд нийтлэл бичдэг, олонд танигдсан сэтгүүлч байсан боловч Бурханаас холдсон амьдрал маань өдөр бүр намайг тарчлааж байсан юм. Үүнээс болоод би гэрээсээ хол байдаг Вентанилла дүүрэгт төвтэй нэгэн сэтгүүлийн хэвлэлийн хянагчаар ажиллах болов. Би одоогийнхоо найз нөхдийн хүрэнээс холдох арга замыг маш их хайж байлаа. Вентаниллад миний амьдрал өөрчлөгдөнө гэдгийг би зүрх сэтгэлдээ мэдэрсэн юм.

Би найз охин Мариа Кристинатайгаа хамт үе үе сүмд очдог байсан бөгөөд хоёр сайн, зөрүүд номлогч энэ Сүм үнэн эсэхийг Тэнгэрлэг Эцэгээс залбирч асуухыг надад ятгаж чадсан юм. Би асуусан бөгөөд мэдэрсэн зүйл маань дүрслэхийн аргагүй гайхалтай байсан. Би Сүнийг тэр өдөр мэдэрсэн шиг тийм хүчтэй мэдэрч байгаагүй.

Мариа Кристина бид хоёр гэрлэж, мөн баптисм хүртээд удаагүй байхдаа Вентаниллад нэгэн жижиг, тав тух муутай өрөө түрээсэлж амьдарсан. Би шаргуу ажилласан учраас хэвлэлийн хянагчаас компаний сонин, сэтгүүлийн редактор болж дэвшлээ. Би өмнө нь редактороор ажиллаж үзээгүй ч энэ албан тушаалд ажиллахдаа баяртай байв. Гэсэн хэдий ч манай хэвлэл жишгээ бууруулж, ёс суртахууны хувьд асуудалтай зүйлүүд нийтэлж эхэлснээс хойш бүх юм өөрчлөгдөж эхлэх нь тэр. Захирлуудын хийсэн эдгээр өөрчлөлт Сүмийн зарчим, эрхэмлэдэг зүйлүүдийн эсрэг байлаа.

Би редактор болохыг үргэлж хүсдэг байсан ч ийм нөхцөл байдал

надад таагүй санагдаж байв. Хэрэв бид Тэнгэрлэг Эцэгийн таалалд нийцэх зүйлүүдийг хийвэл Тэр биднийг адислах болно гэж манай бишоп зөвлөсөн. Иймд эхнэр бид хоёр энэ талаар бодож, залбирсны дараа ажлаасаа гарах ёстой гэсэн мэдрэмж хүлээж авсан юм.

Хэдэн өдрийн дараа миний сэтгэл санаа хямарч, зөв зүйл хийсэн эсэхдээ эргэлзэж эхлэв. Би ажлаасаа гарсны дараа анкет намтраа хэд хэдэн компани руу явуулсан ч ямар ч хариу ирсэнгүй. Мариа Кристинагийн зөвлөсний дагуу бид хоёр хамтдаа дахин залбирсан юм. Бидэнд төлбөрийн нэхэмжлэхүүд овоорч байсан ч бүх зүйл сайнаар эргэхийн төлөө, бас бид итгэлээ алдахгүйн төлөө залбирав.

Хэдэн цагийн дараа эхнэр маань тэр компаниудын нэг рүү залгахыг зөвлөж билээ. Би итгэл муутайхан залгалаа. Тэр компаний ажилтан над руу яг ярих гэж байсныг сонсоод, би ихэд гайхав. Тэр намайг маргаашнаас ажиллаж чадах эсэхийг асуулаа!

Бид баярласандаа уйлсан. Тэнгэрлэг Эцэг маань бидний залбиралд ийнхүү хариулсан юм.

Шинэ ажилд ороод, бид хоёр тойргоо, олон сайн найзаа орхих хэрэгтэй болсон ч бидний гэрчлэл илүү хүчтэй болсон байв. Одоо би өндөр цалинтай сайн ажилтай бөгөөд бид сайхан байранд амьдарч байна. Хамгийн чухал нь, бид Бурханы таалалд нийцэх зүйлийг хийвэл Түүний адислалуудыг авах болно гэсэн гэрчлэлээр адислагдсан юм. ■

Карлос Жавиер Леон Угартэ, Перу, Лима

БИ ЧАМД ХАЙРТАЙ

Номлолын маань бүсийн чуулган дуусах дөхөж байхад би гадаа зогсоод, “Би энэ гадаад оронд юу хийж байгаа юм бэ? Би хийх ёстой бүх зүйлээ хэрхэн хийх билээ?” гэж бодож байлаа.

Би Италийн Сицилид ирээд долоо хонож байсан ч аль хэдийн сэтгэлээр унасан байв. Номлогчийг бэлтгэх төвд өнгөрүүлсэн хугацаа маань гайхалтай зүүд мэт байсан ч, өөрийнхөө хангалтгүй байдлаас болоод би энд хар дарсан зүүдэн дотор байгаа юм шиг л санагдаж байлаа.

Би “Хайрт Эцэг минь, би агуу номлогч болохыг хүссэн. Гэтэл би одоо энд хийх гэж ирсэн зүйлээ хийх авьяас, чадвар, оюун ухаангүй гэдгээ ойлголоо. Би энэ хэлийг

мэддэг гэж бодсон ч хүн бүр маш хурдан ярьж, харин би ямар ч үг хэлэх гэж хичээгээд хэл эвлэрэхгүй юм. Хамтрагч маань надад сайн гэж би бодохгүй байна. Манай номлолын ерөнхийлөгч англиар муухан ярьдаг. Надтай ярилцах хэн ч алга. Надад туслаач” гэж залбирлаа.

Би дотогшоо буцаж орох ёстойгоо мэдэж байсан ч, гудамжинд дахин хэдэн минут зогссон юм. Гэнэт хүрэмнээс маань хэн нэгэн гурван удаа татахыг би мэдрэв. Би эргэж хараад, нэг хөөрхөн бяцхан охиныг харж, чулуу дэвссэн зам дээр түүний хажууд өвдөглөн суулаа. Тэр намайг хүзүүгээр минь тэврээд, чихэнд минь, “*Ti voglio bene*” гэж шивнэв.

“Чи юу гэж хэлсэн бэ?” Тэр

намайг ойлгохгүй гэдгийг би сайн мэдэж байсан ч хариуд нь англиар ингэж асуув.

Тэр миний нэрийн тэмдэг рүү ширтэж, “Сорелла Доменики” гэж уншаад, “*ti voglio bene*” гэж хэллээ.

Би энэ өгүүлбэрийн утгыг мэддэг байсан. Энэ бол номлогчдын хамгийн түрүүнд чээжилсэн өгүүлбэрүүдийн нэг байв. Энэ нь бодгальд шууд нэвтэрч чадах өгүүлбэр байсан юм. Энэ нь “би чамд хайртай” гэсэн үг.

Эдгээр үг нь яг тэр үед надад хэрэгтэй байсан үгс байлаа. Аврагч эдгээр үгийг надад хэлэхийн тулд нэгэн онцгой элчийг илгээжээ. Би бяцхан охиныг дагуулан сүмд оров.

“Би түүнийг нэг гишүүний охин байх” гэж бодсон юм. Би олон номлогчийн дундуур явж, түүнийг ээж нь олж харах байх гэж бодов.

Би хамтрагчаа олж очоод, “Чи энэ бяцхан охиныг харж байсан уу?” гэж асуулаа.

Тэр гайхсан янзтай, “ямар бяцхан охин?” гэв.

Би хажуу тийш хартал нөгөө бяцхан охин байхгүй байв.

Би байрны үүдэнд зогсоод, эзэнгүй гудамжны хоёр тийш харлаа. Намайг тунгаан бодох үед тэрхүү шивнээ сонсогдоод зогсохгүй, бодгальд минь “Сорелла Доменики, би чамд хайртай” гэж цуурайтахыг би мэдэрсэн.

Би тэр бяцхан охин хэн байсныг мэдээгүй ч, Аврагч надад хайртай гэдгийг мэдсэн юм. ■

Натали Т.Фристрап, АНУ, Юта



Би эргэж хараад, нэг хөөрхөн бяцхан охиныг харж, чулуу дэвссэн зам дээр түүний хажууд өвдөглөн суулаа.



Маргааш нь
үдээс хойш би
өөртөө хийсэн оройн
хоолоо Морган
эгч, түүний нөхөр
хоёрын хуримын ойд
зориулан аваачиж
өгөх ёстой гэж
сүнслэгээр мэдэрлээ.

МИНИЙ ХООЛ ХЭТЭРХИЙ ЭНГИЙН БАЙСАН УУ?

Би хэдэн жилийн турш Морган гэдэг нэртэй хөршийнхөө буюу найз эгчийнхээ айлчлагч багш байсан юм. Тэр надаас олон насаар эгч байсан учраас би түүнд заахаасаа илүү түүнээс болон түүний амьдралаас их зүйлийг сурдаг байлаа.

Намайг Морган эгчийн айлчлагч багш байх үед тэр хорт хавдартай гэж оношлогдсон юм. Би түүнийг эмчилгээнүүдээ хэрхэн зоригтой хийлгэхийг, бас нүүрэндээ үргэлж инээмсэглэл тодруулан явдгийг гайхдаг байв.

Тэрээр нэг удаа түүн дээр айлчлан очих үеэр маргааш хуримынх нь ой болно гэж билээ. Бидний яриа удалгүй өөр зүйлс рүү шилжиж, айлчлал маань ч өндөрлөсөн.

Маргааш үдээс хойш нь би өөртөө хийсэн оройн хоолоо Морган эгч, түүний нөхөр хоёрын хуримын ойд зориулан аваачиж өгөх ёстой гэж сүнслэгээр мэдэрлээ. Би энгийн өдөр тутмын хоол хийж байсан учраас эхлээд энэ өдөөлтийг үл тоомсорлосон юм. Ийм онцгой үйл явдлын үеэр энгийн хоол

өгөх нь тохиромжгүй шүү дээ.

Гэвч өнөөх өдөөлт намайг орхисонгүй. Би ажил дээрээ байсан нөхөр рүүтээ залгаж, түүнийг ч бас үүнийг сайн санаа биш гэж хэлэх байх гэж найдаж байлаа. Харин тэр намайг Морган эгч рүү утасдаад, оройн хоол аваачиж өгөх гэж байгаагаа хэл гэж зөвлөв.

Би энгийн хоолноосоо санаа зовон, өөрийнхөө таамаглалаас болоод найз руугаа утасдаж чадаагүй ч, оройн хоолоо хуваалц гэсэн мэдрэмжийг эсэргүүцэж чадсангүй. Тиймээс би хоолоо саванд хийж, авч гарснаа тээнэгэлзэн алхав.

Би тэдний хашаанд ороод, Морган ах, эгч хоёрыг машиндаа сууж байгааг харлаа. Би тэдний хуримын ойд зориулан оройн хоол авчирснаа, мөн тэд хоолыг авна гэж найдаж байгаагаа хэлсэн юм.

Морган эгчийн нүүрэнд инээмсэглэл тодров. Тэр хавдрын эмчилгээнээс болж маш их ядарсан учраас хоол хийж, эсвэл өөр тийшээ явж чадахгүй учраас тэр хоёр ойрхон байдаг түргэн хоолны газарт очиж,

хуримын ойгоо тэмдэглэх гэж байснаа тайлбарласан юм. Тэр оройн хоолоо гэртээ идэх болсондоо сэтгэл нь амарсан харагдаж байв.

Тэд миний хийсэн энгийн хоолыг хүлээн авахад би сэтгэл уужирч, аз жаргалаар дүүрч билээ.

Морган эгч хоёр сар хүрэхгүй хугацааны дараа хавдрын эмчилгээгээ дуусах үед хайртай нөхөр нь өвчний улмаас гэнэт нас барав. Хэдхэн долоо хоногийн өмнө тохиосон хуримын ой тэдний сүүлчийнх байсан юм.

Тэр зун би бусдад үйлчлэхэд урьдаг Сүнсний намуун, зөөлөн дуу хоолойг дагах талаар маш их зүйл сурсан. Бидний хийх үйлчлэл нь амархан биш, эсвэл бидний нүдэнд энгийн байж болох боловч энэ нь яг хэрэгтэй тэр зүйл нь байж болно. Энэ туршлага нь Их Эзэний хүссэн болгонд үйлчлэх зоригийг надад өгч, “тэнгэр элчүүдийн ажлыг” хийх итгэлийг маань нэмэгдүүлсэн юм (“Сионы эгч нар,” *Hymns*, дугаар 309). ■

Жэннифэр Клингосмит, АНУ, Юта



ИХ ЭЗЭНИЙ баталгаанд ИТГЭХҮЙ

**Бидний бэрхшээлүүд
үргэлж алга
болохгүй ч, бид
Их Эзэний баталгааг
эрэлхийлснээр
хэцүү үеүдэд ч бүх
зүйл дажгүй байх
болно гэдгийг
мэдэж болно.**

Минди Энн Лэвитт

Сүмийн сэтгүүлүүд

Би ариун сүмийн селестиел өрөөнд суугаад, амьдрал маань миний төлөвлөснөөс өөр чиглэлд явж байгааг тунгаан бодож байлаа. Бусад олон залуучуудтай адил олон зүйл миний санааг зовоож байв. Би сурлага, нийгмийн амьдралаа хэрхэн

тэнцвэртэй байлгаж чадах вэ? Би хэрхэн ажлаасаа гарч, өөр ажил олох вэ? Би ямар ч мөнгөгүй байж, яаж хуримтлал бий болгох вэ? Би яагаад одоо болтол гэрлээгүй байгаа юм бэ? Жагсаалт энэ маягаар үргэлжилсээр байлаа. Би тайвшрал эрэлхийлж, амьдрал минь Тэнгэрлэг Эцэгийн гарт байгаа гэсэн баталгааг залбирч авахын тулд ариун сүм рүү явсан юм. “Амьдралд минь бүх зүйл сайхан болох болов уу?” гэж би асуулаа. “Бүх зүйл сайхан болно” гэсэн хариулт тэр дороо, миний оюун ухаанд баттай ирсэн.

Миний амьдрал төлөвлөснөөс минь өөр байсан ч, би *Түүний* төлөвлөгөөний дагуу явж, Тэр бүх зүйлийг хариуцаж байгааг тэрхүү мөчид ойлгосон юм. Тэр миний бэрхшээлүүдийг үргэлж алга болгодоггүй ч гэсэн, намайг мэддэг бас надад санаа тавьж байгаа гэсэн сайхан баталгаа нь олон бэрхшээл дундуур намайг авч гарсан юм. Бид эдгээр баталгааг ойлгож, эрэлхийлж, мөн хүсэн хүлээснээр Их Эзэн биднийг, үүрч буй ачаа дарамтуудын дундуур дэмждэг гэдгийг мэдэж чадна.

Чөлөөлөлтөөс урьтаж ирэх баталгаа

Их Эзэн биднийг гуймагц бэрхшээлээс минь тэр даруй чөлөөлдөггүй нь тодорхой юм. Харин Тэр хувийн илчлэлтээр дамжуулан үнэлж баршгүй баталгаагаар Тэр бидний амьдралыг удирдаж байгаа бөгөөд биднийг бэрхшээлүүдээс чөлөөлнө гэсэн баталгаагаар адисалж болно. Эдгээр баталгаа нь биднийг бэрхшээлүүдээс чөлөөлөхгүй ч бидэнд өөрсдийгөө чөлөөлөх хүч чадлыг өгч болно. Энэхүү чөлөөлөлт нь Ариун Сүнсний тайтгарал мэт энгийн зүйл байж болно. Их Эзэн ихэнхдээ чөлөөлөлтөөс урьтаж баталгаа өгдөг олон жишээг би судруудаас анзаарсан юм.

Хиламан 2060 залуу дайчинг, мөн нифайчуудын өөр армийг удирдаж байхдаа тэд Их Эзэний баталгааг хүлээн авчээ. Хоол хүнс, нэмэгдэл хүчийг хэдэн сар хүлээсний эцэст тэднийг өлсөж үхэхийн даваан дээр цөөхөн эрэгтэй хоол хүнс авчирсан байна. Хүчээ цөөн хүнээр нэмэх нь хангалтгүй гэж айсан тэд эцэст нь Их Эзэнд хандаж, “тэрээр [тэднийг]

хүчирхэгжүүлж, мөн [тэднийг] дайснуудын гараас чөлөөлж . . . өгөөсэй хэмээн [тэд] сэтгэл оюунаа Бурханд хандсан залбиралд юүлсэн болой.” Тэд залбирсны дараа юу болсон тухай Хиламан: “Их Эзэн Бурхан минь, тэрээр биднийг чөлөөлөх болно хэмээх баталгаагаар бидэнд зочилсон юм; тийм ээ, үүний хэрээр тэр бидний сэтгэл оюунд амар амгаланг өгч, мөн агуу итгэлийг бидэнд соёрхож, мөн биднийг түүгээр дамжин ирэх чөлөөлөлтөндөө найдах болгосон билээ” гэжээ (Алма 58:10–11). Эдгээр баталгаа нь Хиламанд болон түүний дайчдад тэсэн гарч, дайснуудаа ялах хүчийг өгсөн юм.

Иосеф Смит Либерти шоронд хоригдож байхдаа Их Эзэний баталгааг хүлээн авсан. Тэр залбирах үедээ:

“Хүү минь, сүнсэнд чинь амар амгалан байг; саад тотгор хийгээд зовлон зүдгүүрүүд чинь хэсэг хугацаанд байх болно;

Мөн тэгээд, хэрэв чи үүнийг дажгүй давбал, Бурхан чамайг тэнгэрт өргөмжлөх болно; чи бүх дайснаа ялах болно” гэсэн үгсийг сонсчээ (С ба Г 121:7–8).

Энэхүү баталгаа нь Иосеф Смитэд хүнд бэрхшээлүүдийг даван гарах зориг, сэтгэлийн тэнхээг өгсөн юм.

Эдгээр болон өөр бусад жишээнд (жишээ нь Мозая 24:8–16-г үзнэ үү) Их Эзэн итгэлтэй хүмүүсийг бэрхшээлүүдээс нь тэр даруй чөлөөлдөггүй. Харин Тэр Өөрийн цаг хугацаанд тэднийг *чөлөөлөх болно* гэсэн *баталгаагаар* тэдэнд зочилсон юм. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г.Скоттын хэлснээр эдгээр баталгаа нь: “бидний замыг гэрэлтүүлэхийн тулд” Тэнгэрлэг Эцэгийн бидний замд тавьдаг “боодолтой сүнслэг нарны



ТҮҮНИЙ ХҮЧ ЧАДЛЫН БАТАЛГАА

“Бид бүгдээрээ бэрхшээлийг даван туулах ёстой. . . . Тэрээр

биднийг хэрхэн эмчилж, бидэнд хэрхэн туслахыг сайн мэддэг, Аврагчийн тайтгаруулах хүчний тухай тодорхой өгүүлсэн. Мормоны Номонд Түүний тайтгаруулах хүчний тодорхой баталгааг өгдөг. Энэхүү баталгаанд итгэх нь залбирах, ажиллах, тусламж хүлээх зэргийг тэсэн хүлээх чадварыг өгөх болно.

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, ерөнхийлөгч Хэнри Б.Айринг “Нэг бай,” *Лиахона*, 2009 оны 5-р сар, 24.

гэрлүүд” юм.¹ Бид эцэст нь чөлөөлөгдөх болно гэдгийг мэдэж байхад зарим үед бэрхшээлүүдийг даван гарахад энэ баталгаа бидэнд хангалттай байдаг.

Баталгаануудыг эрэлхийлэх нь

Амьдрал хэцүү. Бид эргэлзэж, өөрсдөдөө болон бэрхшээлийг даван туулах өөрсдийн чадварт бүрэн итгэхгүй байх, мөн найдвар алдах үед байдаг. Ихэнх тохиолдолд бидний бэрхшээлүүд хэзээ ч дуусахгүй мэт санагддаг. Хэдийгээр зарим баталгаа нь биднээс шалтгаалахгүй ирдэг ч ихэнх тохиолдолд

бид бэрхшээлүүдээс чөлөөлөгдөнө гэдгийг сануулдаг баталгааг эрэлхийлэх хэрэгтэй.

Их Эзэний баталгаанууд ихэвчлэн орон нутгийн удирдагчид, институт, ням гаргийн ангийн багш, ялангуяа Түүний бошиглогч, төлөөлөгчид гэх мэт Түүний үйлчлэгчдийн дуу хоолойгоор ирдэг. Залуу эмэгтэйчүүдийн бүлгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Кэрол Ф.Макконки “Бид тэдний үгсээс Их Эзэний дуу хоолойг сонсож, Аврагчийн хайрыг мэдэрдэг билээ”² хэмээн бидэнд сануулсан.

Бид чин сэтгэлийн залбирлаар Тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцан, судруудыг уншиж, тунгаан бодож, ариун сүм рүү яван, Сүмийн цуглаанд оролцох үед, мөн бусдад үйлчилж, зөв зүйлийг хийхийг хичээх үед эдгээр баталгаа нь Сүнсний дуу хоолойгоор дамжин ирдэг. Товчхондоо бид “Түүнийг бүх зүрхээрээ, бүх сэтгэлээрээ эрвэл” (Дэд хууль 4:29), мөн Түүний зарлигуудыг сахивал Их Эзэний баталгаанууд ирдэг юм.

Хиламан болон түүний арми чин сэтгэлийн олон залбирлын дараа баталгаа хүлээн авсан. Мөн Иосеф Смит залбирч, тунгаан бодсоны дараа баталгаа хүлээн авсан билээ. Эдгээр нөхцөл байдалд Их Эзэн тэдэнд баталгаа өгөхөөсөө өмнө тэдний тэвчээр, итгэлийг сорьсон бөгөөд энэ нь бэрхшээл тохиолдох үед бид итгэлтэй байж, тэвчээрээ харуулах хэрэгтэй гэсэн сайхан сануулга юм.

Баталгаа хүлээх

Тэвчээрийн бүх л сорилттой адил Их Эзэний баталгаанууд бидний хүсэн хүлээсэн байдлаар, эсвэл хүссэн цаг хугацаанд

ирэхгүй байж болно. Бид амьдралдаа Их Эзэний мутрыг болон Түүний баталгаануудыг “харах нүдтэй” (Езекиел 12:2) болохын төлөө залбирах хэрэгтэй байж болох юм. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар Их Эзэний нигүүлсэлд эдгээр баталгаа багтдаг бөгөөд тэдгээр нь “санамсаргүй, эсвэл тохиолдлоор ирдэггүй” хэмээн хэлсэн байдаг. Итгэлтэй, дуулгавартай байдал нь бидэнд тэдгээр чухал бэлгийг хүлээн авах боломжийг олгодог төдийгүй Их Эзэний товлосон цаг хугацаа тэдгээрийг танихад бидэнд тусалдаг.”³

Ихэнх тохиолдолд чөлөөлөлтийг юм уу, чөлөөлөлтийн баталгааг хүлээх нь бидэнд байгаагаас илүү тэвчээр шаарддаг. Бид ямар нэг баталгаа хүлээж авахаасаа өмнө ноцтой хүнд бэрхшээлтэй тулгарах хэрэгтэй ч байж магадгүй. Ахлагч Скотт Их Эзэний өгдөг “боодолтой сүнслэг нарны гэрэл” нь “ихэвчлэн хамгийн хүнд бэрхшээлийн дараа, бүхнийг мэдэгч Эцэгийн энэрэл, хайрын нотолгоо болж ирдэг. Тэдгээр нь илүү агуу аз жаргал, илүү их ойлголтод хүрэх замыг заадаг бөгөөд Түүний хүслийг хүлээн зөвшөөрч, дуулгавартай

байх [бидний] шийдвэрийг хүчирхэгжүүлдэг”⁴ хэмээн тайлбарлажээ. Бид бэрхшээлүүдийн дунд итгэлтэй бөгөөд дуулгавартай байвал Их Эзэний баталгаанууд биднийг цаашид ч ийм байлгахын тулд ирэх болно.

Бидэнд буй хамгийн агуу баталгаа

Эцсийн эцэст, хэрэв бид Есүс Христэд итгэх итгэл, найдваргүй байвал Тэнгэрлэг Эцэг биднийг болон бидний нөхцөл байдлыг мэддэг гэсэн хэчнээн их баталгаа авсан ч, энэ нь бидэнд эцсээ хүртэл тэвчихэд туслахуйц хангалттай биш байх болно. Түүний Цагаатгалаар дамжуулан бид нэгэн өдөр бүх бэрхшээлээсээ чөлөөлөгдөж чадна гэсэн туйлын найдвартай байж чадна. Аврагч “бүх зүйлийн доор бууж ирснээр тэрбээр бүх зүйлийг ухамсарласан” (С ба Г 88:6) учраас Тэр бидэнтэй хамт зовно гэдгийг бид мэдэж чадна. Тэр “бүх төрлийн өвчин мөн зүдгүүрүүд мөн уруу таталтуудыг тэвчих болно; . . . тэрээр бие махбодын дагуу өөрийн хүмүүсийг тэдний сул байдлуудынх нь дагуу хэрхэн халамжлахыг [мэддэг]” (Алма 7:11–12) учраас бидний бэрхшээл, зовлонг ойлгодог.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд: “Бурханы төлөвлөгөөн дэх хамгийн агуу баталгаа нь Түүнд итгэх итгэлийнхээ хэмжээгээр шалгуур, сорилтуудыг ялгуусан байдалтай даван туулахад бидэнд туслах Аврагч, Гэтэлгэгч амаагдсан явдал юм. . . . Энэхүү бурханлаг хайрын тухай бидний ойлголт нь биднийг өөрсдийн багахан зовлонг эхлээд тэвчихүйц, дараа нь ойлгож

чадахуйц, эцэст нь ариусгахуйц болгодог билээ.”⁵ Түүнийг болон Түүний Цагаатгалаас суралцах явдал нь өөрөө баталгаа болдог.

Бүх юм сайхан болно

Бид Их Эзэний баталгаануудыг ойлгож, эрэлхийлж, мөн хүлээвэл тэд гарцаагүй ирэх болно. Бид тэдгээр үнэлж баршгүй мөчийг санаж, тэмдэглэн авч, мөн олонтоо бодож байх ёстой. Хамгийн чухал нь бид Хиламан ба түүний эрчүүд, мөн бошиглогч Иосеф Смит итгэсэн шиг тэдгээрт найдаж, Их Эзэн бидэнд өгсөн амлалтуудаа биелүүлнэ гэдэгт итгэх хэрэгтэй. Тэр баталгаануудаараа дамжуулан тэдгээр амлалтыг бидэнд сануулдаг бөгөөд тэдгээр нь бидний бэрхшээлүүдийг алга болгохгүй ч гэсэн Тэнгэрлэг Эцэг бүх зүйлд биднийг дэмжихээр бидэнтэй хамт байдаг гэдгийг бид мэдэж чадна.

Тэр өдөр ариун сүмд болсон үйл явдлын дараа миний бэрхшээлүүд багасаагүй. Би гэнэт сайн дүн авч, эсвэл их мөнгөтэй болж, эсвэл олон болзоонд яваагүй. Хэдийгээр миний олж авсан зүйл нь бэрхшээлүүд ч гэсэн Их Эзэн намайг чөлөөлөх амлалтаа биелүүлэх учраас би ДАЖГҮЙ байх болно гэсэн намуухан баталгаа юм. Энэхүү баталгаагаар дамжуулан би бүх зүйл сайхан болно гэдгийг мэднэ. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Ричард Г.Скотт, “Trust in the Lord,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 17.
2. Кэрл Ф.Макконки “Бошиглогчдын үгсийг дагаж амьдарцгаая,” *Лиакхона*, 2014 оны 11-р сар, 77.
3. Дэвид А.Бэднар, “The Tender Mercies of the Lord,” *Лиакхона*, 2005 оны 5-р сар, 100.
4. Ричард Г.Скотт, “Trust in the Lord,” 17.
5. Жэффри Р.Холланд, “Бие биендээ энэрэнгүй хандацгаая,” *Лиакхона*, 2013 оны 11-р сар, 40–42.

“Боодолтой сүнслэг нарны гэрэл” нь ихэвчлэн хамгийн хүнд бэрхшээлийн дараа, бүхнийг мэдэгч Эцэгийн энэрэл, хайрын нотолгоо болж ирдэг. Тэд илүү аз жаргалд хүрэх замыг заадаг.”



Лена Син Яао Чо

Б и 2005 онд Калифорнийн хойд хэсэгт бүрэн цагийн номлогчоор үйлчлэхээр Тайваний Нан Цэ дахь гэрээсээ явсан. Хамтрагч бид хоёрын томилогдсон газар жижигхэн газар байсан тул дөрвөн сар хагасын дотор бид хоёр хотын төв хэсгийн бүх гудамжин дахь айлуудын хаалгыг тогшсон байв. Номлолын ажил хэцүү байсан бөгөөд хүмүүс ихэнхдээ бидэн рүү хашгичдаг байлаа. Бидэнд цөөхөн сонирхогч байсан юм. Надад ажил урагшлахгүй байгаа юм шиг санагддаг байв. Би тэнд дөрвөн сар болсны дараа тэндээс явахад бэлэн болсон байлаа. Би солилцоогоор явна гэдэгтээ итгэчихсэн байсан билээ.

Ням гаргийн орой би утасныхаа хажууд бүсийн удирдагчийнхаа ярихыг хүлээж байлаа. Гэтэл тэр намайг энэ газраа дахин зургаан долоо хоног ажиллахаар томилогдсон гэж хэлэхэд нь би чихэндээ ч итгээгүй юм. Эндүүрсэн байлгүй дээ гэж би бодсон!

Дараагийн долоо хоног миний хувьд ч, хамтрагчийн маань хувьд ч, мөн бидэнтэй хамт үйлчилдэг хүмүүсийн хувьд ч жинхэнэ сүйрэл болох нь тэр. Энд үлдэх нь зөв шийдвэр гэдэгт би итгэхийг хүсээгүй. Хэдийгээр би хүмүүсийг харж, ярилцах бүрдээ нүүр дүүрэн инээмсэглэж байсан ч дотроо гунигтай байсан юм. Би бардам зандаа хөтлөгдөн, энд байх ёсгүй гэж өөртөө үргэлжлүүлэн хэлсээр байв. Номлолын ерөнхийлөгч маань над руу ярьж, өөр газар

Солилцоогоор ЯВАХГҮЙ

Номлолын ерөнхийлөгч маань андуурсан байлгүй дээ, би энэ газар удаан байлаа гээд юу сурах юм бэ?

руу солилцоогоор явах тухай хэлнэ гэж би найдсаар л байлаа.

Баталгаа ирсэн нь

Дараагийн ням гаргийн өглөө намайг сүмдээ явах бэлтгэлээ дурамжхан гэгч хийж байхад утас дуутарлаа. Номлолын ерөнхийлөгч байв. Тэр дасал болсон найрсаг хоолойгоор надтай мэндлээд, “Чо эгч ээ, би өчигдөр өдрийн хоол идэж байгаад таны тухай бодож, таныг зөв газраа байгаа гэдгийг утасдаж хэлэх хэрэгтэй гэсэн мэдрэмж төрсөн. Та байх ёстой газраа л байгаа” гэж хэлэв. Эдгээр үгийг сонсоод, нулимс минь урсаж билээ.

Би түүнд талархаад, утсаа тавив. Намайг уйлж эхлэхэд энэ газарт миний хийж дуусгаагүй ажлууд *байгаа* гэсэн маш ойлгомжтой мэдрэмж тун хүчтэй төрсөн. Тэнгэрлэг Эцэг миний бодол, бухимдлыг мэдэж байсныг би мэдрэсэн. Тэр миний сүл дорой чанаруудыг ойлгож байсан бөгөөд надад баталгаа өгөхөөр Тэр Өөрийн үйлчлэгчийг илгээсэн юм.

Утсаар ярьсныхаа дараа би хэвийн байдалдаа оров. Би өдөр бүр хүч чадалтай байхын төлөө залбирч, Их Эзэний надаар хийлгэхийг хүсэж буй зүйлийг хэрхэн хийж чадахаа илүү тодорхой ойлгохыг хүсэж байлаа. Дараагийн таван долоо хоногийн турш хамтрагч бид хоёр шаргуу ажиллах хангалттай итгэлээ харуулснаар олон гайхамшиг тохиолдов. Маш сайн бэлтгэгдсэн нэг сонирхогч манай газарт

нүүж ирж, тэр солилцоон дээр баптисм хүртсэн.

Мөн өмнө нь хүлээж аваагүй хүмүүс биднийг гэртээ урьсан. Бид хэцүү асуудалтай олон хүнтэй уулзаж, Бурханы тайтгаруулагч үгсийг тэдэнтэй хуваалцах боломжоор адислагдсан юм. Хэдийгээр зарим хүн баптисм хүртэх сонголт хийгээгүй ч, би тэдний гэрэлтсэн царайг болон Сүнс ба Бурханы хайр тэдний болон миний зүрх сэтгэлд хэрхэн нөлөөлснийг хэзээ ч мартахгүй.

Миний сурсан зүйл

Их Эзэн бидний хүн нэг бүрийг үнэхээр мэддэгийг би сурсан. Тэр Өөрийн номлогчдыг зорилгогүйгээр аливаа газарт явуулдаггүй. Бид ямар нэг газарт томилогдоход, Их Эзэн тэнд биднийг Өөрийн ажлыг гүйцэлдүүлэх зэмсэг болгон ашиглахыг хүсдэг гэдгийг би мэдсэн. Бид өөрсдийгөө Түүний мутарт даатгахад, бидэнд боломжгүй мэт санагдаж байсан ч гайхамшгууд тохиож, зүрх сэтгэл зөөлөрдөг.

Хамгийн чухал нь номлолын ерөнхийлөгч маань Сүмийн бусад удирдагчтай адил үнэхээр Бурханаар дуудагдсан гэдгийг би мэдэж авсан. Их Эзэн бидний бодгалийн сайн сайхан байдалд хэрэгтэй илчлэлтүүдийг хүлээн авах чадварыг удирдагчдад маань өгдөг.

Би солилцоогоор өөр тийш *яваагүйн* үр дүнд надад ирсэн туршлагад үүрд талархах болно. ■
Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.





**Ерөнхийлөгч
Дийтр Ф.Угдорф**
Тэргүүн Зөвлөлийн
хоёрдугаар зөвлөх

Хурдан хэмнэлтэй ДЭЛХИЙД АМЬДРАХ НЬ

Хэрэв амьдрал болон үүний тэвдүүхэн хурд, мөн олон дарамт нь баярлаж наадахад тань саад болж байвал, энэ нь одоо хамгийн чухал зүйлс рүүгээ хандах сайн цаг нь байж магадгүй юм.

Та нарыг нисэх үеэр онгоц донсолж байсан уу? Донслох хамгийн нийтлэг шалтгаан нь агаарын гэнэтийн хөдөлгөөний өөрчлөлтөөс болоод онгоцны хошуу дээш доош, нэг хажуугаас нөгөө тийш шидэгдэж, онгоцыг хөрвөхөд хүргэдэг явдал юм. Онгоцнууд бидний жирийн нислэгийн үеэр тохиолдох ямар ч зүйлээс хамаагүй илүү хүчтэй донсолгооныг даван гарахуйцаар хийгдсэн байдаг ч зорчигчид сандарч тэвдэж болно.

Онгоц донсолж эхлэхэд нисгэгчид юу хийдэг гэж та нар бодож байна? Оюутан нисгэгч бол үүнийг хурдхан шиг өнгөрөөхийн тулд хурдаа нэмэх нь зөв арга гэж бодож болох юм. Гэвч энэ нь буруу зүйл байж магадгүй. Донсолж байхад явах тохиромжтой хурд гэж байдаг бөгөөд энэ нь онгоцны донсолгооны сөрөг нөлөөг багасгадгийг мэргэжлийн нисгэгчид мэддэг. Ихэнхдээ энэ нь хурдаа багасгах гэсэн утгатай байдаг. Энэхүү зарчим нь замын хурд сааруулах газрын овгор гадаргууд мөн адил хамааралтай юм.

Иймээс сөрөг нөхцөл байдалтай тулгарсан үедээ бага зэрэг удааширч, явдлаа тогтворжуулж, зайлшгүй чухал зүйл дээр анхаарах нь маш сайн зөвлөгөө юм.

Орчин үеийн амьдралын хурд

Бид саад тотгор, үймээн самуунаас үл шалтгаалан зогсолтгүй хурдалсаар байгаа нь өнөөгийн амьдралын нэг онцлог шинж болж байгаа мэт санагддаг.



Бурхантай харьцах харилцаа

Шударгаар хэлэхэд, завгүй байх нь илүү амар байдаг. Бид цагийн хуваариасаа хэтэрсэн хийх зүйлсийн жагсаалтыг гаргаж чадна. Тэр байтугай, зарим хүн

өөрсдийнх нь хувийн үнэ цэнэ хийх ёстой зүйлсийн жагсаалт нь хэр урт байгаагаас шалтгаалдаг гэж бодож ч болох юм.

Ухаалаг хүн өдөр тутмын амьдралын яаруу тэвдүү байдалд уруу татагдахгүй байж чаддаг. Тэд “амьдралд хурдыг нь ихэсгэхээс илүү их зүйл байдаг”¹ гэсэн зөвлөгөөг дагадаг. Товчоор хэлбэл, тэд хамгийн чухал зүйлс дээр анхаарлаа төвлөрүүлдэг билээ.

Ахлагч Даллин Х.Өүкс саяхны Ерөнхий чуулган дээр “Бидний Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлийг хөгжүүлж, гэр бүлүүдийг хүчирхэгжүүлдэг тэр илүү сайн юм уу, хамгийн сайн зүйлсийг сонгохын тулд зарим нэг сайн зүйлийг ардаа орхих ёстой” гэж заажээ.²

Тэрхүү хамгийн сайн зүйлсийг хайх нь биднийг Есүс Христийн сайн мэдээний үндсэн зарчмууд руу зайлшгүй хөтөлдөг. Үүнд хайртай, мөнхийн, бүхнийг мэдэгч Тэнгэр дэх Эцэгийн маань бидэнд илчилсэн энгийн бөгөөд гайхамшигт үнэнүүд ордог билээ.

Би юу хамгийн чухал болохыг хэрхэн сүрч мэдэх вэ?

Бидний ихэнх нь үндсэн гол зүйлс нь хэчнээн чухал болохыг зөн совингоороо мэддэг гэж би бодож байна. Гэвч заримдаа бид илүү дур булаам санагдах зүйлст сэтгэл татагддаг.

Хэвлэгдсэн материал, олон нийтийн өргөн цар хүрээтэй мэдээлэл, электрон төхөөрөмж, зэмсгүүд нь бүх хүн зөв хэрэглэх юм бол бидэнд тус болдог. Гэвч эдгээр нь буруу зугаа цэнгэл юм уу, бусдаас хөндийрөн зожигрох аюултай зүйл болж мэднэ.

Гэвч эдгээр өдий олон дуу хоолой, сонголт дунд Галилын даруу Эр гар сунган зогссоор, мөн хүлээсээр л байна. Түүний захиас нь энгийн: “Ирж, Намайг дага” (Лук 18:22). Тэрээр хүчтэй чанга яригчаар ярьдаггүй, харин намуухан хүнгэнэх дуугаар ярьдаг (Хаадын дээд 19:12-ыг үзнэ үү). Биднийг тал бүрээс дайрах янз бүрийн

мэдээллүүдийн урсгал дунд сайн мэдээний үндсэн захиас гээгдэх нь амархан байдаг.

Ариун судрууд болон амьд бошиглогчдын хэлсэн үгс нь сайн мэдээний үндсэн сургаал, зарчмуудыг онцолдог. Яагаад бид эдгээр үндсэн зарчимд болон цэвэр ариун сургаалд эргэн ханддаг вэ гэвэл, эдгээр нь гүн утга учиртай үнэний үүд хаалга юм.

Үндсэн гол зүйлс: Гол дөрвөн харилцаа

Бид Тэнгэрлэг Эцэгтээ хандан хамгийн чухал зүйлсийн талаарх Түүний мэргэн ухааныг асуухдаа дараах гол дөрвөн харилцааны тухай дахин дахин сурдаг. Үүнд: Бурхан бидний хоорондох харилцаа, гэр бүлийн болон найз нөхдийн харилцаа, мөн бидний өөрсөдтэйгөө харилцах харилцаа орно. Бид өөрсдийн амьдралыг оюун санаагаараа шинжиж үзвэл, хэрхэн уг илүү дөт, илүү сайн замаас холдсоноо харах болно. Бидний ойлголтын мэлмий нээгдсэнээр, бид зүрх сэтгэлээ ариусгаж, амьдралаа дахин шинээр чиглүүлэхийн тулд юу хийх хэрэгтэй байгаагаа олж харах юм.

Нэгдүгээрт, Бурхан ба бидний хоорондох харилцаа бол хамгийн ариун нандин бөгөөд зайлшгүй шаардлагатай харилцаа юм. Бид бол Түүний сүнсэн хүүхдүүд. Тэр бол бидний Эцэг. Тэр бидэнд аз жаргал хүсдэг. Бид Түүнийг хайж, Түүний Хүү Есүс Христийн талаар суралцахын хэрээр, мөн Ариун Сүнсний нөлөөнд зүрх сэтгэлээ нээхийн хэрээр бидний амьдрал илүү тогтвортой бөгөөд амар амгалан болдог. Бид Бурханы мөнхийн төлөвлөгөөний дагуу амьдарч, Түүний зарлигуудыг дагахын тулд чадах бүхнээ хийх аваас бид илүү агуу амар амгалан, баяр баясгалан, ололт амжилтыг мэдрэх болно.



Гэр бүлтэйгээ харьцах харилцаа

Бид Тэнгэрлэг Эцэгийн тухай сурч, Түүнтэй ярьж, нүглээ наманчлан, Есүс Христийг идэвхтэй дагаснаар Түүнтэй харилцах харилцаагаа хөгжүүлдэг. “Хэн ч [Христээр] дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй” (Иохан 14:6). Бид Бурхантай харилцах харилцаагаа сайжруулахын тулд ганцаараа байхдаа Түүнтэй хамт цагийг өнгөрүүлэх хэрэгтэй. Бурхантай харилцаагаа хүчирхэгжүүлэхийн тулд бидэнд Түүнтэй хоёулхнаа байх утга учир бүхий цаг хугацаа хэрэгтэй. Өдөр бүрийн хувийн залбиралдаа болон судраас суралцахад, мөн ариун сүмийн эрхийн бичгээ байнга хүчинтэй байлгахыг хичээхэд анхаа-

рах хэрэгтэй. “Тэмцэлдэхээ больж, намайг Бурхан гэдгийг мэд” гэсэн дууллын урилгад анхаарлаа хандуулцгаая (Дуулал 46:10).

Хоёрдугаар харилцаа нь бидний гэр бүлтэйгээ харилцах харилцаа юм. Өөр ямар ч амжилтаар орлуулж болшгүй

Найз нөхөдтэйгөө **харьцах харилцаа**

чухал учраас гэр бүлийн харилцааг онцгойлон үзэх хэрэгтэй.³ Бид гэр бүлээрээ оройн хоол идэх, гэр бүлийн үдэш хийх болон зүгээр хамтдаа хөгжилтэй байх зэрэг энгийн зүйлсийг цутгаа хийснээр ойр дотно, үнэнч харилцааг бий болгодог. Гэр бүлийн харилцаанд *хайр* гэдэг үгийг *ц-а-г*, цаг гэж үсэглэдэг юм. Бие биедээ цаг зарцуулах гэдэг бол гэр орондоо эвтэй найртай байхын түлхүүр. Бид нэг нэгнийхээ тухай ярих биш, харин нэг нэгэнтэйгээ ярьдаг. Бид бие биенээсээ сурч, адил зан чанар болон ялгаатай талууддаа талархдаг. Бид гэр бүлээрээ залбирч, сайн мэдээнээс суралцаж, ням гарагт шүтэн биширснээр Бурханд хамтдаа очих тэнгэрлэг хэлхээ холбоог үүсгэдэг.

Гуравдугаар гол харилцаа нь бидний найз нөхөдтэйгөө харилцах харилцаа юм. Бид бусдын хэрэгцээнд чин сэтгэлээсээ хандаж, тэдэнд үйлчилж, өөрсдийн цаг зав, авьяас чадвараа зориулан хүн нэг бүртэй нөхөрсөг харилцааг бий болгодог. Өндөр настай, өвчин зовлонд шаналсан нэгэн эгч нэг их зүйлийг хийж чадахгүй ч, бусдыг сонсож чадна гэж шийдсэнд нь би гайхаж билээ. Иймээс долоо хоног бүр тэрээр санаа сэтгэл нь зовж, урам хугарсан

хүмүүсийг хайж, тэднийг сонсон, тэдэнтэй цагаа хамт өнгөрүүлдэг байжээ. Тэрээр хэчнээн олон хүний амьдралд ямар гайхалтай адислал болсон гээч.


Дөрөвдүгээр гол харилцаа нь бидний өөрсөдтэйгөө харилцах харилцаа юм. Бидэнд өөрсөдтэйгөө харилцах харилцаа байдаг гэж бодоход хачин санагдаж болох юм. Гэвч энэ нь үнэхээр байдаг. Зарим хүн өөртэйгөө таардаггүй. Тэд бүр өөрсдийгөө үзэн ядаж эхэлтлээ бүх л өдөржингөө өөрсдийгөө шүүмжилж, өөртөө сэтгэл дундуур байдаг. Та бүхэн яаруу тэвдүү байдлаа багасгаж, өөрсдийгөө илүү сайн мэдэж авахад цаг гаргахыг би санал болгож байна. Байгалийн сайханд алхаж, нар мандахыг харж, Бурханы бүтээлүүдэд баясаж бай. Сэргээгдсэн сайн мэдээний үнэнүүдийг тунгаан бодоод, эдгээр нь чиний хувьд ямар утга учиртайг эргэцүүл. Бурхан чамайг Өөрийн тэнгэрлэг чадавх бүхий хайртай охин, хайртай хүү гэж хардаг шиг өөрийгөө харж сур.

Эгэл жирийн зүйлс дэх хүч чадал

Хүч чадал гэдэг нь яарч тэвдсэнээр биш, харин үнэн ба гэрлийн бат бөх сууриа тавьснаар ирдэг юм. Энэ нь анхаарал, хичээл зүтгэлээ Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний үндсэн зүйлс дээр төвлөрүүлснээр ирдэг. Мөн энэ нь хамгийн чухал бурханлаг зүйлс дээр анхаарал хандуулснаар ирдэг.

Амьдралаа бага зэрэг энгийн болгоцгооё. Бид бүтдийг үргэлж утга учиртай, баяр хөөртэй, амар амгалан амьдрал руу хөтөлдөг Христийн дагалдагчийн даруу бөгөөд урам хайрласан, энгийн сайхан зам руу өөрсдийгөө эргэн хандуулахад шаардлагатай өөрчлөлтүүдийг хийцгээе. ■

2010 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээс авав.



Өөрсөдтэйгээ **харьцах харилцаа**

ЭШЛЭЛҮҮД

1. Махатма Ганди, in Larry Chang, *Wisdom for the Soul* (2006), 356.
2. Далин Х.Өүкс, “Сайн, илүү сайн, хамгийн сайн,” *Луахона*, 2007 оны 11-р сар, 107.
3. Ж.И.Маккулох, *Home: The Savior of Civilization* (1924), 42; see also Conference Report, 1935 оны 4-р сар, 116.

БИДНИЙ ОРОН ЗАЙ

ЯРИЛЦЛАГЫН САНААНД ОРОМГУЙ АСУУЛТ

Номлолынхоо дараа би ажил олж чадахгүй байлаа. Удалгүй би нэгэн ярилцлаганд орсон юм. Албан тушаал нь гайхалтай боломж байсан ч би өөрийгөө хангалттай чадвартай эсэхэд санаа зовж байв. Ярилцлаганд орох миний ээлж болж, би менежерийн өмнө тэвдүүхэн суулаа. Би түүний ширээн дээр ажил хайгчдаас асуух асуултуудтай цаас байхыг харав. Миний зүрх түт түт цохилж эхэллээ. Асуултууд нь түвэгтэй үгнүүдтэй байв.

Менежер миний товч намтрыг барьж байгаад, ажлын туршлагын минь талаар асууж эхлэв. Тэр “бүрэн цагийн номлогч” гэсэн үгийг уншаад, номлолдоо юу заадаг байснаа хэлж өгөхийг хүсэв.

Би түүнтэй бошиглогчид, авралын төлөвлөгөө болон гэр бүлүүдийн талаар ярилцсан. Тэр инээмсэглээд, “Би таныг ирж, гэр бүлийнхэнтэй минь танилцаасай гэж хүсэж байна” гэж хэлэв.

Тэр ярилцлагын асуултуудтай

цаасаа дахин авахад би дахин сандарч эхэллээ. Тэр “Танд Манилд амьдрах газар байгаа юу?” гэж асуув. Тэр миний хариултыг хүлээлгүй, “Та амьдрах газар хайх хэрэгтэй. Та маргааш ажлаа эхэлнэ” гэж хэлэв.

Энэ бол чухамдаа гайхамшиг байлаа. Номлолд үйлчилсэн маань миний ажлын ярилцлаганд хэрхэн тус болсныг би хэзээ ч мартаггүй. ■

Алвин А. Филиппин

ХАВЧЛАГА ДУНДАХ АМАР АМГАЛАН

Би дараагийн үг хэлэгчийн Мормоны Сүм яагаад буруу вэ, мормончууд яагаад хоёр нүүртэй үзэн ядагчид байдаг вэ гэсэн сэдвийг сонсоод, сандал дээрээ цэх суулаа. Ярианы туршид хацар минь халуу шатаж, чээжийг минь гүн цочрол болон таагүй мэдрэмж дүүргэв. Миний найз намайг хожмын үеийн гэгээнтэн гэдгийг мэдсээр байж, англи хэлний хичээл дээр сурагчдын өмнө яаж ийм муухай зүйл хэлж чадав аа?

Хонх дуугарсны дараа үг хэлэгч болон бусад найз маань над дээр ирэв. Би дотор минь шатаж буй Сүнсээр, энд хэлэгдсэн зүйлүүд нь буруу бөгөөд Сүм бидний итгэл үнэмшлийн дагуу амьдардаггүй хүмүүсийг үзэн яддаггүй гэж хэлэв. Хариуд нь тэд миний эсрэг хуурамч

мэдэгдлүүд ярьж, намайг зэмлэсэн юм. Би ганцаардаж байлаа. “Би үнэн гэж мэддэг зүйлийнхээ дагуу амьдарсныхаа төлөө хавчигдах нь шударга гэж үү?” гэж би бодов.

Би тэр өдөр сургуулиасаа гэртээ ирээд, эмээгээсээ ирсэн э-мэйлийг уншлаа. Тэр надад Матай 5:11–14-ийг унш гэж бичсэн байв. Би нүдэндээ нулимстайгаар: “Надаас болж та нарыг хүмүүс доромжилж, хавчиж, хуурамчаар та нарын эсрэг зүсэн бүрийн хорон мууг ярихад та нар ерөөлтэй еэ! Тэнгэр дэх шагнал тань агуу учир баярлацгаа, мөн баяр хөөртэй байцгаа. Учир нь та нараас өмнө байсан эш үзүүлэгчдийг тэд ийнхүү хавчсан юм. Та нар бол дэлхийн гэрэл мөн. Уулан дээрх хот нуугдаж үл чадна” гэж уншлаа.

Эдгээр үгийг унших үед Ариун Сүнс зүрх сэтгэлийг минь дүүргэсэн юм. Хавчлага нь бидний гэрчлэлүүдийг хүчирхэгжүүлнэ гэдгийг би мэднэ. Мөн тэнгэр дээрх адислалууд бидний дэлхий дээр амсдаг зовлонгоос илүү агуу гэдгийг би мэднэ. Бид сайн мэдээний дагуу амьдарсныхаа төлөө хавчигдах үедээ амар амгаланг олох боломжийг Аврагч бидэнд өгсөнд би үнэхээр талархаж байна. ■

Бека Ф., АНУ, Монтана





ХӨГЖИМ СОНСОЖ, МУУ ЗҮЙЛЭЭС ЗУГТАХ АРГА

Би сургуулийн тойрон аяллын үеэр автобусаар явж байхдаа нэг охины урд суусан бөгөөд түүний хэлж байсан бүдүүлэг үг хэллэг, тоглоом тохуу надад маш эвгүй санагдаж байв. Багш болон бусад оюутан түүнийг болиулахыг хичээсэн боловч тэр больсонгүй. Би юу хийхээ мэдэхгүй байсан учраас MP3 тоглуулагчаа гаргаж ирээд, дуртай хөгжмөө сонсохоор шийдсэн юм.

Би дуунуудаа нийлүүлсэн бөгөөд эхний дуу нь youth.lds.org/music дээрээс авсан дуу байлаа. Би энэ дууг алгасах гэж байтал миний дотор ямар нэгэн зүйл энэ дууг сонсох хэрэгтэй гэж хэлэв. Би 20 минутын

турш сүнслэг хөгжим сонссоор байлаа. Дуунуудын үгс нь намайг тэвчээртэй байхад урамшуулж, би бол Тэнгэрлэг Эцэгийн охин гэдгийг надад сануулж байсан юм.

Долоо хоногийн сүүлчээр сургууль дээр бүжиг болов. Хэдийгээр тэнд алдартай бүжгийн дуунуудын цэвэр хувилбарыг тоглуулж байсан ч, манай ангийн хүүхдүүд нэг дууны арилгасан үгийг чанга дуугаар хэлж байлаа.

Надад бас л эвгүй байлаа. Багш нар хажууд сууж байсан ч, үүнийг анзаарсангүй. Би бугуй руугаа харав. “Ариун газруудад зогсогтун та нар, бүү шилжин нүүлгэгд (С ба Г

87:8)” гэсэн бичигтэй өсвөр үеийнхний чуулганаас авсан бугуйвчаа би харлаа.

Миний зогсож байсан газар ариун газар биш гэдгийг би мэдэж байсан учраас өөр дуу явах хүртэл гадагш гарав.

Хөгжим бидний амьдралд хүчтэй нөлөө үзүүлж чадна гэдгийг би мэднэ. Хэдэн өдрийн өмнө MP3 дээрээ урам хайрласан хөгжим сонссон нь надад бүжгийг орхиж гарах зориг өгснийг би мэднэ. Эдгээр туршлага нь Тэнгэрлэг Эцэгтэйгээ илүү ойр дотно болоход надад тусалсан юм. ■

Аликса Б., Нидерланд

ИОХАН БАПТИСТТАЙ АДИЛ САЙН МЭДЭЭГ ХУВААЛЦАХ НЬ

*Иохан Баптист
Аврагчийн эхний
црэлтэнд хүмүүсийг
бэлтгэсэн шиг та
нар Аврагчийн
Хоёр дахь црэлтэд
бэлтгэхэд нь хүмүүст
тусалж чадна.*

Раян Карр
Сүмийн сэтгүүлүүд

Та нар Иохан Баптисттай адил “Иудейн цөлд” (Матай 3:1) номлолд үйлчлэхгүй. Та нар “тэмээн ний ноосоор” (Матай 3:4) хийсэн хувцас өмсөхгүй. Та нар “царцаа болон зэрлэг зөгийн бал” (Матай 3:4) идэх хэрэггүй. Гэхдээ сайн мэдээг хуваалцах та нарын зорилго Иохан Баптистынхтай адил юм. Та нар “Тэмшицгээ! Тэнгэрийн хаанчлал ойрхон байна гэж” (Матай 3:2) хашгирах арга замаар хүмүүсийг Есүс Христийн ирэлтэнд бэлтгэдэг.

Иохан Баптистын номлол тодорхой байсан: “тэрээр Их Эзэний замыг бэлтгэхээр, Мессиагийн өмнө ирэх нэгэн” (1 Нифай 10:7) байсан юм. Гэвч түүний номлол амар байгаагүй. Түүний өмнөх сүүлчийн бошиглогч нь 400 гаруй жилийн өмнө амьдарч байсан Малахи юм. “Бошиглогчгүйгээр тэр нутаг дахь хүмүүс судруудыг орчуулж, хүмүүсийг удирдах эрхийг өөрсдөдөө олгосон хэсэг, бүлгүүдэд хуваагдаж эхлэв. Иеховагийн талаарх үнэн бодит ойлголт эдгээр бүлгийн дунд багасчээ.”¹

Иоханы өдрүүдэд бэрхшээлүүд байсан ч гэлээ, олон хүн түүний номлохыг сонсох гэж цөлд ирсэн бөгөөд тэр олон хүнд баптисм хүртээсэн. Ирээдүйд төлөөлөгч болох хайрт Иохан, Андрей нар Иоханаар

дамжуулан Есүстэй танилцсан юм (Иохан 1:40-ийг үзнэ үү).

Сайн мэдээг хуваалцахад өнөөдөр ч гэсэн бэрхшээлтэй байдаг. Орчин үеийн амьдралд анхаарал сарниулах зүйл олон байгаа. Дэлхийн гүн ухаан хүмүүсийг буруу тийш удирддаг. Илүү олон хүн ёс суртахууны өндөр жишгүүдээр амьдрахаа больж байна. Зарим хүн шашин хэрэггүй гэж үздэг.

Эдгээр нөхцөл байдалд та нар Иохан Баптист шиг сайн мэдээг хэрхэн амжилттай хуваалцаж чадах вэ? Түүний амьдралаас авсан, бидэнд тусалж чадах хэдэн зүйлийг доор харуулав:

Иохан өөрийн номлол юу вэ гэдгийг мэдэж байсан. Тэр Христэд ирэхэд нь хүмүүст туслахаар дуудагдсан гэдгээ мэдэж байсан (Лук 1:16-г үзнэ үү). Иохан Аврагчийг хараад, “Ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы Хургыг харатгун” (Иохан 1:29) хэмээн гэрчилсэн билээ. Тэр хүмүүсийг өөрийг нь дагахад урамшуулахын оронд Есүс Христийн дагалдагчид болоход нь тэдэнд тусалсан. Иохан Баптист Аврагчийн тухай “Тэр өсөж, харин би буурах ёстой” (Иохан 3:30) хэмээн хэлжээ.

Иохан Есүс Христийн сайн мэдээний үндсэн зарчмуудыг заасан



юм. Тэр шударга ёс, нигүүлсэл, шударга зан, ёс суртахуун, мацаг барилт, залбирал, наманчлал, нүг-лийн хүлээлт, усанд умбуулалтаар хийгдэх баптисм, амилалт, шүүлт зэргийн талаар хүмүүст заасан (Матай 3; Лук 3-ыг үзнэ үү). Түүний заасан зүйлсийг Аврагчийнхтай адил гэж дүрсэлж болно: “Хүмүүс Түүний сургаалыг гайхаж байлаа. Учир нь тэр . . . эрх мэдэлтэй нэгэн мэт тэдэнд сургаж байв” (Марк 1:22).

Иохан дэлхийнхнээс өөрөөр амьдарсан. Есүс Иоханыг дэлхийн багш нартай дараах байдлаар харьцуулсан: Иохан “Хээнцэр хувцасласан . . . хээнцэр гоёмсогор хувцаслаж, . . . хаадын ордонд байдаг” (Лук 7:25)

хүн байгаагүй юм. Тэрээр “дарс, эсвэл согтоох ундааг хэзээ ч” (Лук 1:15) амсаагүй юм. Иохан “Цөлд хаширагч нэгний дуу ЭЗЭНий замыг бэлтгэгтүн, Түүний замыг шулуун болгогтун” (Марк 1:3) гэж хэлэх хүн байсан юм. Тэр Бурханы хүчээр заасан учраас хүмүүс Сүнийг мэдэрч, мөн хөрвүүлэгдсэн.

Иохан бүхнээ зориулдаг байсан. Нэг эрдэмтэн Иоханы зан чанарыг ийн дүгнэн хэлжээ: “Тэр зорилгодоо бүхнээ зориулж, онцгой дуудлагадаа өөрийгөө зориулж, мөн Бурханы Хүүд үнэнч байсан. Эдгээр чанар болох түүний санваарын эрх мэдэл, байр сууриа хадгалах болон хувийн зөв шударга байдал нь түүнийг

судрууд дээрх хамгийн агуу дүрүүдийн нэг болгодог.”²

Та нар Иохан Баптистын амьдралыг судлахдаа, тэр бол Есүс Христэд баптисм хүртээх онцгой адислалыг авсан хүн гэдгээс илүү агуу хүн болохыг харах болно. Түүний амьдрал ба номлол нь та нарынхтай адил хүмүүсийг Аврагчийн ирэлтэнд бэлтгэх явдал байсан гэдгийг та нар харах болно. ■

ЭШЛЭЛҮҮД

1. С.Кэнт Браун ба Ричард Нийцл Холзапил, “Алдагдсан 500 жил: Малахигаас Иохан баптистыг хүртэл,” *Лиахона*, 2014 оны 12-р сар, 30.
2. Роберт Ж.Мэттьюс, “John the Baptist: A Burning and a Shining Light,” *Ensign*, 1972 оны 9-р сар, 79.



ТА НАР ЯАГААД ЭНЭ ЦАГ ҮЕД ДЭЛХИЙ ДЭЭР БАЙГАА ВЭ?

“Та бид Түүний ирэлтэнд баясаж, Түүнийг ирэхээс өмнө дэлхийг бэлтгэхэд туслахаар энэхүү цаг үед биднийг дэлхийд илгээсэнд Их Эзэнд талархах болно.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэн, “Дэлхийг Хоёр дахь ирэлтэд бэлтгэх нь,” *Лиахона*, 2011 оны 5-р сар, 52.

ХЭРВЭЭ ... ТЭГВЭЛ ЯАХ ВЭ?

Номлолд үйлчлэх талаар асуудаг асуултууд

Номлолд үйлчлэх хугацаа чинь ойртох тусам чи өөрөөсөө “Би үнэхээр үүнийг хийж чадах уу?” гэж асууж болох юм. Чи чадна! Энэ нь амаргүй байж болох ч, чи номлолд үйлчилсэндээ хэзээ ч харамсахгүй.

Номлолд үйлчлэхээр бэлтгэх нь сүрдмээр зүйл байж мэднэ. Мөнгө, мэдлэг, ичимхий зан гэх мэт чиний санааг зовоож болох олон зүйл байгаа ч, чи өөртөө хэрэгтэй баталгаа, зоригийг олж авч чадна. Айдсаа даван туулж, номлолдоо явах итгэлтэй болоход чинь туслах зарим нийтлэг асуулт, хариултыг энд дурдлаа.

Хэрэв би судруудыг, эсвэл сайн мэдээний талаар хангалттай сайн мэдэхгүй байвал яах вэ?

Сайн мэдээг судлах нь номлолын өмнө зайлшгүй хийх ёстой бэлтгэл боловч чи явахаасаа өмнө бүх зүйлийг мэдэх шаардлагагүй. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэн өөрийгөө номлолд явахад бэлэн биш гэж санаа нь зовж байжээ. “Тэнгэрлэг Эцэг минь ээ, би ийм бага зүйл мэддэг байж, яаж номлолд үйлчилж чадах юм бэ? хэмээн залбирснаа би санаж байна” гэж тэр хэлсэн юм. Би Сүмд итгэдэг ч, миний сүнслэг мэдлэг тун тааруухан гэж боддог байлаа. Намайг залбирч байх үед

“Чи юм бүхнийг мэдэхгүй, гэхдээ хангалттай зүйлийг мэднэ” гэсэн мэдрэмж ирж билээ.¹

Чи сайн мэдээний зарчмуудыг сурахын тулд итгэлтэйгээр үйлдэж, судруудыг судалбал, сайн мэдээний мэдлэг ирэх болно. Мөн чи ганцаараа биш байх болно. Ариун Сүнс чамайг удирдах бөгөөд танд туслах хамтрагч, номлолын удирдагчид болон номлолын ерөнхийлөгч байх болно. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холландын заасан зүйлийг сана: “Итгэл чинь хэр бат бөх эсвэл мэдлэг чинь хэр гүнзгий байна вэ гэдэг тань тийм чухал биш бөгөөд харин танд байгаа итгэл, олж авсан үнэнээ хэрхэн ашиглаж байгаа тань л чухал юм.”²

Хэрэв би гэрчлэлтэй эсэхээ баттай мэдэхгүй бол яах вэ?

Гэрчлэлтэй болох явдал нь номлолын бэлтгэлийн маш чухал хэсэг. Гэрчлэл чинь сүл юм шиг санагдаж болно, гэхдээ чи үүнийг сайжруулахын тулд чин сэтгэлээсээ чармайвал гэрчлэл чинь өсөх болно. Үүнийг сана:


- *Судалж, залбирах нам гүмхэн цаг гарга.* Чамд Сүнсний өдөөлтийг мэдрэх цаг байх хэрэгтэй.
- *Сайн мэдээний дагуу амьдар.* Энэ нь яагаад та нарын гэрчлэлийг өсөхөд тусалдгийг харахын тулд Иохан 7:17-г үзнэ үү.
- *Бага багаар сайжруул.* “Бидний сүнслэг байдлын аян бол насан туршийн үйл явц учраас бид шууд эхлэнгүүт, бас явцын дунд ч бүх зүйлийн тухай мэдэж чадахгүй. Бидний хөрвөлт алхам алхмаар ирдэг.”³

Чиний гэрчлэл бодож байгаагаас чинь илүү хүчтэй байж магадгүй гэдгийг санаарай. Ахлагч Холланд дараах түүхийг хуваалцсан юм: “14 настай нэгэн хөвгүүн надад эргэлзсэн байдалтайгаар “Холланд ах аа, Сүм үнэн гэж би хараахан хэлж чадахгүй ч гэсэн, үнэн гэдэгт итгэж байна” гэж хэлж билээ. Би тэр хөвгүүнийг бараг нүдийг нь бүлтэртэл чангаар тэвэрч, *итгэх* гэдэг үг, үйлдэл нь хэчнээн ариун нандин болох талаар, бас тэр хэзээ ч “зөвхөн

итгэж” байгаадаа уучлал хүсэх ёсгүйг зүрх сэтгэлийнхээ гүнээс түүнд зөвлөн хэлсэн юм. Христ хүртэл “Бүү ай. Зөвхөн итгэ” гэж хэлсэн . . . гэж би түүнд сануулж билээ. . . . Мөн би тэр хүүд итгэл нь бүрэн үнэмшил рүү хөтөлдөг . . . гэж бас хэлсэн юм. . . . Өөрийнхөө итгэлийн эрэлд үнэн сэтгэлээсээ хандаж байгаад нь би хэчнээн их бахдаж байгаагаа мөн тэр хөвгүүнд хэлсэн.”⁴

Хэрэв би өөрийгөө зохистой биш гэж бодож байвал яах вэ?

Хэрэв амьдралд чинь ямар нэг буруу зүйл байгаа бол чи үүнийг шийдэж чадна. Салбарын ерөнхийлөгч эсвэл бишоп чинь Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан цэвэр болохын тулд юу хийх ёстойгоо мэдэхэд чинь тусална. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г.Скотт “Би та нарыг номлолд явах ёстой юу, үгүй юү гэж залбирахын оронд зохистой, хүч чадалтай бүрэн цагийн номлогч болохын тулд шаардлагатай зүйлийг хийхэд удирдахыг Их Эзэнээс гүйхыг хичээнгүйлэн хүсэж байна” гэсэн юм.⁵





ЗАЛУУ ЭМЭГТЭЙЧҮҮД БА НОМЛОЛД ЯВАХ ШИЙДВЭР

Залуу эмэгтэйчүүд номлолд явах үүрэг хүлээгээгүй боловч явах боломж байгаа. Та нарыг үйлчлэх эсэхээ шийдэх үед та нарт дараах асуултууд бий болж магадгүй:

- ▶ Номлолд явах нь миний хувьд зөв үү? Би хэрхэн мэдэж болох вэ?
- ▶ Би өнөөдрөөс бүрэн цагийн номлолд бэлтгэх ёстой юу?
- ▶ Би үйлчлэх ямар шалтгаануудыг бодож үзэх ёстой вэ?
- ▶ Би сайн номлогч болж чадах болов уу?

Хариултуудыг болон удирдамжийг “Залуу эмэгтэйчүүд ба номлолд явах шийдвэр,” *Лиахона*, 2013 оны 1-р сар, 32-35-аас уншина уу.

Оросын Ребека С. туршлагаа хуваалцахдаа: “Хэдийгээр би наманчилсан ч миний алдаанууд маш ноцтой байсан тул гэм буруу болон зовиураасаа болж би өөрийгөө номлолд үйлчилж чадахгүй гэж бодсон. Гэвч бишоп болон гадасны ерөнхийлөгч маань амьдралдаа Цагаатгалын эдгээгч хүчийг ойлгоход тусалсан юм. Би наманчлалд маш их талархаж байна. Зөв зохистой байх нь номлолын ажлын хамгийн чухал зүйл. Хэрэв чи зөв зохистой биш байвал Сүнсээр зааж чадахгүй (С ба Г 42:14-ийг үзнэ үү). Чи бүх зүрх сэтгэлээрээ үйлчлэхийн тулд зүрх сэтгэлдээ амар амгаланг мэдэрч байх ёстой. Энэ нь бүх зүйлийг өөрчлөх болно” гэжээ.

Би гэр бүлээ болон найзуудаа яаж орхих вэ?

Хайртай хүмүүсээ орхино гэдэг, ялангуяа эргээд ирэхэд найзууд, гэр бүлийнхэн болон өөрт чинь бүх зүйл өөр байна гэдгийг мэдэх нь хэцүү байдаг. Чамайг байхгүйд гэр бүл чинь санхүүгийн тал дээр ямар байхыг, эсвэл тэд номлолд явах шийдвэрийг чинь яаж хүлээж авах талаар чи санаа зовж байж магадгүй. Гэхдээ Их Эзэн чиний хайртай хүмүүст санаа тавьж, мөн чиний үйлчлэлийн хариуд тэднийг адислах болно (С ба Г 100:1-ийг үзнэ үү). Хэдийгээр чи тэднийг санах боловч бусад гэр бүлд сайн мэдээний аз

жаргалыг олоход нь туслах ажилд чи Их Эзэнд хэрэгтэй. Тэнгэрлэг Эцэг чамд болон чиний гэр бүлд хамгийн сайн сайхныг хүсдэг гэдэгт итгэж, мөн “Итгэл нь Бурхан бидний хүн нэг бүрд зориулж агуу зүйлүүдийг хадгалсан байгаа гэдэгт итгэдэг” гэдгийг санаарай.⁶ Чи номлолд явах итгэлтэй болох үед чамайг болон гэр бүлийг чинь Их Эзэний агуу адислалууд хүлээж байх болно.

Хэрэв би номлолын мөнгөө төлж чадахгүй бол яах вэ?

Номлолын нийт зардал нь том золиослол мэт санагдаж болох ч, Их Эзэн чамаар юу хийлгэхийг хүсэж буйгаа мэднэ. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгч Бонд К.Пакэр “Би номлолынхоо зардлыг яаж олохоо мэдэхгүй байгаа залуу эрэгтэйд хандан ярьж байна. Номлолын зардлаа яаж олохыг би ч бас сайн мэдэхгүй байна. Гэхдээ би нэг л зүйлийг мэднэ: Хэрэв чи итгэлтэй байж, номлолд явна гэж шийдэх юм бол арга зам нь олдох болно”⁷ хэмээн хэлжээ.

Английн Лоран С. дараах туршлагыг хуваалцсан юм: “Намайг номлолын өргөдлөө дөнгөж бөглөж эхэлж байхад, зээлийн картны их өртэй байна гэж банкнаас хэллээ. Бишоп бид хоёр өр, номлол, аравны нэгд болон бусад зардалдаа хэдийг зарцуулах талаар төсөвлөсөн юм. Энэ

нь их золиослол шаардсан бөгөөд би зорилгодоо хүрч чадахгүй нь гэж бодож байлаа. Гэвч би итгэлтэйгээр аравны нэгээ төлсөн бөгөөд Их Эзэний тусламж ч ирсэн. Нэг үл таних хүнээс ирсэн бэлэг надад өрөө төлж, номлолд явах зорилгоо биелүүлэхэд тусалсан юм.

Хэрэв би хүмүүстэй ярихаас ичдэг бол яах вэ?

Өдөр бүр бүхэл өдөржингөө танихгүй хүмүүстэй ярих нь хэцүү байж болно. АНУ-ын Калифорнийн Сэм Л. дараах түүхийг хуваалцсан: “Тэрийнхээ хаалгыг ч онгойлгохыг хүсдэггүй хүний хувьд огт танихгүй хүний хаалга тогшиж, сайн мэдээний талаар ярина гэдэг боломжгүй мэт санагдаж байв.

“Нэг гадасны чуулган дээр бидэнд номлогчидтой хамт гадуур явж, сайн мэдээг номлох боломж гарсан юм. Жинхэнэ номлогчидтой хамт явна гэж үү? Жинхэнэ хүмүүс рүү юу? Би сандарч байсан ч нэгэн судрыг саналаа: ‘Учир нь Би бол чиний баруун гараас атгадаг чиний Бурхан ЭЗЭН билээ. Би чамд Бүү ай. Би чамд тусална гэж айлдаж байна’ (Исаиа

41:13). Би энэхүү тусламжийн төлөө залбирч, сандарсан хэвээр байсан ч Ариун Сүнсний хүчийг мэдэрч, хоёр ч Мормоны Номыг хүмүүст өгсөн.”

Номлолд явах нь миний боловсролд, эсвэл мэргэжилд муугаар нөлөөлбөл яах вэ?

Номлолд явахын тулд их сургуулиа юм уу, ажил мэргэжлээ хойш нь тавьснаараа ирээдүйгээ эрсдэлд оруулж байна гэж чи бодож болно, гэхдээ энэ нь эсрэгээрээ үнэн юм. Их Эзэн чамайг амжилтанд хүрээсэй гэж хүсдэг бөгөөд Тэр чамд тусална. Та нарын гаргах ямар ч золиослол номлолын үйлчлэлээс илүү чухал биш байх болно.

Маш олон залуу адил шийдвэр гаргасан байдаг. Австралийн Виллиам Х. амжилттай хичээллэж байсан рагби спортоо орхисон бөгөөд гэртээ эргэж ирээд, дахин тоглож чадах эсэхээ мэдэхгүй байжээ (“Номлолд цаг гаргах нь,” *Лиакхона*, 2012 оны 6-р сар, 50–52-ыг үзнэ үү). Филиппиний Жозеф Б. боловсрол эзэмших - амьдралд ганц олдох боломжоос татгалзахаар их сургуулийн нарийн бичгийн өрөө рүү орсон байна (“For a Burnt Offering,”

Лиакхона, 2007 оны 9-р сар, 40–42-ыг үзнэ үү). Чиний найдаж байсан зүйлүүд номлолын чинь дараа болсон ч бай, эсвэл болоогүй ч бай, номлогчоор үйлчлэх боломжоос илүү агуу зүйл гэж байхгүй.

Харамсах зүйлгүй

Тэнгэрлэг Эцэг биднийг аз жаргалтай байгаасай гэж хүсдэг. Түүний биднээс хүсдэг зүйлүүд нь биднийг адисалж, бидэнд тусалдаг. Хэрэв Их Эзэний чамаас хүссэн зүйл хэцүү байсан ч гэсэн чи итгэлтэйгээр хийвэл, адислалууд нь энэ дэлхийн ямар ч зүйлээс илүү гэдгийг мэдэх болно. Чи номлолд үйлчилсэндээ хэзээ ч харамсахгүй. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Нийл Л.Андэрсэн, “Чи хангалттай ихийг мэднэ,” *Лиакхона*, 2008 оны 11-р сар, 13.
2. Жэффри Р.Холланд, “Эзэн минь, би итгэж байна,” *Лиакхона*, 2013 оны 5-р сар, 100.
3. Нийл Л.Андэрсэн, “Чи хангалттай ихийг мэднэ,” 13.
4. Жэффри Р.Холланд, “Эзэн минь, би итгэж байна,” 94–95.
5. Ричард Г.Скотт, “Now Is the Time to Serve a Mission!” *Лиакхона*, 2006 оны 5-р сар, 90.
6. Жэффри Р.Холланд, “The Best Is Yet to Be,” *Лиакхона*, 2010 оны 1-р сар, 21.
7. Бонд К.Пакэр, “Come, All Ye Sons of God,” *Ensign*, 1983 оны 8-р сар, 71.



“Нэг найз маань ямар нэг муу зүйлийг ердөө ганцхан удаа хийж үзэхийг хүсэж байна. Хүмүүсийг энэ тухай ярих үед тэр үүнийг хийж үзсэн байх хүсэлтэй байгаа гэнэ. Энэ нь сайхан санаа биш гэдгийг ойлгоход нь би түүнд хэрхэн тусалж чадах вэ?”

Чиний хийж чадах хамгийн сайн зүйлүүдийн нэг нь бидэнд яагаад зарлигууд байдгийг найздаа сануулах явдал юм. Тэнгэрлэг Эцэг биднийг хайрладаг учраас зарлигуудыг өгдөг. Зарлигууд нь биднийг аз жаргалтай болгож, мөн Түүнтэй адил болоход тусална гэдгийг Тэр мэддэг юм.

Шинэ Гэрээнд Аврагч “Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь” (Иохан 14:15) хэмээн хэлжээ. Зөв зүйлийг сонгосноороо бид Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг хайрлах хайр болон Есүсийн Цагаатгал ба сайн мэдээнд талархаж байгаагаа харуулдаг гэдгийг ойлгоход нь найздаа тусал.

Чи түүнд муу зүйлийг нэг удаа хийсэн ч гэсэн энэ нь муу үр дагавар авчирдаг гэдгийг сануулж болно. Бид нүгэл үйлдсэн л бол үр дагаврыг нь амсдаг. Зарлигуудыг санаатай зөрчих нь Тэнгэрлэг Эцэгээс нүүр буруулж, Тэр бол найзууд болон бусад хүмүүсээс чухал биш гэж Түүнд хэлж байгаатай адил юм.

Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай бөгөөд бид Түүний зарлигуудыг сахих үед Тэр биднийг Сүнсний удирдамжаар адислах болно. Хэрэв бид дуулгавартай байвал нүгэлтэй орооцолдсоноос илүү их зүйлийг Сүнс бидэнд заана.



Бид нүглийг туршиж үзэх шаардлагагүй.
Би найзад чинь
“Учир нь сайн бүхэн
Бурханаас ирдэг, мөн
хилэнцэт болох юу

боловч чөтгөрөөс ирдгийг” (Алма 5:40) заах байсан. Би бас үйлдэл бүр үр дагавартай байдаг ба бид өөрсдийгөө гэмтээх зүйлүүдийг хийх ёсгүй гэдгийг тайлбарлах байсан. Бид муу зүйлүүдийг хийж үзэх шаардлагагүй. Бидний эргэн тойронд муу муухай зүйл маш их байдаг бөгөөд зарлигуудыг сахидаггүй учраас олон хүн зовлонтой байдалд амьдардаг.

*Винишиус С., 17 настай, Бразил,
Сан Пауло*



Чи уруу таталтыг хэрхэн даван туулдгаа хэл

Их Эзэний өмнө хэрхэн зогсож байгаа нь л хамгийн чухал зүйл

гэдгийг найздаа хэл. Бид түр зуурын зүйлээр мөнхийн авралаа солих ёсгүй. Хэрэв чи уруу таталтыг хэрхэн даван туулснаа хэлбэл энэ нь илүү тустай байх болно.

Эмили Г., 19 настай, Пуэрто Рико

Бидэнд тэнгэрлэг чадавх бий

Ганц буруу сонголт хийхэд гэм хоргүй мэт санагдаж болох хэдий ч энэ нь илүү ноцтой нүглүүд рүү хөтөлж болно гэдгийг чи найздаа найрсгаар тайлбарлаж болно. Чи энэ судрыг бас хуваалцаж болно: “Учир нь Их Эзэн бибээр нүглийг өчүүхэн төдий ч хүлцсэн янзаар хүлээн зөвшөөрч чадах нь үгүй” (С ба Г 1:31). Нэг удаа нүгэл үйлдэх нь Сүнсний дуу хоолойг сонсох бидний чадварыг үгүй хийж болно гэдгийг найздаа

сануул. Хамгийн чухал нь чи найздаа хайртай гэдгээ, мөн зөв сонголтууд хийх нь Бурханы охины хувьд тэнгэрлэг чадавхынх нь нэг хэсэг гэдгийг хэлээрэй.

Адриана Ф., 17 настай, АНУ, Аризона

Ганц удаагийн үйлдэл нь хор уршигтай

Ганц удаа хийсэн ч бай, бүх муу зүйл нь Сүнсийг холдуулдаг. Хэрэв Сүнс байхгүй бол Сатанд чамайг илүү олон муу зүйл хийлгэхээр уруу татахад амархан байх болно. Мөн чи хэдэн ч удаа хийсэн бай, бүх нүглээ наманчлах хэрэгтэй. Ноцтой нүглүүдийг наманчлах нь урт удаан, шаналгаатай үйл явц байж болдог.

Эмили Л., 14 настай, АНУ, Юта



Хүчтэй бай

Найздаа хайртай гэдгээ, мөн зөвийг сонгоход нь түүнд туслахыг хүсэж байгаагаа хэл.

Бид хүмүүсийг илүү сайн ойлгохын тулд тэдэнтэй адил сонголт хийх хэрэггүй гэдгийг би хувийн туршлагаасаа мэднэ. Бид сайн мэдээний дагуу амьдарвал, хүмүүсийг ойлгоход Сүнс бидэнд тусална. Найздаа хүчтэй бай гэж хэл. Ингэснээр тэр ч бас бусдад зарлигуудыг сахихад нь тусалж чадна. Найздаа тусалж, мөн тэрээр үйлчилж болохын төлөө залбир.

Ванина П., 19 настай, Аргентин, Буэнос Айрос

Чи өөрийгөө зогсоох боломжгүй болж магадгүй

Би найздаа энэ талаар бодоод ч хэрэггүй гэж хэлнэ. Буруу зүйлийг нэг удаа хийх нь аюултай. Учир нь чи хийгээд эхэлчихвэл, өөрийгөө зогсоож чадахгүй болж ч болно.

Тэнгэрлэг Эцэг биднийг аюулгүй, мөн аз жаргалтай байлгахын тулд зарлигуудыг өгсөн.

Дуглас Б., 13 настай, АНУ, Калифорни

Энэ нь жижиг зүйлээс эхэлдэг

Ахлагч Жэффри Р.Холланд нэг удаа “мянган бээрийн аялал нь нэг алхмаас эхэлдэг учраас алхаагаа цэгнэ” хэмээн хэлсэн (“Place No More for the Enemy of My Soul,” *Лиахона*, 2010 оны 5-р сар, 45). Би найздаа Сатан биднийг буруу замаар доош удирдахын тулд жижиг уруу таталтуудыг ашигладаг гэдгийг ойлгоход нь тусална. Чи буруу зүйлийг ганц удаа л хийвэл, Сатанд болон түүний дагагчдад үүнийг олон дахин хийлгэхээр уруу татах боломж олгож байгаа юм.

Симилони Ф., 18 настай, Юта, АНУ



ЯАГААД ХИЙГЭЭД ҮЗЭЖ БОЛОХГҮЙ ГЭЖ?

“Хэдэн жилийн өмнө нэг хүү

маань архи эсвэл тамхи ямар байдгийг мэдэхийн тулд хэрэглээд үзэж яагаад болохгүй юм гэж асуусан юм. Хэрэв чи ямар нэг зүйл туршиж үзмээр байгаа бол малын саравчинд ороод малын баас идэж үзэх хэрэгтэй гэж би хэллээ. Тэр жигшсэн байдалтай ярвайж, ‘Ямар балиар юм бэ,’ гэж хэлэв.

“Чамайг тэгж бодож байгаад би баяртай байна, гэхдээ чи өөрөө мэдэхийн тулд идээд үз л дээ? Чи биед чинь муу зүйлийг амсаад үзмээр байгаа юм чинь энэ зарчмаа өөр зүйл дээр туршаад үзвэл ямар вэ?” гэж би хэлсэн юм.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Даллин Х.Өүкс. “Sin and Suffering,” Тамбули, 1994 оны 4-р сар, 32.

ДАРААГИЙН АСУУЛТ

“Аав, ээж хоёр хараал хэлж, хэт чанга хөгжим сонсож, зохистой бус телевизийн нэвтрүүлэг үздэг. Би Сүнсийг гэртээ, ялангуяа ням гарагт мэдэрэхийн тулд юу хийж чадах вэ?”

Хариултаа, хэрэв хүсвэл өндөр нягтралтай зургийн хамт liahona.lds.org хаягаар, э-мэйл бичих бол liahona@ldschurch.org хаягаар, эсвэл шуудангаар илгээх бол 3-р хуудсан дээрх хаягаар 2015 оны 7-р сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Э-мэйл эсвэл захидалдаа дараах мэдээлэл, зөвшөөрлийг оруулна уу: (1) овог нэр, (2) төрсөн огноо, (3) тойрог эсвэл салбар, (4) гадас эсвэл дүүрэг, (5) таны хариулт, гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн гараар бичсэн өөрийн тань зөвшөөрөл, 18 нас хүрээгүй бол эцэг эхийн тань бичгээр гаргасан зөвшөөрөл (э-мэйл байж болно).

Хариултын хэмжээг тохируулах эсвэл тодорхой болгохын тулд хянан засварлаж болно.

СУДАР СУДЛАХ НЬ ЗУРАГ ЭВЛҮҮЛДЭГ ТОГЛООМТОЙ АДИЛ ЮМ

Зураг эвлүүлдэг тоглоом шиг та судар судлах бүргээ Бурханы үнэнүүдийн талаар илүү том зургийг харж, ойлгох болно.

Коди Филлипс

2011 оны 9-р сард Вьетнамын нэгэн их сургуулийн оюутнууд дэлхийн хамгийн том зураг эвлүүлдэг тоглоомыг эвлүүлж, дэлхийн шинэ дээд амжилт тогтоосон ажээ. Үүний 551232 хэсгийг 1600 оюутан 17 цагийн хугацаанд эвлүүлсэн байна.

Тэд хүмүүс, газар зүй, түүх, соёл, боловсрол, эдийн засгийг төлөөлсөн 15 x 23 метрийн харьцаатай, зургаан навч бүхий лянхуа цэцгийн зургийг эвлүүлжээ. Хагас сая гаруй жижиг хэсэг нийлээд нэг том зургийг бүтээсэн гээд бодоод үз дээ. Энэхүү эвлүүлдэг зургийн хэсэг бүр нь дангаараа чухал биш, сонирхолгүй санагдаж болох ч, хэрэв нэг хэсэг нь л байхгүй бол зураг бүрэн биш болно.

Судрууд нь зураг эвлүүлдэг тоглоомтой адил юм. Илүү олон хэсгийг нийлүүлэх тусам Бурханы төлөвлөгөөний үнэнүүд илүү сайн харагддаг. Энэхүү төлөвлөгөөг харах чадвар чинь өссөнөөр судрууд нь сонирхолтой бөгөөд амьдралд хамаатай гэдгийг ойлгох болно.

Том зургийг болон жижиг нарийн ширийн зүйлсийг харахад туслах судар судлах зөвлөгөөг өгье. Чи эдгээр хэсгийг нийлүүлэх үед судрууд дээрх та нарыг хүлээж буй гайхалтай үнэнүүдийг олж харах болно.

Сургаал: Мөнхийн үнэнүүдийг заадаг том хэсгүүд

Судрууд сайн мэдээний сургаал, зарчмуудыг заадаг. “Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд заахад, зэмлэхэд, залруулахад, зөвт байдал дотор чиглүүлэхэд тустай” (2 Тимот 3:16). Бид зөвхөн Есүс Христээр дамжуулан аврагдаж чадах учраас (Иохан 14:6-г үзнэ үү) Түүний талаар болон Түүний сургаалаас суралцах хэрэгтэй. Тиймээс Их Эзэн “Та нар Судруудыг судалдаг. . . Тэдгээр нь Намайг гэрчилдэг билээ” (Иохан 5:39) хэмээн хэлдэг.

Хүмүүс: Заадаг хичээлүүдийн өнгөлөг хэсгүүд

Судруудаас бид зуу зуун хүний талаар уншиж болно. Эдгээрээс ямар хүн нь та нарт хамгийн их таалагддаг вэ? Та нар аюул тулгарсан үед зоригтой, дуулгавартай байдаг Аммоныг хардаг байж магадгүй. Эсвэл та нар Иовын гуйвшгүй итгэл, үнэнч байдлын тухай боддог байх.

Та нар эзэнтэйгээ ярьдаг илжигний тухай уншиж байсан уу (Тооллого 22-ыг үзнэ үү)? Эсвэл уучлагдахын тулд хаант улсаа хүртэл өгөхөд бэлэн байсан ёс бус хааны тухай уншиж байсан уу (Алма 22-ыг үзнэ үү)? Эсвэл бүхэл хотынхонд ариун журамтай хүн гэж танигдсан эмэгтэйн тухай уншиж байсан уу (Рут 1–4-ийг үзнэ үү)?

Судрууд дээр муу хүмүүс бас гардаг. Та нар тэднээс болон тэдний хийсэн буруу сонголтоос юу сурч болох вэ?

Судруудад гарч буй хүмүүст анхаарал хандуулж, тэд хэрхэн сайн жишээнүүдийг дагаж, муу алдаануудаас

зайлсхийж болохыг өөрөөсөө асуу. Тэдний амьдралыг харуулдаг хэсгүүд нь эвлүүддэг тоглоомын хамгийн өнгөлөг хэсгүүд байдаг. Тэдний туршлагууд нь сайн мэдээний зарчмуудыг санах гайхалтай арга замууд юм шүү!

Бэлгэдэл: Далд хэсгүүдийг ил гаргах нь

Судрууд заримдаа сайн мэдээний зарчмуудыг заахын тулд бэлгэдэл ашигладаг. Хэрэв та нар бэлгэдлийг ойлгохгүй бол эвлүүддэг тоглоомын зарим хэсгийг олохгүй.

Сүмийн болон семинарын ангиудаас гадна судруудын удирдамж эсвэл семинар, институтын гарын авлагууд нь, дутуу байгаа хэсгүүдийг олоход тань тусална.

Жишээлбэл, Абрахамын болон Исаакийн түүх нь (Эхлэл 22-ыг үзнэ үү) гайхалтай боловч энэ нь бидний төлөөх Тэнгэрлэг Эцэгийн золиослолыг болон Аврагчийн цагаатгагч золиослолыг бэлгэддэг гэдгийг ойлгосноор илүү гүнзгий утгатай болдог (Иаков 4:5-ыг үзнэ үү).



БУРХАН БИДЭНД ХАНДАН ЯРЬДАГ

“Бид Бурхантай ярихыг хүссэн үедээ залбирдаг. Мөн Түүнийг бидэнд хандан яриасай гэж хүсэх үедээ бид судруудыг судалдаг; учир нь Түүний үгс бошиглогчдоор дамжин бидэнд ирдэг. Бид Ариун Сүнсний өдөөлтийг анхааран сонссон үед Тэрбээр бидэнд заах болно.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Роберт Д.Хэйлс, “Holy Scriptures: The Power of God unto Our Salvation,” Лиахона, 2006 оны 11-р сар, 26-27.

Ариун Сүнс: Холбодог хэсгүүдийг олох нь

Эвлүүддэг тоглоомын зарим хэсэг хоорондоо холбоотой юм шиг харагдаг ч таарахгүй байх үе байдаг. Аль хэсгүүд хоорондоо нийлдгийг харахад Сүнс танд туслах болно. Та нар залбирч, тунгаан бодсоноор Түүний тусламжийг уривал, Сүнс таны өмнө нь уншсан шүлгүүдийг одоо судалж байгаа зүйлтэй болон эдгээр сургаал нь таны амьдралтай ямар холбоотой болохыг ойлгоход тань туслах болно. Хамгийн сайндаа, та судрууд дээрх үгсээс илчлэлт авах ба мөн уншиж буй зүйлээ тунгаан бодсоноор Сүнснээс илчлэлт авах болно.

Сурсан зүйлээ хэрэглэх: Хэсгүүдийг эвлүүлэх

Хэрэв та эвлүүддэг тоглоомын хэсгүүдийг эвлүүлэхгүй бол ямар зурагтай болохыг нь харж чадахгүй. Үүнтэй адилаар, хэрэв та судруудаас сурдаг сургаал, зарчим, зарлигуудын дагуу амьдрахгүй бол тэдгээр нь танд тус болохгүй (Иохан 7:17-г үзнэ үү). Та судруудад заагддаг сайн мэдээний зарчмуудаар амьдрахыг өдөр бүр хичээвэл, таны итгэл ба гэрчлэл илүү хүчтэй болж, судраас судлах дадал хэвшил нь амьдралын тань чухал хэсэг болно. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.



САЙН МЭДЭЭН ДЭХ ЭГЧ ДҮҮС

Би сайн мэдээнээс ирэх адислалуудыг амьдралдаа мэдэрсэн учраас үүнийг найзуудтайгаа хуваалцахыг хүссэн юм.



Паола Сарахи Хернандез Круз

Би найз Лупитагаа эгч шигээ хайрладаг. Бид зургаадугаар ангидаа танилцсан бөгөөд хоёулаа сургуулийн үлээвэр найрал хөгжимд явдаг байсан. Дараа жил нь бид хоёр илүү дотно найзууд болж, бие биедээ найддаг болж эхэлсэн юм. Түүний аав нь байхгүй, ээж нь түүнд хангалттай анхаарал хандуулдаггүйгээс учирсан бэрхшээлүүдээ тэр надад ярьж билээ. Аав, ээж нь түүний амьдралд оролцдоггүй байсан учраас тэр гунигладаг байсан юм. Тэр ганцаарддаг байсан ч, би түүнтэй хамт байв.

Би Есүс Христийн сайн мэдээ бүхий гэр бүлд төрсөндөө талархдаг. Энэ нь миний олон найзад байдаггүй амар амгаланг надад өгсөөр ирсэн. Сайн мэдээ миний амьдралыг адисалсан учраас би үүнийг Лупитатай хуваалцахыг хүсэж байв.

Би түүнийг Сүмд, мөн надтай хамт мючелд ирэхэд урьсан. Тэр урилгыг минь хүлээн авч, надтай болон миний гэр бүлтэй хамт Сүмийн цуглаан, тойргийн үйл ажиллагаа зэрэгт оролцож эхлэв. Би түүнийг номлогчидтой танилцуулж, тэд түүнийг баптисм хүртэхэд урьсан юм. Тэр гэрчлэлтэй болж, мөн баптисм хүртэх талаар ээжээсээ асуухад зөвшөөрсөн байна.

Тэр Тэнгэрлэг Эцэгийг дурсан санаж, Түүний зарлигуудыг сахих гэрээ хийсэн учраас баптисмын өдөр нь маш онцгой байлаа. Тэр өдөр би түүнтэй өөрийнхөө гэрчлэлийг хуваалцаж, түүнийг зөв газраа байгаа бөгөөд Тэнгэрлэг Эцэг түүгээр бахархаж байгаа гэдгийг хэлсэн. Би Лупитад хайртай. Мөн би түүний найз байгаадаа, бас одоо сайн мэдээн дэх эгч дүүс болсондоо баяртай байна. Тэр өөрөө, мөн түүний ирээдүйн гэр бүл сайн мэдээний адислалуудыг хүртэх учраас түүний амьдрал илүү аз жаргалтай байх болно гэдгийг би мэднэ.

Лупита сайн мэдээг хуваалцах шийдвэр гаргасанд минь талархаж байгаагаа надад хэлсэн. Тэр Сүмийн цуглаанд оролцож эхэлснээс хойш амьдрал нь илүү сайжирч, мөн амар амгаланг мэдэрсэн гэдгээ бас хэлсэн юм. Энэ бол Сүнс үнэнийг түүнд баталж байгаа хэлбэр гэдгийг би мэднэ. Тэр мөн хэзээ нэгэн өдөр ариун сүмд гэрлэнэ гэж ярьдаг. Би найзаа олсондоо, мөн хамгийн үнэ цэнэтэй зүйлээ хуваалцах үедээ мэдэрдэг баяр баясгалангийн төлөө Тэнгэрлэг Эцэгтээ талархаж байна. ■

Зохиогч нь Мексикийн Мехико хотод амьдардаг.



Ахлагч
Л.Том Пэрри
Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын

Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын гишүүд
бол Есүс Христийн
онцгой гэрчүүд юм.

Би хэрхэн Ариун Сүнсээр удирдуулж чадах вэ?

Сайн мориор хүссэн
зүйлээ гүйцэлдүүлэхийн
тулд залуурдагч зөөлөн
угзрахад л хангалттай. Энэ
зөөлөн угзралт нь намуун,
зөөлөн дуу хоолойтой
адил юм.

Бид Сүнсний зөөлөн
угзралтыг хүлээн авахад
үргэлж бэлэн байх ёстой.

Хэрэв бид Ариун Сүнсний
намуухан өдөөлтүүдийг
анхааралтай сонсвол,
тэдгээр нь биднийг
Тэнгэр дэх Эцэг рүү минь
удирдах болно.

"Итгэлтэй
байдлаараа
дамжуулан
дуулгавартай
байх нь," Лиахона,
2014 оны 5-р сар,
100–103.

Ариун Сүнс

(Хялбаршуулсан)

Энгийнээр ♩ = 126-138

Үг аяыг
Жийн П.Лаулер

С A⁷ G⁷ С

1. Христ энэ дэл - хийд байх - даа ам - га - ланг ав - чир - даг А -
2. Сан - ваар - ын хү - чээр бид ги - шүүн - ээр бат - лагд - ахад А -

F Fm G⁷ С

риун Сүнс мөн - хийн най - зыг минь ил - гээ - хээ ам - ла - сан. А -
риун Сүнс бид - энд ө - гөг - дөн цаг я - магт зам - ыг заана. Би

Сaug F B Em

риун Сүнс зөө - лөн дуу - гаар би - дэнд шив - нэ - дэг. Тэр
тэр на - муун зөө - лөн дууг үр - гэлж сон - сох - сон, Түү -

A⁷ Dm G⁷ С

Бур - хан Христ хоё - рыг гэр - чилж зүрх сэт - гэл баяс - га - даг.
ний гэр - лийг да - ган дан - даа зөв сон - гол - тыг хийх - сэн.

© 2015, 1989, 1977 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.

Энэ дууг ашиг олох зорилгоор бус зөвхөн гэр орон болон Сүмийн хэрэгцээнд зориулан хувилж болно.

Энэ тэмдэглэл хуулбар бүр дээр байх ёстой.

Сайн Хоньчин

Эрин Сандэрсон

Хоньдоо маш их хайрладаг бөгөөд тэдний төлөө амиа өгөхөд ч бэлэн нэг хоньчны тухай түүхийг (сургаалт зүйрлэлийг) Есүс нэгэн өдөр ярьсан юм. Бид энэ түүхэнд гардаг хоньдтой адил юм. Хоньчин нь бидний Аврагч Есүс Христтэй адил юм. Есүсийг заримдаа Сайн Хоньчин гэдэг.

Зарим эцэг эх хүүхдүүдээ Аврагч дээр авчрахад Тэр хайраа харуулсан. Тэр “Хүүхдүүдийг над руу ирэхийг зөвшөөр, Тэднийг бүү хорь: Учир нь Бурханы хаанчлал бол тэдэн шиг хүмүүсийнх юм” (Лук 18:16) хэмээн хэлжээ. Тэрээр тэднийг гартаа тэврэн, адислав.

Нүдээ аниад, Есүс гараас тань барьж, адислал өгч байна хэмээн төсөөлөн бод. Та нар Есүсийн талаар сурч мэдэх юм уу, бодох үед Түүний хайрыг мэдэрч чадна. Ариун Сүнс та нарт Сайн Хоньчин—Есүс Христийн хайрыг мэдрэхэд тусалдаг. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.



ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭХ

зөвшөөр—боломж олго

тэднийг бүү хорь—тэднийг
бүү зогсоо

ГЭР БҮЛИЙН ЯРИЛЦЛАГА

Иохан 10:1-5, 11-16-г унш. Есүс ямар байдлаараа хоньчинтой адил болох талаар жагсаалт гаргаж, Аврагчийн хайрыг мэдэрсэн үеийнхээ тухай ярилц.

Дуу: “Тэр сайхан түүхийг уншихаараа би” (Сүмийн дуулал болон хүүхдийн дуу, 60)

Судрууд: Лук 18:15–17; Иохан 10:1–5, 11–16

Видео бичлэгүүд: “Бяцхан хүүхдүүдийг над руу ирэхийг зөвшөөр”, “Бид бяцхан хүүхэд адил болох ёстой гэж Есүс заав” (Biblevideos.org)

БИДНИЙ САЙН ХОНЬЧИН

Энэ зургийг холдуул. Цагаан шугамнуудын дагуу үүнийг сэнс шиг нугал. Дараа нь үүнийг дэлгээд; баруун, зүүн талаас нь хар. Та нар Сайн Хоньчны хайрыг хэрхэн мэдэрдэг вэ?

СУДРЫН ЗӨВЛӨГӨӨ

Үйл явдал юм уу сургаал бүрийг аль номонд байдгийг харуулдаг "Сайн мэ-дээнүүд" гэсэн хүснэгтийг судруудын удирдамжаас олоорой. Зөвхөн Иоханы ном л Сайн Хоньчны тухай заадаг. Матай, Марк, Лук гэсэн гурван ном Есүс хүүхдүүдийг адисалж байгааг өгүүлдэг.



БИДНИЙ ХУУДАС



Би баптисм хүртэх өдрөө тэсэн ядан хүлээж байлаа. Өнгөрсөн жил намайг найман нас хүрэхэд аав, ээж, гэр бүлийнхэн болон найзууд маань миний баптисм дээр байсан. Энэ бол миний хувьд агуу үйл явдал байв. Баптисм хүртэж, Есүс Христийн шавь болох миний шийдвэрийг тэнгэрт бас тэмдэглэж байгааг мэдэх үнэхээр гайхалтай сайхан байсан. Бид баптисм хүртэхдээ Бурхантай гэрээ байгуулдаг. Энэ нь зөв, зохистой шийдвэр байсан учраас Тэр баяртай байгаа гэдгийг би мэднэ.

Сариа З., 8 настай, Гондурас



Би Хиламаны дайчдыг футболк дээрээ зурсан. Би яг тэдэн шиг итгэлтэй, зоригтой, Бурханы зарлигуудад дуулгавартай болмоор байна.

З.Юэн, 6 настай, Тайвань



Энэ бол манай гэр бүлийнхний ариун сүмийн урд авахуулсан зураг.

Шерриза Т., 8 настай, Мексик



Аав, ээж хоёр биднийг ариун сүм рүү дагуулж явахад бид дуртай байдаг. Учир нь энэ бол үзэсгэлэнтэй газар. Бид тэнд байхдаа Бурхантай илүү ойр байгаагаа мэдэрдэг.

Нифай болон Брайн В., 6 ба 9 настай, Эквадор

Сайн Хоньчин

Иохан 10:1-5, 11-16



Энэ хуудсыг зузаан юм уу картонон цаасан дээр цавуугаар наа. Дараа нь зургуудаа хайчилж, тэдгээрийг гараар урла, эсвэл цаасан хайрцгандаа хий. Дутгуйн дотор хийгээд, судрын эшлэлийг урд талд нь бич. ■



Хоньчин



Хулгайч



*Та liahona.lds.org
хаягаар орж,
илүү олон хувийг
хэвлэн авч болно.*

Стивэний тэмдэглэсэн анхны ирээдүйн аавуудын баяр

Кэлли Жорж Пурчил

Бодит түүхээс сэдэвлэв

Хүүхдийн хэсгийн хүүхдүүд шинэ дуу сурахаар давтаж байхад, Стивэн зангиагаа эрүүндээ тултал хуйлчихсан сууж байлаа. Түүнд энэ дуут дуулахсан гэсэн шинж огт үгүй байв.

Манай аав гэр бүлийг минь удирддаг . . .

Стивэн цонхоор гадагшаа харав, мөн тааз руу харлаа. Тэр сандал дээрээ маш их займчиж, бараг л бүжиглэж байсан юм. Тэр хүсээд ч дуулж чадахгүй байв. Ямар нэг том, бас таагүй зүйл хоолойд нь тээглээд байлаа. Хүүхдийн хэсгийн хүүхдүүд дуулсаар шинэ үгсийг мөр мөрөөр нь сурч байсан юм.

Зөв зүйл бүхэнд мэргэн ухааны гэрлээр;

My father's good to me ("Fathers," Children's Songbook, 209).

Стивэн гарт нь хэн нэгэн хүрэхийг мэдрэв. Хүүхдийн хэсгийн өрөөний хаалгаар чимээгүйхэн харж байсан ээж нь түүний гарас зөөлөн хөтөлж, дагуулан гарлаа. Ээж нь түүнийг аваад, коридорт гарав. Найзуудаасаа болон Хүүхдийн хэсгээсээ холдсоны дараа Стивэн нулимсаа барьж чадсангүй. Ээж нь түүнийг чанга гэгч нь тэврэв.

“Бачимдаад хэрэггүй дээ” гэж ээж нь хэлээд, нурууг нь илэв. “Би



энэ дуут сонсох, бас дуулах хэцүү гэдгийг мэднэ.”

Стивэн толгой дохиод, нүдээ арчив. “Надад аав байхгүй учраас би аавуудын өдрөөр дуулмааргүй байна.” Стивэний нүд хорсож, тэр уруулаа хазав. “Би түүнийг дахин аав гэж дуудмааргүй байна. Би түүнийг ойрд хараагүй, тэгээд ч тэр миний аав байхыг хүсдэггүй.”

Стивэн уйлахгүй гэж маш их хичээсэн боловч тэдний дуулж байгаа нь сонсогдсоор байлаа. Энэ дуу түүний сэтгэлийг шархлуулж байсан юм. Яг л Стивэний аавынх нь шинэ эхнэр түүнийг Стивэнтэй болон ахтай нь дахин уулзуулахгүй байхаар шийдсэн гэж хэлэх үед мэдэрсэн шиг л сэтгэл нь шархалж байлаа.

Ээж нь түүнийг дахин тэврэхэд, Стивэн сүүлийн хэдэн дусал нулимсаа цамцан дээрээ унагав. “Би Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчтэй ярилцана. Чи хүсэхгүй байвал дуулах шаардлагагүй. Гэхдээ надад нэг санаа байна” гээд, ээж нь түүний нүд рүү эгцлэн харлаа. “Энэ жил бид аавуудын баярыг тэмдэглэхгүй, харин *ирээдүйн* аавуудын баярыг тэмдэглэе!” Ээж нь инээмсэглэж, Стивэн гайхсан янзтай харав.

“Юу гэнэ ээ? Юу тэмдэглэнэ гэнэ ээ?”

“Бид ирээдүйн аавуудын баярыг буюу чиний ах, та хоёрын

хэзээ нэгэн цагт гайхалтай аавууд болох тэр өдрийг тэмдэглэнэ. Бид бэлэг, бялуу, бас чиний дуртай ундааг авна!”

Ээж нь түүний духан дээр үнсээд, хуниралдсан зангиаг нь засахаар оролдов. “Стивэн, би чамайг *гайхалтай* аав болно гэдгийг хараад л мэдэж байна. Яагаад гэвэл, чи хүүхдүүдтэйгээ юу хийхээ бодож, мөн ямар аав болохоо төлөвлөөд эхэлчихсэн байна.”

Стивэн энэ талаар бодох тусам улам бүр инээмсэглэсээр байлаа. Тэр ээжийгээ тэвэрч, илүү өөдрөг байдалтай Хүүхдийн хэсэгтээ буцаж оров.

Хоёр долоо хоногийн дараа Стивэн толины өмнө зогсоод, зүүсэн янзын гоё шинэ эрвээхэй зангиагаа заслаа. Ээж нь үүнийг түүнд анхны ирээдүйн аавуудын баярыг тэмдэглэсэн тэр өглөө өгсөн юм! Стивэн судруудаа бариад, сүм рүү явахаар хаалга руу явлаа.

Тэр ээж рүүгээ хараад, инээмсэглэв.

“Аавуудын баярын мэнд хүргэе, ээж ээ.”

Ээж нь инээмсэглэснээ, “Ирээдүйн аавуудын баярын мэнд хүргэе, Стивэн” гэлээ. ■

Зохиогч нь Австралийн Квинслэндэд амьдардаг.



ЗОРИЛГОТОЙ ТӨЛӨВЛӨ

“Та нарт өөрсдийн нас, нөхцөл байдлыг үл харгалзан **амьдралаа зорилготойгоор төлөвлөхийг** анхаа-

руулж байна.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Ирцгээ Бурханы хөвгүүд та нар,” *Лиахона*, 2013 оны 5-р сар, 67.



Миагийн гэрчлэл



Амелиа Хоокинс

Бодит түүхээс сэдэвлэв

“Ариун Сүнс намуухан зөөлөн дуу хоолойгоор шивнэдэг. Тэр Бурхан, Христ хоёрыг гэрчилж, мөн бидний зүрх сэтгэлийг баясгадаг” (Children’s Songbook, 105).

Миaгийн унтах цаг өнгөрсөн ч, тэр орондоо ороогүй байв. Тэр өрөөнийхөө шалан дээр суугаад, Дувал эгчийн Хүүхдийн хэсэгт уншиж өгсөн зүйлийн тухай бодож байлаа: “Эрэгтэй, эмэгтэй хүмүүс бусдын гэрэлд найдах боломжгүй цаг үе ирэх болно.”¹

“Гэрчлэл нь бидний доторх гэрэл гэсэн үг юм” гэж Дувал эгч тайлбарлажээ. “Бид бүгдэд өөрсдийн гэрэл байх ёстой. Тэгснээр амьдрал хэцүү болж, Сатан биднийг уруу татах үед бид хүчтэй байж чадна.”

Миa толгойгоороо ороо налав. “Би сайн мэдээ үнэн гэсэн гэрчлэлтэй болмоор байна” гэж тэр бодлоо. Гэхдээ яаж гэрчлэлтэй болдог юм бол? Залбирал нь гэрчлэлтэй болохын нэг хэсэг гэдгийг тэр мэдэж байв.

“Би залбирна аа” гэж тэр шийдлээ. Тэр залбирч, Сүм үнэн гэдгийг мэдрүүлэх ямар нэгэн зүйл тохиолдох хүртэл үргэлжлүүлэхээр шийдсэн юм. Шаардлагатай бол тэр шөнөжингөө залбирсан ч чадахаар байв!

Тэр өвдөг сөгдөв. Тэгээд тэр “Хайрт Тэнгэрлэг Эцэг минь, би Сүм үнэн эсэхийг мэдэхийг хүсэж

байна. Үүнийг би зүрх сэтгэлдээ мэдрэмээр байна” гэж шивнэв.

Миa тэгээд хүлээлээ. Тэр залбирах үедээ мэдрэдэг намуун зөөлөн мэдрэмжээс өөр юу ч мэдрэсэнгүй. Тэр юуг нь буруу хийсэн юм бол? Түүний гэрчлэл хаана байгаа юм бол?

Түүнийг өвдөг сөхрөөд, нэлээн удаж байтал өрөөнийх нь хаалга бага зэрэг онгойж, аав нь шагайв.

“Би хаалганы чинь завсраар гэрэлтэй байхыг харлаа” гэж аав нь хэлэв. “Чи дахиад юм уншиж байгаа юм уу?” Тэгээд тэр Миагийн хацран дээрх нулимсыг харав. Тэр өвдөглөн суугаад, охиноо тэврэлээ. “Юу болоо вэ?”

Тэр хэсэг зуур чимээгүй байв. Тэгээд тэр “Аав аа, та яаж гэрчлэлтэй болдог вэ?” гэж асуув.

Аав нь түүнийг улам чанга тэврэв. “Энэ чинь их сайн асуулт байна. Гэрчлэлтэй болохыг хүснэ гэдэг нь хамгийн түрүүнд хийх зүйлсийн нэг юм.”

Миагийн хоолойд тээглэж байсан юм алга болох шиг болохыг тэр мэдрэв.

“Ерөнхийдөө нэг удаа залбираад, гэрчлэлтэй болчихдоггүй. Чи гэрчлэлтэй байсан ч гэсэн үүнийгээ заавал тордож байх хэрэгтэй.”

“Гэхдээ гэрчлэл хаанаас ирдэг юм бол?” гэж Миa асуув.

“Гэрчлэл Ариун Сүнснээс ирдэг” гэж аав нь хэлжээ. “Чи гэр бүлийн үдшийн үеэр, эсвэл сүм дээр байхдаа дулаан, бас сайхан мэдрэмжийг мэдрч байсан уу?”

Миa энэ тухай бодов. “Сургууль эхлэхээс өмнө та надад онцгой адислал өгөхөд надад сайхан мэдрэмж төрсөн.” Тэр дахин бодлоо. “Би ерөнхийлөгч Монсонг Ерөнхий чуулган дээр ярихыг сонсоод, гоё дулаан зүйлийг мэдрэдэг. Би найзууддаа найрсаг хандах үед, эсвэл судруудыг унших үедээ бас сайхан мэдрэмж мэдрэдэг.”

Аав инээв. “Ариун Сүнс тэдгээр мэдрэмжээр дамжуулан чамтай ярьж байгаа юм. Чамайг зөв зүйл хийхэд, эсвэл үнэн зүйлийг сонсох үед Тэр эдгээр мэдрэмжийг чамд өгдөг.”

“Би одоо халуун дулаан мэдрэмжийг, бас аз жаргалыг мэдрч байна” гэж Миa хэлжээ. “Энэ Ариун Сүнс мөн үү?”

Аав нь түүнийг дахин тэврэв. “Тийм ээ. Бидний ярьж байгаа зүйл үнэн гэдгийг Тэр чамд хэлж байна. Хүн ингэж л гэрчлэлтэй болдог юм.”

Дараа нь Миa орондоо ороод, өөрийгөө бүтэн гэрчлэлтэй болсон гэж бодоогүй ч, аавынх нь хэлсэн зүйл үнэн гэсэн сайхан, дулаан мэдрэмжийг мэдрэчээ. Энэ мэдрэмж бол эхлэл гэдгийг тэр мэдсэн.

Миa дулаан хөнжилдөө ороод, нүдээ анив. Тэр яг унтахынхаа өмнө, “Тэнгэрлэг Эцэг минь, гэрчлэлтэй болоход минь тусалсанд баярлалаа. Аавыг минь өгсөнд баярлалаа” гэж шивнэлээ. ■

Зохиогч нь АНУ-ын Миссурид амьдардаг.

ЭШЛЭЛ

1. Орсон Ф.Витни, *Life of Heber C. Kimball* (1967), 450.

Аравны нэгээр баригдсан өргөө

Жэнил Виллиамс



Энэ бол Жак. Эдгээр
жингэнэж байгаа зоос
бол Жакийнх. Энэ бол
Жакийн аравны нэг,
10 хувь.

Жакийг аравны нэг,
10 хувиа өгөхөд нь
түүнтэй гар барьсан
энэ хүн бол бишоп.





Энэ бол “ариун сүм барьцгаая” хэмээн баяр хөөртэй, залбиралтайгаар хэлсэн бошиглогч юм. Ариун сүм барих энэ аравны нэгийн мөнгө Жакийг аравны нэг буюу 10 хувиа өгөхөд түүнтэй гар барьсан бишопоос ирсэн билээ.



Энэ бол гялалзсан, цагаан, гэрлээр дүүрэн Их Эзэний өргөө болох ариун сүм юм.

Энэ бол Жакийг аравны нэг буюу 10 хувиа өгөхөд түүнтэй гар барьсан бишопоос ирсэн аравны нэгийн мөнгөөр, “ариун сүм барьцгаая” хэмээн бошиглогч хэлсэн учраас баригдсан өргөө юм.



Энэ бол гялалзсан, ариун цагаан сүмд орж, Бурханы
мэлмийд гэр бүлтэйгээ лацдан холбогдох үе дэх
Жакийн нүүр дүүрэн, баяр хөөртэй инээмсэглэл. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

Жакийн аравны нэг хаана байна вэ?

Жингэнэдэг, аравны нэгийн найман зоосоо олоход нь Жакад туслаарай!





**Ерөнхийлөгч
Бойд К.Пакэр**

Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын ерөнхийлөгч

ҮҮНИЙГЭЭ ОРХИ

*Найзын минь амьдрал нуран унав.
Тэр хайртай эхнэрээсээ хагацсан юм.*

Хэрэв та сэтгэл зовнил, уй гашуу юм уу, ичгүүр, атаархлаас, эсвэл сэтгэлээр унах, өөрийгөө буруутгах явдлаас, эсвэл зөвтгөх байдлаас болж зовж байгаа бол олон жилийн өмнө нэгэн патриархын заасан энэ хичээлийг эргэцүүлэн бодоод үзээрэй. Тэрээр миний мэдэх хүмүүсээс хамгийн гэгээлэг нь байлаа. . . .

Тэр жижигхэн газарт өссөн бөгөөд амжилтанд хүрэхийг хүсдэг байв. Тэр боловсрол эзэмших гэж чармайж байлаа.

Тэр залуухан сайхан бүсгүйтэй гэрлэж, тэр үед амьдралынх нь бүх зүйл сайхан байсан ажээ. Тэр сайн цалинтай, ирээдүйтэй ажил хийдэг байжээ. Тэд бие биедээ үнэхээр хайртай байсан бөгөөд анхныхаа үрийн зулайг үнэрлэхээр хүлээж байв.

“Тэтэл хүүхэд төрөх орой нь түвэгтэй байдал үүсчээ. Цорын ганц эмч нь хөдөө хаа нэгтээ өвчтэй хүн асрахаар явчихсан байж. . . .

Эцэст нь арай гэж эмч ирлээ. Тэр яаралтай тусламж үзүүлж, шуурхай ажиллав. Удалгүй бүх зүйл хэвийн боллоо. Хүүхэд ч төрж, байдал хэвийн болов.

Гэтэл хэдэн өдрийн дараа залуу ээж тэр орой эмчийн асарч байсан нөгөө айлаас дамжин ирсэн халдвараас болж нас баржээ.



Жоны амьдрал нуран унав. Бүх юм сайхан байхаа больж, бүтд буруугаар эргэв. Тэр хайртай эхнэрээсээ хагацав. Тэр хүүхдээ асарч, хажуугаар нь ажлаа хийх ямар ч боломжгүй байлаа.

Өдөр хоногууд өнгөрөх тусам тэр уй гашууд улам их автжээ. “Тэр эмч ажлаа хийх ёсгүй” гэж тэр хэлдэг байв. “Тэр миний эхнэрт халдвар тараасан. Хэрэв тэр болгоомжтой байсансан бол эхнэр минь өнөөдөр амьд байх байсан” гэж тэр хэлдэг байлаа.

Тэрээр бусад юмны тухай бараг бодохоо больж, уй гашуугаасаа болоод уурлан хорсдог болов. . . .

Нэг орой нэг хүн хаалгыг нь тогшжээ. Бяцхан охин энгийнээр “Аав таныг манайд ирээч гэж байна. Тэр тантай ярилцмаар байна гэсэн” гэлээ.

“Аав” гэдэг нь гадасны ерөнхийлөгч байлаа. . . .

Сайхь сүнслэг хоньчин сүргээ

харж ханддаг байсан бөгөөд түүнд нэг зүйл хэлэхийг хүсжээ.

Тэрхүү мэргэн үйлчлэгчийн өгсөн зөвлөгөө нь ердөө л: “Жон, үүнийгээ орхи. Чиний хийх ямар ч зүйл эхнэрийг чинь буцааж авчрахгүй. Чи юу ч хийлээ гэсэн, энэ нь байдлыг зөвхөн муутгана. Жон, үүнийгээ орхи” гэсэн тун энгийн зөвлөгөө байлаа. . . .

Тэр биеэ барихын тулд тэмцэлдэж байв. Эцэст нь тэрээр асуудлын гол нь юу ч байсан хамаагүй, харин зөвхөн дуулгавартай байх болно гэж шийджээ.

Дуулгавартай байдал бол хүчирхэг сүнслэг эм юм. Энэ нь бараг бүх өвчинг эдгээдэг.

Тэр өнөөх мэргэн, сүнслэг удирдагчийнхаа зөвлөгөөг дагахаар шийдэв. Тэр үүнийгээ орхиж чадсан юм.

Тэр надад “Би түүнийг дэндүү их ажиллаад бага цалин авдаг, нэг өвчтөнөөс нөгөө өвчтөн рүү гүйсэн, эм тариа нь хүрэлцээ муутай, эмнэлэггүй, цөөхөн багаж хэрэгсэлтэй, хөдөөний хөөрхийлөлтэй эмч байсан гэдгийг нас дээр гарсан хойноо л ойлгосон юм.

“Хоёр хүний амьдрал үхлийн ирмэг дээр байх мөчид тэрээр ирж, шуурхай ажилласан шүү дээ.

“Би нас дээр гарсан хойноо л ойлголоо. Би өөрийнхөө болон бусдын амьдралыг нураах байсан байх” хэмээн тэр давтан хэлэв.

Тэрээр “Жон, үүнийгээ орхи” хэмээн энгийнээр зөвлөсөн ухаалаг, сүнслэг удирдагчийнхаа төлөө Их Эзэнд олон удаа өвдөг сөгдөн, талархлаа илэрхийлжээ. ■

*“Balm of Gilead,” Ensign, 1987 оны
11-р сар, 17–18.*

ОЙЛГОЛТ



Амьдралд яаж хандах нь чухал вэ?

"Энэ амьдрал нь Бурхантай уулзахаар бэлтгэх цаг үе билээ. Бид аз жаргалтай, баяр хөөртэй хүмүүс. Бид хошин шогийн мэдрэмжтэй бөгөөд гэр бүл, найз нөхөдтэйгөө цагийг өнгөрөөхийг эрмэлздэг. Гэхдээ бидний сонголт болон хэрхэн амьдарч байгаагийн үндсэн зорилго илүү чухал гэдгийг бид санах ёстой."

Энэ дугаарт

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

ИХ ЭЗЭНИЙ БАТАЛГААНУУДАД ИТГЭХ НЬ

Бид бэрхшээлүүдээсээ үргэлж чөлөөлөгдөхгүй ч гэсэн, Их Эзэн биднийг мэдэж байгаа бөгөөд бэрхшээл дундуур бидэнд туслахад бэлэн байгаа гэсэн баталгааг үргэлж авч чадна.



42-р
хуудас

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ



56-р
хуудас

Хэрвээ ... тэгвэл яах вэ?

Номлолг үйлчлэх талаарх асуултууд

Сайн мэдээний талаар сайн мэдэхгүй, гэрчлэл тань хангалттай хүчтэй биш, мөн өөрийгөө дэндүү ичимхий гэж санаа зовж байна уу? Номлолын өмнө нийтлэг асуудаг асуултууд болон санаа зовоосон зүйлүүдийн хариултуудыг эндээс олоорой.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Миагийн гэрчлэл

Миа сайн мэдээний талаар хувийн гэрчлэлтэй болохыг хүсэж байсан юм. Тэр хэрхэн гэрчлэлтэй болсныг олж мэд!



74-р
хуудас